




Чанга хууль ядмаг зүтгэл



Did you know SAAB 340 is the most selling 30-seater ever built?



Saab 340B



eznis airways is the **leading** Mongolian regional airline both in passenger numbers and fleet size. We offer **most destinations** with the **highest frequency**. We are proud to announce that we partner with **Lufthansa Technik AG**, one of the best airline maintenance and repair service providers in the world to ensure the **safest flights**. We are also proud to be the partner of choice of **ANA** (All Nippon Airways) of Japan, one of the largest airlines in the world to bring the **best global aviation practices** in Mongolia.

Fly Smart - Fly **ez!**

8 Zovkhis Building, 1st floor, Seoul street 21, Sukhbaatar district,
Ulaanbaatar 14251, Mongolia
Tel: +(976-11) 333311, Fax: +(976-11) 331514, E-mail: info@eznis.com
www.eznisairways.com

+(976-11) **333311**
CALL & RESERVATION CENTER

Challenger®

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХҮЧИРХЭГ ХАМТРАГЧ

MARCH

APRIL
MAY



JUNE
JULY

SEPTEMBER
OCTOBER

“CHALLENGER” нь цаг агаарын эрс тэс өөрчлөлттэй, хүйтэн сэрүүн бүс нутгуудад ажиллахаар бүтээгдсэн байдаг бөгөөд Монгол улсын зах зээлд “Вагнер Ази Тоног Төхөөрөмж” ХХК анхлан таниулаад удаагүй байна. Хүнд машин, тоног төхөөрөмжийн худалдааны салбарт зөвхөн “оруулж ирээд – зарах” гэдэг ойлголт орчин цагт алга болж байна. Машин механизмаа дагаад түүний сэлбэгийн хангамж - агуулах, засварын үйлчилгээ, засварын төв, түүнийг ажиллуулах операторын сургалт, дуудлагын засварын инженерүүд, мөн санхүүгийн асуудлыг шийдвэрлэх лизингийн үйл ажиллагаа зэрэг бүгд багтсан, таны бизнесийг бүрэн дүүрэн дэмжих ОРЧИН ЦАГИЙН ХУДАЛДААГ бид ХАА -н салбарынханд санал болгож байна.

Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК
Баянгол дүүрэг, Баруун Үйлдвэр-133, Ш/х-26, Улаанбаатар-16030, Монгол Улс
Утас: 976-687588, 99013673 Факс: 976-11-687587
www.wagnerasia.com



Ногоон хөгжлийн шөлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр 9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал 8800 6228

Англи хэлний редактор:
Terrence Edwards

Орчуулагч: Б.Үүрийнгуяа

Сэтгүүлч:
Х.Хулан
Э.Зоригт
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Б.Ууганбаяр
Б.Энхмарт

Дизайнер, Вэб мастер:
Ш.Оюундарь

Маркетингийн менежер:
Д.Бариянжав 8880 0825
С.Жавхлан 99620780
Б.Энхцэцэг 9901 5476

Борлуулалтын менежер:
С.Цэнд-Аюуш

Хаяг:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23
Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Зиг заг" автосервис
"Минж плаза"
"Алтангүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall"

MONGOLIAN ECONOMY

14 хоног тутамд
танг хүрнэ

ШИНЭ УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

ЗАХИАЛГЫГ:


"Монгол шуудан"
"Түгээмэл шуудан"
"Sky" шуудан
"UB Post" шуудангийн салбарууд болон
сэтгүүлийн редакцид авч байна.

Уул уурхайн тэсрэлт дундах бохир баячууд ба үндсэрхэг үзэл



Монгол оронд олон хүн ирээдүйгээс эмээж амьдардаг. Улс төрийн хүрээний авлигал өргөн дэлгэрч, цөөн хэдэн томчуулын жинтэй нөлөө эдийн засаг болон төрд зонхилно.

Увидаст Маестро



Танай Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуягтай уулзсан тэр азтай учралаас үүдэлтэй. Бид Давосын уулзалтын үеэр анх танилцсан юм.

Жижгээс том руу



Дэлхийн хөгжлийн галт тэрэгнээс холоо хоцорчихоод “хүүе хүлээгээч” хэмээн хий дэмий орилохгүйн тулд монголчууд галт тэрэгний зогсоол дээр зөв цагтаа, зөв тасалбараа бариад зогсож байх хэрэгтэй аж.

Эдийн засаг

- 8 “Монголын эдийн засгийн чуулган-2012”
- 9 Ил тод, иргэдийн хяналтыг сайжруулах сайхан зорилт
- 11 Чанга хууль ядмаг зүтгэл
- 13 Уул уурхайн тэсрэлт дундах бохир баячууд ба үндсэрхэг үзэл
- 16 Увидаст Маестро
- 19 Баруун хөрш маань Бар болох уу?

Ногоон эдийн засаг

- 21 Жижгээс том руу
- 22 Энгийн бүхэн ээлтэй

Уул уурхай

- 24 Хүлээлт буюу “Хэлсэндээ шүү”
- 25 Төрөлжиж чадаагүй эдийн засагт үлэмж орлого тогтохгүй
- 27 Монгол Улс баялгийн орлогоо хэрхэн зөв удирдаж сурах вэ?
- 30 Хөгжлийн хөшүүрэг

Бизнес

- 32 Улаанбаатарын хөгжил хаашаа явна вэ?
- 34 Нийгмийн хариуцлага нь их ашгийг бий болгоно
- 36 Энэ салбар энэрэнгүй, үнэнч байхыг шаарддаг
- 38 “Mongolian Economy” нэг нас хүрлээ
- 40 Эх орны хөвгүүд
- 43 Ирээдүйн аав Та эрүүл байж чадаж байна уу
- 44 Бизнес эрхлэгчдийн 11 нийтлэг алдаа
- 45 Уншихгүй бол сэтгэхгүй

Энгийн бүхэн ээлтэй



Өдөржин шөнөжин эвдэрсэн крантнаас дуслах ус, энд тэндгүй хөглөрөн агаар тэнгэрт хөөрөх хог хаягдал, уулын барааг харагдуулахгүй бүрхсэн утаа униар юуг өгүүлнэ вэ?

Хүлээлт буюу “Хэлсэндээ шүү”



Уул уурхайгүйгээр Монголын маргаашийг төсөөлөөд үзэх үү. Хамгийн түрүүнд төсвийн орлого ганхаж, төрийн сан хоосрох болов уу.

Эх орны хөвгүүд



Гурван цэрэг Монгол Улсын төрийн далбааг хүндэтгэлтэйгээр барьсаар 015 дугаар ангийн талбайд гарч ирэв. Энэ үеэр төрийн дуулал эгшиглэх аж. Эгнэн жагссан цэргүүд төрийн далбаандаа хүндэтгэл үзүүлэн төрийн далбаа мандлаа.



Осака хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар байгуулагдлаа. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн түүхийн хуудсыг баяжуулах Осака хотод энэ сарын 14-нд Монгол Улсын Ерөнхий консулын газрын нээлт боллоо.

Засгийн газрын хуралдаанаар дотоодын зах зээлийг хамгаалах, махны хангамжийг тогтворжуулах зорилгоор махны экспортыг 2012 оны долдугаар сарын 1-ний өдөр хүртэл түр хязгаарлах шийдвэр гаргав. Харин гахай, шувууны мах, загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг нэмэгдүүлэхийг ХХААХУ-ийн сайдад даалгажээ.

УИХ-ын гишүүн С.Эрдэнэ, Г.Баярсайхан нар ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн төсөл санаачилж, УИХ-ын даргад өргөн барилаа. Уг хууль батлагдвал 1990-1994 оны нийгмийн шилжилтийн үед олон үйлдвэр, завод хаагдсанаас болж ажилгүй болсон 200 мянга гаруй иргэний ажилласан жилийг нь нөхөн тооцож, 1995-2000 онд ажил хийгээгүй 700 гаруй мянган иргэн тэтгэврийн даатгалд хамрагдах боломжтой болох юм байна. Ингэснээр иргэд ажилгүй байх үеийнхээ цалингийн доод хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын 10

хувийн шимтгэлийг нөхөн төлнө гэсэн үг юм.

Улсын дээд шүүх энэ сарын 12-нд Иргэний зориг-Ногоон нам гэх шинэ нэрийг, мөн Эх орончдын нэгдсэн намыг улсын бүтгэлд бүртгэлээ. Ийнхүү Монгол улс төрийн 21 намтай боллоо.

Эдийн засаг

Хоёр сар орчмын өмнө 270 орчим төгрөгөөр нэмэгдсэн шатахууны үнэ үе шаттай буусаар Олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдөр 50 төгрөгөөр бууж хуучин хэвэндээ орлоо. Үүнтэй холбоотойгоор МҮЭХ-ынхон хэвлэлийн хурал зарлаж, Гурван талт хэлэлцээрийн үр дүн гарлаа гэдгийг онцолсон юм. Гэхдээ үнийн бууралт удаан хадгалагдахгүй болов уу гэсэн айдас иргэд, олон нийтэд байгааг МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар хэллээ.

“Мишээл экспо”-д энэ сарын 15-19-нд “Барилга экспо 2012” үзэсгэлэн, худалдааг зохион байгуулахаар болоод байна. Үзэсгэлэн, худалдаанд барилгын материалын үйлдвэрлэл, импорт, худалдаа эрхлэгчид, барилга орон сууцны захиалга авч буй байгууллагууд болон үл хөдлөх хөрөнгийн зуучлагч аж ахуйн нэгжүүд оролцох юм байна. Түүнчлэн барилгын засвар үйлчилгээ, засал чимэглэл, интерьер, даатгалын компаниуд ч оролцох аж. Уг үзэсгэлэн хүн амыг орон сууцжуулж, барилгын салбарт хэрэгцээт шинэ техник технологийг танилцуулах, ард иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангах, зах зээлийг өргөжүүлэх талаар цогц мэдээлэл өгч, хооронд

нь холбох зорилготой юм.

Нийслэлийн автозамын газраас энэ жил Яармагийн гүүр- Нисэхийн товчоо, Сонсголонгийн уулзвараас Яармагийн товчоо хүртэл 13.7 км замыг улсын хөрөнгөөр барихаар болсон байна. Эдгээр замыг нэг чиглэлдээ гурван эгнээ бүхий зургаан эгнээтэй болгох аж. Мөн Нисэхийн товчоо- Биокомбанит-Шувуун фабрик чиглэлийн 22.5 км авто замд өргөтгөл шинэчлэл хийж, бетон зам барих ажлын зураг төсөл дуусах шатандаа оржээ. Түүнчлэн нийслэлийн хөрөнгө оруулалтаар “Хүчит шонхор” захаас Баянхошууны ам хүртэл 1.6 км зам шинээр барихаар төлөвлөөд байгаа аж. Замын ажил ирэх сарын дундуур эхлэх бөгөөд дээр нь өмнөх онд барьж дуусгаагүй замын арван ажлыг эхлэх юм байна. Тухайлбал, ТЭЦ IV –ийн өмнөх 6.4 км, 22-ын товчоо чиглэлийн 10.6 км, Ажилчны гудамж 3.5 км, Сансарын шатахуун түгээх станцаас Дамбадаржаа хүртэл 6.7 км, Сансарын тунелийн шинэчлэл, Залуучуудын өргөн чөлөөний 0.9 км замын ажлыг энэ намар хүлээлгэж өгөх аж.

Монгол Улсын өнцөг



булан бүрээс анх удаагаа улсын шилдэг малчнаар шалгарсан эмэгтэйчүүдийг тодрууллаа. Өнөөдөр нийт малчдын 45 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа аж. “Монгол Улсын шилдэг малчин эмэгтэй”-чүүдийг шалгаруулахдаа мал



маллагааны арга туршлага, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нутаг орныхондоо танигдаж хүндлэгдсэн байдал төдийгүй, үр хүүхэд, ач зээ нараа малч ухаанаар хүмүүжүүлж өсгөсөн хөдөлмөр зүтгэлийг голлох шалгуур үзүүлэлт болгосон байна. Энд 29-75 насны 4-13 хүүхэд төрүүлж өсгөн, 3000 хүртэл мал маллаж буй 21 бүсгүйг шалгаруулжээ.

Бизнес

МҮХАЙТ-аас “Lady Entrepreneur” буюу Монголын бизнесийн салбарт амжилттай яваа хатагтайг шалгаруулах, шагнал гардуулах үйл ажиллагаа боллоо. Уг арга хэмжээ нь 1998 оноос жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг байсан бөгөөд 2002 оноос эхлэн хоёр жилд нэг удаа зохиогддог болсон байна. Уг арга хэмжээний гол зорилго нь бизнесийн бүхий л салбарт хүч үзэж буй эмэгтэйчүүдийг тусалж дэмжих, туршлага солилцуулах аж.

Санхүүгийн зах зээл

Монгол Улсын Хөгжлийн банк болон Японы “Сумитомо Мицуй банкинг” корпорацийн хооронд харилцан ойлголцлын санамж бичигт “Сумитомо Мицуй” корпорацийн Ерөнхийлөгч Т.Китайама, Монголын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Л.Болормаа нар гарын үсэг зурлаа. Дэд бүтэц, уул уурхай, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэх, хамтран ажиллах боломж нээгдэж байгаад

талархалтай байгаагаа энэ үеэр хоёр тал илэрхийлсэн юм.

“100 мянган айл орон сууц” хөтөлбөрийн хүрээнд жилийн зургаан хувийн хүүтэй орон сууцны зээлийн журмыг Сангийн сайд Д.Хаянхярваа, ЗТБХБ-ын сайд Ц.Дашдорж, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нар гарын үсэг зурж баталлаа. Уг журамд тухайн зээлдэгч анх удаа орон сууц авахаар хүсэлт гаргасан, сард төлөх зээл, хүүгийн нийт төлбөр нь тухайн өрхийн гурван сарын орлогын 45 хувиас хэтрэхгүй байх ёстой ба санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх хэрэгтэй талаар тус тус заасан байна.

“Монгол IPO- 2012” форум энэ сарын 7-нд Улаанбаатар хотноо болж өндөрлөлөө. Лондоны хөрөнгийн бирж /ЛХБ/-ийн Олон Улсын хөгжлийн газрын дарга Т.Вирсинг тэргүүтэй гадаад,



дотоодын төлөөлөгчид энэ удаагийн форумд оролцсон юм. Монгол Улсын Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхээр ЛХБ-тэй хамтарч ажиллаж байгаа билээ. Энэхүү ажлын үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлийн тогтолцоонд зарчмын томоохон өөрчлөлт орж, шинэ үе эхэлж байгаа тул IPO хийж хөрөнгө босгох хүсэлтэй Монголын үндэсний компаниуд болон Монголын компаниудад хөрөнгө оруулах сонирхолтой

олон улсын хөрөнгө оруулагчдыг хооронд нь зуучлах зорилгоор уг форумыг зохион байгуулж байгаа хэмээн Монголын Хөрөнгийн бирж /МХБ/-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай онцоллоо.

Уул уурхай



Тавантолгойн нүүрс гуравдагч зах зээлд гарч эхэллээ. “Эрдэнэс Тавантолгой” компани болон Японы Мицүй компанийн хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагаа Японд боллоо. Мицүй компани Монголд дулааны цахилгаан станц барих, гангийн үйлдвэр байгуулахад оролцох санал тавиад байсан бөгөөд энэхүү санамж бичгийг байгуулснаар

Тавантолгойн ордоос гарах коксжих нүүрсийг худалдах, худалдан авах асуудлаар хамтран ажиллах боломжтой болж байгаа юм байна. Ингэснээр “Эрдэнэс Тавантолгой” төрийн өмчит компани нүүрсний салбарт гурав дахь зах зээлд нүүрс экспортлох боломж эрэлхийлсэн бодит яриа хэлэлцээ эхэлж байна гэж үзэж байна.


Япон

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын Япон Улсын Засгийн газрын урилгаар тус улсад хийж байгаа албан ёсны айлчлал 2012 оны гуравдугаар сарын 12-нд албан ёсоор эхэллээ. Монгол Улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх жилийн хүрээнд хэрэгжиж буй өндөр дээд хэмжээний энэхүү айлчлал нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны анхны гадаад айлчлал юм.

Манай улс Японы Засгийн газрын хөнгөлөлтэй зээлийг өөрийн орны хөгжлийн зорилтуудтайгаа холбож үр ашигтай зарцуулах боломжийг нээсэн нэгэн чухал баримт бичигт Токио хотноо гарын үсэг зурлаа. Өөрөөр хэлбэл, Японы Олон улсын хамтын ажиллагааны банкнаас экспортын зээл авах, уул уурхай, дэд бүтэц, аж үйлдвэрийн салбарт төсөл хэрэгжүүлэх зорилгоор санхүүгийн хамтын ажиллагааг эхлүүлэх тухай Сангийн яам, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулах Харилцан ойлголцлын санамж бичигт Сангийн сайд Д.Хаянхярваа Японы төрийн банк болох Олон улсын хамтын ажиллагааны банкны ерөнхийлөгч Х.Ватанабэ нар гарын үсэг зурав. Ингэснээр манай улс Японы буцалтгүй тусламж, дэмжлэг авдаг орноос нэг шат ахиж харилцан ашигтай хөнгөлөлттэй зээл авч эдийн засгийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжтой болж байна.

<http://www.mongolianeconomy.mn>

Эдийн засаг...





Онцлох сэдэв

“Монголын эдийн засгийн чуулган-2012”

Төрийн ордны Их танхимд сонгодог хөгжим эгшиглэнэ. Хоёрдугаар давхрын зааланд Монголын уран зураачдын үзэсгэлэн гарчээ. Монголчуудын хайртай жүжигчид явж харагдана. Тухайлбал, Ардын жүжигчин Н.Сувдаа, Төрийн шагналт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров тэргүүтэй урлагийн нэрт мастеруудын төлөөлөл ажил хэрэгч хувцасласан байх юм. Гурав дахь удаагаа болж буй Монголын эдийн засгийн чуулганы үеэр тэд яах гэж байгаа юм бол. Улс орны эдийн засгийн хөгжлийн төлөө урлагийнхан санаа бодлоо уралдуулахаар ирсэн юм болов уу. Дэлхийд нэртэй хөгжмийн удирдаач ч иржээ. Бүжигчид хүн байгаль хоёр хүйн холбоотойг харуулсан бүжиг бүжиж байна. Гэтэл хажуугаар нь Төрийн ордны хурлын гол танхимуудад эдийн засгийн хөгжлийн тухай ярилцсан хурлууд болж байна.

Их танхим дахь сонгодог хөгжмийн аялгуу байсхийгээд л тасалдах юм. Яагаад тасалдаад байгаа юм бол. Израилын хөгжмийн удирдаач Итай Талгам Монголын эдийн засгийн чуулганы индрээс улс орны, аливаа нэгэн байгууллагын удирдлагыг симфони хөгжим удирдахтай харьцуулан илтгэл тавьж байгаа нь энэ аж. Тэрбээр хөгжмийн удирдлагыг удирдахуйн ухаантай харьцуулан тавьдаг илтгэлээрээ дэлхийд алдартай нэгэн юм.....

Баялгийн орлогын зохистой удирдлага, эдийн засгийн төрөлжилт, ядуурал, инноваци, эрсдэл, тэтгэвэр, ногоон эдийн засаг, эрүүл мэнд, усны менежмент, нефтийн бүтээгдэхүүний хараат байдал, төсөв, авлига, үнэт зүйл, сайн засаглал, сэргээгдэх эрчим. Эдгээр нь Монголын эдийн засгийн чуулганаар хэлэлцсэн асуудлууд. Хамгийн гол нь эдийн засаг огцом өссөн ч өсөлт иргэн бүрт хүртээмжтэй байж чадаагүйд тус чуулган анхаарал хандуулахыг зорьсон. Тийм ч учраас “Хөгжилд хамтдаа” уриан дор хүртээмжтэй өсөлт, тэнцвэртэй өсөлт, ногоон өсөлт сэдвүүдийн хүрээнд төлөөлөгчид санал бодлоо хоёр өдрийн турш хуваалцсан юм. Эдийн засаг 17 хувиар өссөн дүн гарч байхад яагаад ядуурал буурахгүй байна, Голланд өвчин хэдийнэ хаалга тогшоод ороод ирсэн байхад яагаад дорвитой арга хэмжээ авахгүй байна, байгалийн зохистой удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх вэ, хүн ам нь өвчинд нэрвэгдэждууслаа, яагаад анхаарахгүй байна, байгаль орчин сүйрлээ, яагаад төрийн нэгдсэн бодлого алга байна гэсэн үндсэн асуултуудад хариу өгөхийг оролдсон хурал боллоо.

Төрийн өндөрлөгүүдээс эхлээд номын дуу сонсож буй оюутнуудын төлөөлөл өөрөөр хэлбэл, бүх түвшний 1000 орчим хүн оролцож дуу хоолойгоо хүргэлээ. Өмнөх хоёр хурлаас

ялгаатай нь эрдэмтэн судлаачдыг түлхүү оролцуулсан, сэдвийн хувьд нэлээд төрөлжүүлж, мөн урьдчилсан хэлэлцүүлгээр сэдвүүдийг ярьж, төрөлжүүлж, илүү олон хүний саналыг сонссоноороо онцлогтой боллоо гэж зохион байгуулагчдын зүгээс мэдээлэл хийсэн. Нөгөө талаас төрийн байгууллагууд, УИХ, Засгийн газрын гишүүдийг түлхүү оролцуулах шаардлагатай гэсэн олон санал гарсан. Улс орныхоо хөгжлийн төлөө өөрсдийн бодсон санаснаа хэлсэн тэрхүү үнэтэй санал санаачлагуудыг тусгасан тайлан гаргаж, төрийн бодлого тодорхойлогчдод хүргэж, ажил хэрэг болгох ёстой хэмээн Засгийн газрын тэргүүн С.Батболд амласан. Чуулганы хүндэт зочдоор ИБУИНВУ-ын Парламентийн Төв Азийн бүлгэмийн тэргүүн Лорд Уэверли, Стэнфордын их сургуулийн профессор Жонатан Грийнберг, Хөгжмийн нэрт удирдаач Итай Талгам нар урилгаар оролцсон.

Энэ удаагийн форум УИХ-ын сонгуулийн өмнө болж байгаа. Тиймээс улстөржсөн, зохион байгуулагчдын зүгээс улс төртэй хутгах вий гэсэн болгоомжлол хүмүүст байсан. Харин санасныг бодоход улс төрийн урт гар тийм ч их байсангүй гэж сэтгүүлчид ярьж байлаа. Үнэхээрийн хөгжлийн төлөө хамтдаа байхыг л чухалчилсан, хөгжлийн гарц хайхыг хичээж байснаас зохион байгуулагчид, төлөөлөгчдийн зүгээс ч улстөржсөн, намаар хагаралдсан, сонгууль угтсан шоу болоогүйг онцлон тэмдэглэе.

Манай сэтгүүл өмнөх дугаараараа тус чуулганаар хэлэлцэх бүх сэдвийн хүрээнд нийтлэлүүд бичсэн тул форумын сэдэв бүрийн сурвалжлагыг дараа дараагийн дугаараа хүргэх болно.

Төсөв

Ил тод, иргэдийн хяналтыг сайжруулах сайхан зорилт

Б.Ууганбаяр

Монгол хэмээх их айлын иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагын татвар, бусад орлогоос бүтэж буй төсвийн мөнгөний зарцуулалт болон татвар төлөгчдийн хяналт хангалтгүй, хууль эрх зүйн орчин бүрэлдээгүй байгааг Эдийн засгийн форумын салбар хуралдааны үеэр оролцогчид санууллаа. Гэхдээ тэд бас хамтдаа гарах гарцыг эрэлхийлж, санал бодлоо солилцож, ухаанаа уралдуулсан юм.

Хаалттай, хавчигдмал төсөв

Иргэдийн ирээдүйн ахуй, амьдралын өнгө төрх, улс орны хөгжлийн чиг хандлагад хэрхэн хөрөнгө оруулалт хийж, ахиц дэвшил гаргах чиглэлээр төрөөс гаргаж буй томоохон бичиг баримт бол мэдээж улсын төсөв. Тэгвэл төсвийг зориулан гаргаж буй эзэн нь болох иргэдэд төсвийг зохиохоос нь эхлээд батлах, хэрэгжилтэд нь хяналт

тавих хууль эрх зүйн орчин хангалтгүй байгааг олон хүн дурдсан. Нөгөө талаас төсвийг хянадаг гол субъект нь өөрөө захиран зарцуулах эрхийг эдэлдэг учир буруу арга барилаар сүүлийн арав гаруй жил явж байгаа учраас авлига цэцэглэж, иргэд төсвийг хянах боломж хумигдсан гэдгийг МАЭХ-ны тэргүүн Ц.Оюунгэрэл хэллээ. Тиймээс төсөвт хяналт тавих эцсийн боломж иргэдэд л үлдэж буйг ч тэрбээр онцлов.

Төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр сүүлийн хоёр жилд хууль эрх зүйн хүрээнд багагүй ахиц гарсан ч үүнийг байгууллага, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхгүй байгааг Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь шүүмжилсэн. Түүний хэлсэнчлэн УИХ-ын Дэгийн тухай хуулиар Нээлттэй сонсгол хийх бололцоог төсөв батлахад заавал ашиглах ёстойг сануулав. Дээр нь гүйцэтгэх засаглал хангалтгүй ажиллаж байгааг ч хэлсэн. Учир нь, төсвийг ▶

<http://www.mongolianeconomy.mn>

Монголын эдийн засгийн чуулган ямар болсон бэ?

П.Цагаан /Монгол Улсын Ерөнхийлөгчийн эдийн засгийн зөвлөх/

-Улс орны эдийн засгийн асуудлыг хэлэлцэж байгаа нь сэргэн мандахын шинж тэмдэг. Нэг үгээр хэлбэл ардчилалтай, амьдрах чадвартай байгаагийн илрэл юм. Өнөө жилийн чуулган төр, хувийн хэвшил, иргэний уулзах цэг, асуудлаа ярилцах төв боллоо. Ардчилсан зарчмаар алдаа, оноогоо хэлэлцлээ. Монгол улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгаа бэхжүүлэхэд чуулган үр дүнгээ өгсөн.

Г.Ганболд /Голомт банкны Иргэдийн банк хариуцсан тэргүүн дэд захирал/


-Эдийн засгийн чуулганы хувьд гурван жил зохион байгуулагдлаа. Зохион байгуулалтын арга хэлбэрээ аятайхан олчихлоо гэж бодож байна. Форумын ач холбогдол жилээс жилд өсөж байна. Тус чуулганы үнэ цэнэ нь зөвхөн манай монголчууд төдийгүй гадны зочид төлөөгчдийн сонирхлыг төрүүлэх боллоо. Төр, засгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний болон олон улсын байгууллага, судлаачид, гадаадынхан оролцож өнөөдөр, ойрын ирээдүй, удаан хугацаанд тулгарч болох асуудлыг барьж хэлэлцлээ. Товчхондоо эдийн засгийн чуулган гэдэг уулзах цэг, нээлттэй индэр юм.

Д.Энхжаргал /Монголбанкны Лондон дахь төлөөлөгчийн газрын захирал/

-Энэ жилийн Монголын эдийн засгийн чуулган өнгөрсөн оныхоо ажлыг дүгнээд, ирээдүйд юу хийх вэ гэсэн гол асуудлуудыг авч хэлэлцлээ. Өнөөгийн манай эдийн засагт өндөр өсөлт байгаа боловч эдийн засгийн чанар, өгөөж нь хувь хүндээ хүрч чадахгүй байгаа талаарх асуудлыг ярилцлаа. Мөн ирээдүйд учрах сорилтуудыг даван туулах чухал хэлэлцүүлэг боллоо.

С.Одонтуяа /НИТХ-ын төлөөлөгч/

- Эдийн засгийн форумар анх удаа эрүүл мэндийн асуудлыг авч хэлэлцлээ. Эрүүл мэндийг эдийн засгийн нүдээр томоор харах шаардлагатай болсныг хүн бүхэн ярьж байна. Өнөөдөр эдийн засаг гэдэг хамгийн хялбар зүйлийг хэлээд байгаа шүү дээ. Тиймээс өнөөдөр эрүүл мэндийн салбарын тухайд иргэд халааснаас хэрхэн бага зардал гаргах вэ. Гаргасан зардал нь хэр чанартай байх вэ гэдэг асуудал байна. Миний хувьд эрүүл хот, эрүүл орчинг бий болгосноор эрүүл мэндийн зардал буурна. Тиймээс эмч, эрүүл мэндийн салбарыг үнэ цэнэтэй болгох хэрэгтэй.



УИХ-д өргөн барихаас өмнө олон нийтэд ирэх жил ямар төсөв батлах вэ, ямар томоохон хөрөнгө оруулалт хийх вэ гэдгээ иргэдэд мэдээлдэггүй, яам, тамгын газраас гаргасан саналын дагуу л явуулж байна гэдгийг онцолсон нь хуралд оролцогчдын сэтгэлд ихэд нийцэж байгаа нь илт байсан. Энэ нь төсвийг батлахдаа үндэслэл муутай, ашиг сонирхлын зөрчил агуулсан, үрэлгэн зарцуулах үндэс болдог аж. Ялангуяа хөрөнгө оруулалтын зардал дээр ТЭЗҮ-ийг сайн хийдэггүй, эсвэл жил бүр дахин дахин ТЭЗҮ хийж мөнгө завших сонирхол шат шатанд байдгийг ч хэлэхээс тэрбээр эмээгээгүй. Түүнчлэн манайд төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хангалтгүй араасаа хэл ам дагуулж буй шалтгааныг Сангийн сайд Д.Хаянхярваа тайлбарлахдаа “УИХ, Засгийн газрын гишүүд, орон нутгийн түвшинд эрх ашгийн, эд хөрөнгийн зөрчил ихтэй холбон тайлбарласан. Дээр нь иргэд УИХ-ын гишүүдийг төсөв захиран зарцуулдаг хүн мэтээр ойлгодог нь хамгийн буруу хандлага” гэв.

Мөн Засгийн газар эрх зүйн чадамжынхаа хүрээнд баталсан төсвийг УИХ дээр гишүүд элдэв янзын юм ярьж, хувийн эрх ашигтаа нийцүүлэн өөрчилдөггүй байх эрх зүйн орчин хэрэгтэйг өмнөх Сангийн сайдаас эхлээд ярьдаг байсныг оролцогчид санууллаа. Дээр нь төсвийн тэлэлт, төсвийн байгууллагынхны цалинг нэмж байгаа нь хувийн хэвшлийнхний хөлдөө чирч байна гэдгийг “Өгөөж чихэр

боов” компанийн ерөнхий захирал С. Түмэнгэрэл сануулав. Үүнээс гадна нийгмийн дундаж давхаргын ажилчид, иргэдийн дунд цалингаасаа татвар хэрхэн төлдөг талаараа болон үүнийхээ ач холбогдол, хяналтын талаар ойлголт маш хангалтгүй гэдгийг ч хэлсэн.

Мөн нэг жилийн доторх эдийн засгаа харж, зохицуулж чадахгүй байгаа хүмүүс яаж улс орноо эдийн засгийг өндөр хөгжилд аваачих вэ. Ядаж төсөвт байсхийгээд л тодотгол хийж, хариуцлагагүй төсөв баталдгаа

	1998	2011	2012
Улсын төсөв	330 тэрбум төгрөг	5.1 их наяд төгрөг	6.3 их наяд төгрөг
Ядуурал	35.6%	39.2%	-



зогсоох шаардлагатайг ч судлаачид дуу нэгтэй шүүмжлэв. Ийнхүү улсын төсөв, мөнгөний бодлогыг захиран зарцуулдаг албан тушаалтнууд, эрдэмтэн, судлаач, эдийн засагчид төсвийн зарцуулалт, түүнд тавих татвар төлөгчдийн хяналтад тулгарч буй хууль эрх зүйн болон бодлогын асуудлыг сөхөн тавилаа. Тэд ерөнхийдөө улсын төсвийг хаалттай хавчигдмал, зохицуулалт муутай, үрэлгэн гэдэгтэй санал нэгдсэн юм.

Төсвийг ил тод, нээлттэй болгох жор

Тэгвэл одоо төсвөө ил тод нээлттэй болгож, олон нийтийн оролцоог хангаж, зөв зарцуулж, хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгохын тулд ямар алхам хийх ёстой гарцыг эрье.

“Манай улс иргэдийг татварын орчноосоо холдуулах бодлого барьж буй нь хамгийн буруу. Уг нь иргэн бүр татвар төлдөг байж л эргээд хяналт тавих юм. Тиймээс иргэн, аж ахуйн нэгж хамтдаа санхүүгийн цагаан толгойд суралцъя” хэмээн Ерөнхий сайдын зөвлөх Б.Лхагважав уриалсан. Үүний тулд татварын хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байгааг тэрбээр хэлэв. Учир нь, эдийн засгийн хөгжлийн хурдыг хууль нь гүйцэхгүй байна. Татвар төлөх боломжтой хэсэгт нь илүү давуу харин боломж багатай хэсэгт халтай болоод байгаа. Тиймээс татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, түүнээсээ үүдэлтэй хөнгөлөлтийн системийг бий болгох гарц байгааг тэрбээр онцолсон юм.

Нөгөө талаас иргэд, татвар төлөгчдийн оролцоог хангахын тулд төсвийг зохиохоос эхлээд батлах, хэрэгжүүлэлтэд хяналт тавих эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгож, нээлттэй хэлэлцүүлэг явуулж байх хэрэгтэйг олон хүн хэлж байлаа. Ингэхдээ аль болох бага нэгжээсээ буюу иргэн, баг, сум, хорооноосоо эхлэх хэрэгтэй аж. Жишээ нь, орон нутагт төсвийнхөө 20 орчим хувийг зөвхөн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, юунд зарцуулахаа шийддэг механизм байж болох юм байна. Мөн ТЭЗҮ хийгдээгүй хөрөнгө оруулалтуудад санхүүжилт хийхгүй байхыг ч сануулсан. Тухайн жилийн төсөвт хийгдэж буй томоохон хөрөнгө оруулалтуудыг иргэдийн дунд нээлттэй хэлэлцэж, танилцуулж байх хэрэгтэйг “Петровис” компанийн ерөнхий захирал Ж.Оюунгэрэл сануулав. Дээр нь төсвийн хуваарилалт, зарцуулалтад ▶▶

иргэдийн хяналтаас гадна Төсвийн зарлагын хороо, Аудитын байгууллага хяналтаа ёс төдий биш, хатуухан тавих хууль эрх зүйн орчинг дээшлүүлж, шүүх засаглалынхан ажлаа сайн хийж, төсөв мөнгө шамшигдуулсан хүнд төр төмөр нүүрээ харуулж байж үр дүн гарна гэдгийг Дэлхийн банкны Монгол, Хятад, БНСУ-ыг хариуцсан суурин захирал Клаус Роланд онцлов. Манай Төрийн Аудитын байгууллагын эрх зүйн чадамж доогуур, төсвийн зарцуулалтад хяналт, шалгалт тавьсан ч эргэж түүнийг хэрэгжүүлэх механизм байхгүйг засах шаардлагатайг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Б.Батбаяр ч учирласан.

Харин энэ асуудлыг өндөр хөгжилтэй орнуудад шийдэхдээ Нийтийн данс тооцооны хороог ажиллуулж, зөвхөн Аудитын байгууллагынхаа хийсэн тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжилтийг нь хангадаг аж. Ингэхдээ

дээрх хорооноос давхар зөвлөмж гаргаж, Парламентын гишүүддээ хүргүүлдэг жишигтэй юм байна. Энэ нь төсвийн зарцуулалтын ил тод байдлын жанжин шугам, хяналт болж өгнө гэсэн үг гэнэ. Энэхүү аудитын байгууллагын төсөвт хийсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, ул мөрийг хянах механизмтай бол гэсэн шаардлага манай улсад Аудитын олон улсын байгууллагаас удаа дараа өгсөн ч хэрэгжээгүй байгааг тэрбээр шүүмжлэв. Төсвийн зарцуулалтад хяналт тавих өөр нэг гарц нь иргэд энэ хүрээнд гарц, хууль дүрмийн дагуу орон нутаг, сум, багынх нь төсвийн мөнгийг хэрхэн юунд зарцуулсныг эргэж хянаж, асуун шалгааж, үр дүнг нэхдэг байх нь зүйтэй гэдгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд чухалчилсан.

Эцэст нь иргэний нийгмийн байгууллага, ард иргэд хамтран төсөвт хяналт чанд тавьж байх нь хамгийн

шударга зарчим тул таны талхны мөнгө, үр хүүхдийн чинь хоолны мөнгөнөөс хумслах гэсэн хүмүүсийн муу үйлдлийг таслан зогсоох л чухал байгаа юм. Нөгөө талаас УИХ болон бүх шатны ИТХ-ын байгууллагын төсвийг хуваарилдаг хянадаг ажлаа үнэнч шударга хийж, шүүх засаглалын байгууллага нь төсвийн сахилга бат алдсан, төсвийн мөнгийг үргүй зарцуулдаг албан тушаалтнуудад тавих хяналтаа сайжруулах хэрэгтэй гэдэг дүгнэлтэд хуралд оролцогчид санал нэгтэй хүрсэн юм. Төсвийн ил тод байдлыг сайжруулах, иргэдийн хяналтыг сайжруулах талаар ийнхүү олон сайхан санал, шийдэл гарсан. Хуралд оролцогчид ирэх жилийн Эдийн засгийн форумын үеэр төсвөө хянаж чадах, чадахгүй тухай биш ямар зүйлд зарцуулсан, хэрхэн хөрөнгө оруулалт хийсэн, зөв буруу гэдэг тал дээр нь ярьдаг больё гэсэн өөдрөг зорилт дэвшүүлсэн билээ. ■

Авлига

Чанга хууль ядмаг зүтгэл

Б.Энхцэцэг

Хөдөлбөл хөлс, зогсвол зоос гэдэг чинь ер нь манай чөлөөт зах зээлийн номер нэг уриа юм биш үү. Банкнаас зээл авъя аа мөнгө, ажил, сургуульд оръё оо мөнгө, эмнэлэгт хандана аа мөнгө, ажлаа бүтээе ээ мөнгө... ингээд л зах хязгааргүй үргэлжилнэ шүү дээ. Мөнгөгүй бол ажил урагшилна аа “гонж” гэж байгаа. Дэлхийн авлигатай тэмцэх иргэний нийгмийн “Transparency International” байгууллагын 2011 оны судалгаагаар Монгол Улс дэлхийн 183 орноос 120 дугаар байранд жагсжээ. Нэгхэн жилийн өмнө буюу 2010 онд манай орон дээрх судалгаанд өнгөрсөн оныхоосоо арай дээр буюу 116 дугаарт орсон юм. Ганцхан жилийн дотор дөрвөн байраар ухарчээ. Гэтэл манай урд хөрш 75 дугаарт орсон байна. Эндээс харахад Монголд авлига цэцэглэсэн хэвээр. Авлига хаана тохитой үүрээ зассан бэ гэхээр улс төрийн хүрээнд. Өнөөдөр

манай улсын залуу халаа эх орныхоо төлөө зүтгэх бус, идэж уухын төлөө урагшаа уриан дор төрийн алба руу хошуурдаг болсон нь дээрхийг баталж байгаа бодит баримт.

“Оюутнуудаас хулгай хийх үү гэж асуухад хэн ч хийнэ гэж хариулаагүй атлаа авлига авах уу гэхэд тэдний гуравны хоёр нь авна гэсэн хариулт өгсөн” хэмээн МУИС-ын Эдийн засгийн сургуулийн багш С.Даваасүрэн “Монголын эдийн засгийн чуулган 2012”-ын үеэрх авлигын хэлэлцүүлэг дээр ярьсан. Энэ бол өнөөгийн залуусын дундах авлигын тухай ойлголт. Харин УИХ-ын гишүүн С.Оюун урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нь авлигатай тэмцэх асуудлуудын нэн тэргүүнд тавигдах ёстой гэж хэлж байв.

“Томоохон авлигыг махан идэштэнд оруулж, бага гарын жижиг авлигыг өвсөн идэштэнд багтаан авч үздэг ангилал байдаг. Манай улс газар нутгийнхаа

60,70 хувийг лицензээр худалдчихсан байна гэхээр л ойлгомжтой шүү дээ” хэмээн МҮХАҮТ-ын Нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Ч.Нэргүй хэллээ.

Орчин үеийн авлигын өнгө төрх өгөх нь бөхийж авах нь гэдийдэг болсон гэнэ билээ. Гэхдээ манайх Эрүүгийн хуулийн Албан тушаалын гэмт хэргийн 28 дугаар бүлэгт өгсөн, авсан хоёул шийтгэгддэг айхтар чанга хуулийн заалттай орон. Энэ часхийсэн заалттай хууль одоогоос арван жилийн өмнө буюу 2002 онд батлагджээ. Өмнө нь хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. /Энэ тайлбарыг 2008 оны хоёрдугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/ байна. Харин Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлийн тайлбарт авлигад зуучилсан этгээд сайн дураараа хэрэг зоригоо хэлээд ирвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө гэсэн заалт бий.

Хуулийг чангаллаа гээд манайд авлига дэгэнд ороод байгаа юм алга. Харин ч авлига өгөх, авах арга аль ч салбарт улам нарийсаж, цэцэглэн хөгжсөөр байгаа тухай баримт материал, ам дамжсан яриа цөөнгүй бий. Нэг үгээр хэлбэл, авлига ханцуйнаас ханцуй руу харагдахгүй урссаар. Гэхдээ энэ нь шийтгэгдэхгүй өнгөрнө гэсэн үг хараахан биш аж. ▶



► Хуулийг шүүмжлэх хүн олон бий. Арга ч үгүй. Тэнэг л биш бол хэн ч бусдыг боддоггүй юм аа гэхэд өөрийгөө ялд унагахыг хүсэхгүй. Мэдсээр байж мэдээгүй өнгөрч, зүхсээр байж зүгээр өнгөрөхийг энэ хууль өөшүүлэн хөгжүүлэх үндэс болж байгаа хэрэг юм. 2002 онд хүчин төгөлдөр мөрдөгдсөн уг хуулийн сул талыг авлига далд хэлбэрээр хөгжих бололцоог бүрдүүлсэн хэмээн үзэх нь бий.

Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Л.Энхсайхан “Аливаа хуулийг гаргахдаа эцсийн үр дүнг сайтар тооцоолж байж гаргадаг. Хэрвээ авлига өгсөн этгээдийг чөлөөлөх тал дээр хуулинд өөрчлөлт оруулбал

ямар тохиолдолд ямар байдлаар чөлөөлөх вэ гэдгийг маш тодорхой зааж өгөхгүй бол ашиг сонирхлын үүднээс нэг нэгнийгээ хилс хэрэгт унагах хор уршиг дагуулах эрсдэлтэй” гэв. Монголын эдийн засгийн чуулганы авлигын асуудлаарх тусгай хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын олонхи нь хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж, тодорхой болгохыг дэмжиж байсан. Нөгөө талаас хуулийн орчин байгаа харин хэрэгжилт хангалтгүй байна гэдэг асуудлыг ч сөргүүлэн тавьж байлаа. УИХ-ын гишүүн С.Оюун “ Маш олон хууль хамтдаа зэрэг хэрэгжиж байж бага багаар урагшилна уу гэхээс өргөс авчихсан мэт ганц хоёр хуулийн учрыг оллоо гээд энэ асуудал шийдвэрлэгдэхгүй нь лавтай. Авлига гэдэг илрүүлэхэд хүндрэлтэй хэрэг учраас эрсдэлийг нь нэмэгдүүлэх замаар тэмцэх нь зөв гэж үздэг юм билээ” гэж хэлсэн юм.

Мэргэжлийн хүмүүсийн ярианаас үзэхэд, Хөрөнгө орлогын мэдүүлэг, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэрэгжиж эхэлсэн, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль саяхан батлагдсан мөн Авлигын конвенцтэй уялдуулан Монгол Улсын эрүүгийн хууль бусад хууль тогтоомж, бодлогыг чангатгасан гээд авлига өгч, авахад бизнесийн эрсдэлийг ихэсгэж ашиг багатай болох нөхцөлийг бүрдүүлээд байгаа аж. Түүнчлэн Авлигатай тэмцэх газарт ч энэ байдлаараа хийх ажил нэлээд нэмэгдэж байх шиг. Гэхдээ манайд хууль хэрэгжинэ гэж нэг хэцүүхэн асуудал бий шүү дээ. Хууль хууль шиг байвал задарсан авлигыг хазаарлах найдвар бий. Нэргүй даргын хэлсэн махан идэштэнд манай хууль тогтоох эрх мэдэлтнүүд өөрсдөө багтах вий. Иймээс хууль байгаа ч улс төрийн хүчтэй хүсэл зориг үгүйлэгдэж байна гэж үзэж болох юм.

“Авлига өгснөөр тухайн байгууллагын зардал 10 хувиар нэмэгддэг” гэсэн судалгаа байдгийг Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Ж.Баярцэцэг онцолсон. Тэгвэл өнөөдөр манай хувийн хэвшлийн 150 гаруй байгууллага хамтарч Дэлхийн эдийн засгийн чуулганаас хэрэгжүүлж буй /PACI/ Дэлхий нийтийн авлигыг устгах санаачилга буюу “Авлигын эсрэг түншлэлд” нэгдэж гарын үсэг зурсан нь бизнесийнхний

Эмэгтэйчүүд авлигад бага автдаг

Төрийн эрх баригчдын талаас илүү хувийг эмэгтэйчүүд эзэлдэг дэлхий дээрх цорын ганц орон бол Руанда. Тус улс 2011 онд авлигалын индексээрээ дэлхийд 49 дүгээр байранд жагссан бол бүсийн хэмжээнд дөрөвт оржээ. Руанда улсад авлигалын хэрэг харьцангуй бага гардаг гэдгийг авлигалын эсрэг “хоточ нохой” Transparency International байгууллагаас мэдээлсэн байдаг. Үй олон иргэдийг хомроглон устгасан 1994 оны тэр өдрөөс хойш тус улсын зүгээснөр их хүчин чармайлт гаргасны эцэст өнөөдөр Зүүн Африкдаа хамгийн бага авлигалтай оронд тооцогддог.

Тус улсын Парламентын 56 хувийг эмэгтэйгтэйчүүд эзэлдэг бөгөөд сонгуулиас сонгуульд энэ тоо нэмэгдэж байгаа аж. Руандад хуулийн дагуу Омбудсманы үүрэг гүйцэтгэгчид авлигалаас сэргийлэн, тэмцдэг. Төрийн албан хаагчид омбудсманд хөрөнгө орлогоо мэдүүлэх ёстой байдаг ба эс бөгөөс сэжигтнээр татагддаг байна. Гэвч ихэнх судлаачид тус улсын авлигалаас богино хугацаанд ангижирч чадсан амжилтыг эмэгтэйчүүдийн ноёрхолтой холбон авч үздэг. “Эрэгтэй хүн эмэгтэй хүнийг бодвол илүү эрх мэдлээр цангамал байдаг учир эрчүүд

илүүтэйгээр хахууль авдаг хэмээн “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Сара Тейлор хэлсэн байдаг. Нэг талаас эмэгтэйчүүд авлигал авахыг биеэ үнэлэхтэй адилтган ойлгодог гэж үздэг бол нөгөө талаас эмэгтэй хүн үр хүүхэд, эцэг эхээ асран хамгаалах гэсэн нийгмийн үүргийнхээ үүднээс аливаа эрсдэлээс зайлсхийх хүсэлтэй байдаг оршдог гэж үздэг байна. Дэлхийн банкны гаргасан судалгаагаар эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол авлигад автахдаа харьцангуй бага, итгэл даах чадвар сайтай байдаг гэжээ.

хүсэл зоригийг илтгэж байгаа нэг үзүүлэлт аж. Учир нь, дэлхийн аль ч улс оронд ийм тооны томоохон компани хоорондоо нэгдэж хамтдаа тэмцэхээр идэвхийлсэн нь үгүй юм байна. МУ-ын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх П.Цагаан “Төр нь ингэж дэмжээд, засаг нь ингэж санаачлаад, хувийн хэвшил нь энэ эрчээрээ тууштай урагшилж чадвал Монгол Улс хэдхэн жилийн дараа авлигаас ангижирч чаддаггүй юм аа гэхэд тэг гэсэн тоо руу тэмүүлсэн улс болох боломжтой” хэмээн өөдрөгөөр өгүүлэв.

Хууль хэрэгждэг, шударга ёс тогтсон, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, авлигатай тууштай тэмцэх гээд Сайн засаглалын гол гол зарчим хэрэгжиж чадвал хөрөнгө хөгжил болдгийн жишээг Австрали, Хонконг, Сингапур,

Шинэ Зеланд гэх мэт орон харуулж байна. Нөгөө талаас хэчнээн их байгалийн баялагтай ч Сайн засаглалгүйн улмаас ядуурал гуйланчлал нь тартагтаа тулж, явцуу ашиг сонирхлоо дийлэхээ больчихсон Африкийн орнууд ч муу засаглалын тод жишээ юм.

“Хүн хэлэхээс нааш санахгүй, цаас чичихээс нааш цоорохгүй” гэдгийн адил авлигал багасаагүй цагт уйдаж, залхаж, цөхөрч болохгүй нь, монголчууд аа. Хөгжил, авлига хоёрын хүйн холбоог таслахгүй аваас өттэй мал таргалдаггүйн адил нийгэм, эдийн засаг дахь эдээ бээр арилах нь байтугай улам бугшсаар ядуу буурай хэвээр үлдэх аюултай. ■

Тэд бидний тухай

Уул уурхайн тэсрэлт дундах бохир баячууд ба үндсэрхэг үзэл

Түрүүч нь №014 дугаарт

Б. Энхцэцэг

Монгол оронд олон хүн ирээдүйгээс эмээж амьдардаг. Уулс төрийн хүрээний авлигал өргөн дэлгэрч, цөөн хэдэн томчуулын жинтэй нөлөө эдийн засаг болон төрд зонхилно. Хүрээлэн буй орчны төлөө тэмцэгчид болон малчдын зүгээс хүн малын ундны ус, газар шороог сүйтгэж байна хэмээн ихээхэн гомдоллодог. Дэлхийд тоогдсон цөөнгүй уурхай нь гаднын “өлөн” компаниудаар хүрээлүүлсэн Монголын Засгийн газаргеополитикийн тулааныг Хятад, Орос, барууныхан болон Зүүн Азийн гарамгай эдийн засгийн хүчнүүдийн дунд “дэглэж” байна. Тэгэхээр энэ мөнгө хаашаа орох вэ гэдэг асуулт гарч ирч байна. Асар их баялгаа Монгол Улс эрх тэгш, шударга нийгэм байгуулахад зориулж чадах болов уу эсвэл баялгийн хараалд өртсөн бусад ядуу буурай орон шиг зөвхөн элитүүдэд хүртээлтэй, уул уурхайгаас хэт хараат зогсонги эдийн засагт хөтлүүлэх үү? Австрали шиг үү эсвэл Нигер шиг үү?, Норвеги уу эсвэл Венесуэль үү?

Монгол Улс нь Хятадын үйлчлэгч колони болох уу гэдэг асуудал олон хүний санааг зовоож байна. Гэхдээ Хятад улсын галт тэрэг утаа хаяхаа боливол юу болох бол.

Бүсийн хөрөнгө оруулалтын “Евроази капитал” банкны ахлах эдийн засагч Дорсберген Мусаев Улаанбаатарын төвд байрлах албан тасалгааныхаа цонхоор, шил шилээ даран сүндэрлэхбарилгуудыг ажиг, Монголын үсрэнгүй хөгжлийг бахдан сууна. Хажуухан талд нь шинэхэн оффисийн зориулалттай барилга босож, харин түүний ойролцоо зэргэлдээх супермаркетаас ч том тайчих клуб саяхан үүдээ нээсэн байна.

“Энэ бол үнэхээр гайхалтай хэрэг” хэмээн Монголын баялгийн үнэлгээг ам.доллараар илэрхийлэн тэрбээр хэллээ. “Бид одоо 1,5-аас хоёр их наяд ам.долларын талаар ярьж байна шүү дээ” гэв. Тэрбээр мөн “Үгүй ээ тэр гудамж руу хар л даа. Улаанбаатар хот дэлхийн “Хаммер”

маркийн машины төв байж магадгүй л юм. Бүх зүйл л Хятадын толгой дээр буугаад ирлээ шүү дээ. Энэ бол Хятадын таваарын эрэлт. Хятадын эдийн засагт өөдрөг хандлага байгаа бол Монголын эдийн засагт ч эргэлзээд байх зүйлгүй” гэж хэлсэн юм.

Хэн хүнийнүд Хятадтай залгах хилийн ойролцоох цэлмэг хөх тэнгэрийн дор цэмцийн оршиховь нутгийн уул уурхайн хоёр том төсөл дээр төвлөрч байна. Дэлхий дээрх хамгийн том уурхайнуудын нэг, олборлолт хийгдэж эхлээгүй байгаагээс, алтны Оюутолгой уурхайг Лондонд төвтэй Англи Австралийн хамтарсан баялгийн магнат Рио Тинто гардан авч явж байна. 2013 онд албан ёсоор арижааны олборлолтоо эхлэхээр зэхэж буй дээрх Оюутолгойн орд 46 сая унци алт, 37 тэрбум тонн зэсийн нөөцтэй хэмээн үнэлэгджээ. Харин нөгөө нэг төсөл болох Тавантолгой нь зургаан тэрбум гаруй тонн нүүрсний нөөцтэй гэх боловч энэ нь тодорхой тогтоогдоогүй байгааг үл харгалзан олборлолтын ажил нь эхэлчихсэн явж байна. Монгол Улсын хувьд уул уурхай шинэ зүйл биш ч түүнийг дагасан үсрэнгүй өсөлт цоо шинэ үзэгдэл юм. Социализмаар замнасан 70 жилийн хугацаанд зарим уурхайг ашиглаж олборлолт хийдэг байсан ч тус улсын газар нутгийн ихэнх хэсэг хэний ч гар хүрээгүй хэвээрээ үлджээ. 1990 он гэхэд ардчилал эхэлж, уул уурхайтай холбогдох хуулиуд залган ар араасаа гарч ирсэн нь томоохон гадаадын компаниудын хүслийн жагсаалт шиг зохицуулалтууд байлаа. Энэ нь хүмүүсийн дуудах дуртайчлан таваарын “супер мөчлөг” –ийн нэг хэсэг байлаа. Барууныхан баларч, түүхий эдийн үнийг доош чирч байхад Хятадаар хөтлүүлсэн хөгжиж буй дэлхийн зарим улс гүрнүүд үүнийг үл харгалзан өмнө нь үзэгдээгүй эдийн засгийн өндөр өсөлт өөд алхалсаар байв.

Яг хэзээнээс Монголын үсрэнгүй өсөлт эхэлснийг асуугаад үзээрэй. Хүн бүр өөр өөр хариулт хэлэх нь бий. ▶

Гэвч Монголын бизнесийн зөвлөлийн дарга Жим Двайр “Энэ бол Монгол орны хувьд түүхэнд байгаагүй 1000 магнитудын хүчтэй тэнцэх маш том гэрээ юм” хэмээн хэлсэнчлэн хэдэн зуун ам.доллараар үнэлэгдэх нөөцтэй Оюутолгой хамгийн том өөрчлөлт гэдэг нь тодорхой.

Монголчуудын өнөөгийн нийтлэг дүр төрхийг аживал барууны маягийн дэгжин. Ардчилсан улстөрчдийн нэг Сангийн яамны дэд сайд Чулууны Ганхуяг Давост цугласан дэлхийн нэртэй хүмүүсийн дунд жирийн л нэгэн байх авч бизнесийн магнатаас Ерөнхий сайд болсон Сүхбаатарын Батболдын нэгэн адил Монголыг Азийн “Чоно эдийн засагтай орон” хэмээн Зүүн Өмнөд азийн бар эдийн засагтай орнуудаас зориуд онцлон өөрөөр дуудах дуртай. Ч.Ганхуяг монгол орон баялгийн хараалыг тойрон гарч, баян орон болно гэдэгт гүн итгэдэг нэгэн. Түүний хэлснээр бол тус улсын түлхүүр хүч бол ардчилал. Одоогийн байдлаар Засгийн газраас Монголын иргэн бүрт уул уурхайн хишиг болгон 21 мянган төгрөгбуюу 14,50 ам.долларыг сар бүр олгож байгаа юм байна. Харин үүнийг сайд Ганхуяг олон нийтийн дэмжлэгийг хүртэх гэсэн бодлого бөгөөд энэ мөнгийг дэд бүтцийг сайжруулахад зарцуулах нь харьцангуй үр дүнтэй хэмээн үзэж байгаа аж. Тун удахгүй Тавантолгойн нүүрсний нөөцийг олборлох үйл ажиллагаанд шууд оролцогч “Эрдэнэс Тавантолгой” хэмээх монгол компани IPO хийхтэй холбогдуулан монгол хүн бүр хувьцаа эзэмшигч болох гэж байна. Сайдын хэлснээр бол маш олон төрийн бус байгууллагын зүгээс байгаль орчны стандартуудыг хангасан эсэхэд хяналт тавин ажиллаж байгаа гэнэ.

Хамгийн төвөгтэй асуудал нь геополитик юм. Тоглолт зохион байгуулагч асан Орос улс Монголын хойд талд орших бөгөөд харин зүүн баруун өмнөд хэсгийг ороон хиллэсэн өмнөд хөрш нь байршлаа ашиглан давуу эрхтэй худалдан авагчийн үүднээс тус улсын таваарыг дэлхийн зах зээлийн үнээс доогуур авахаас татгалзахгүй. Маш олон ажлын байр бий болгогч боловсруулах үйлдвэрүүдийг Бүгд найрамдах улс өөрийн хил дээр байлгах хүсэлтэй байгаа юм. Хятад улс уурлаж урвайх нь амархан. Далай ламын дайран өнгөрсөн нэг удаагийн айлчлалын үеэр хилээ хааж байсан бол өнгөрсөн оны арваннэгдүгээр сард түүнийг дахин айлчлахад мөн л гомдол мэдүүлж байсан билээ.

Монгол Улс дипломат харилцааныхаа хүрээнд “Гуравдагч хөрш” хэмээх бодлогыг Хятад, БНСУ болон барууны орнуудын хувьд баримталдаг. Ирак руу хүртэл цэрэг явуулсан байна. Гэвч ингэлээ гээд тус улс чөдөр тушаанаасаа бүрэн суллагдах боломжгүй. “Бид хэдийгээр Америк, Европ, Австрали болон Канад улсын сонирхлыг татаж байгаа ч гэсэн Монголын уул уурхайн хувьд гол худалдан авагч нь Хятад улс байсаар л байх болно” хэмээн Ганхуяг сайд хэлсэн юм.

Өнөөдөр, Тавантолгой геополитикийн хамгийн том асуудал болж хувираад байгаа билээ. Төрийн өмчийн “Эрдэнэс Тавантолгой” компанийн ашиглалтын талбайгаас гадна үлдсэн хэсэг дээр ноёрхлоо тогтоох гэрээний тэмцэл Америкийн “Пийбоди Энержи”, Хятадын “Шиньхуа” Оросын төмөр замын компаниудын хооронд явагдаж байгаа билээ. Өнөөдрийн байдлаар нүүрс говийн чулуу ихтэй шороон замаар Хятад улсыг зорьж байгаа юм. Хэдийгээр Хятад улс Тавантолгойгоос 200 км-ын цаана орших хэдий ч Засгийн газар нь тус улсаас хэт хараат байдлаас ангижрахын тулд долоон тэрбум ам. долларын өртгөөр Оросоор дамжин далайн чанадад хүргэх төмөр зам барих үйл явцыг яаравчлуулж байгаа юм. Харин нөгөө



талаас Орос улс, Монгол дахь нөлөөгөө нэмэгдүүлэх бодлогынхоо нэг хэсэг болох төмөр зам барих явдлыг чөдөр болгон ашиглахаар зэхэж байгаа аж. “Гэвч энэ бол зөвхөн Орос улс уурхайгаас хуваалцаж чадвал бүтэх асуудал” хэмээн Монгол Улсад суугаа Оросын Элчин сайд Виктор Самоленко хэлсэн юм.

Хуучин зөвлөлтийн үеэс өдгөөг хүртэл Ази, Австралид дипломатчаар ажиллаж байсан Самоленкогийн хэлснээр энэ бол Орос, Хятад хоёрын өрсөлдөөн биш гэнэ. Монголд орж ирсэн зөвлөлтийн цэргүүд нэгэн цагт Бээжинд хутга тулгаж байсан түүхтэй. Мөн хүйтэн дайнаас хойш коммунист тэргүүлэх байр суурийн төлөөх Орос Хятад хэмээх хоёр орны тэмцэл харьцангуй багассан аж. “Энэ бол Оросын геополитик лав биш” хэмээн хэлснийхээ дараа хэсэг зуур дуугүй сууснаа “Магадгүй Монголынх байх” хэмээн хэлсэн.

Монгол байгалийн баялгаа өгөөш болгон унжуулж байгаад томоохон гүрнүүдээр хүрээлэгдэх санаатай байна хэмээн олон хүн үздэг. Гэвч Америкийн “Пийбоди Энержи” л оролцдоггүй юм бол АНУ-ын хувьд дулаан харилцаа үүсгэх тал дээр цаашид төдийлэн идэвхийлэх янзгүй байгаа юм.

20.00 цаг болж байв. Улаанбаатар хотын үнэтэй оффис, дэлгүүр хосолсон цогцолбор “Сентрал таур”-ын орчимд хэн нэгэн ойчсон нь зодоон хийгээ юу гэлтэй. Гэвч ойр орчим дахь хүмүүсийн байдлаас ажиад онцын муу зүйл болсон шинж ер үгүй.

Монголчууд дайчин өвөг дээдсээрээ ихээхэн бахархдаг улс. Коммунист дэглмийн дараах үед хайрлаж хүндэтгэж явдаг үндэсний сүлд тэмдгээс эхлүүлээд харгис дарангуйлагч хэмээн цоллож байсан Чингис хаанаа хүртэл цагаатган дахин хүлээж авсан юм. Монголчууд хэзээ ч хоорондоо нэг нэгэнтэйгээ учраа ололцож найртай байж чаддаггүй байжээ. Эртний нүүдэлчин нийгэмд “чиний хөрш танайхаас 20-50 км-т амьдарна” хэмээн тогтоож өгсөн байдаг хэмээн сайд асан Монголын ухаалаг, нэрт

хүмүүсийн нэг Эрдэнийн Батбаяр буюу Баабар хэлсэн юм. Мөн тэрбээр хэлэхдээ “Сүү, мах арьс, ноос зэргийг өдий хүртэл гар аргаар боловсруулдаг” гэв. Хүн амынх нь бараг гуравны нэг нь уламжлалт байдлаар амьдардаг. Архи хэтрүүлэн хэрэглэх явдал өргөн дэлгэрсэн бөгөөд өдөр шөнийн алинд ч энд тэнд хааш яаш гишгэлэн бүдчих согтуу болон гудамжинд тасарч унасан хүмүүс олонтой харагдана. Зодоон бол Улаанбаатарын шөнийн амьдралын нэгэн хэвийн үзэгдэл.

1990-ээд он бол монголчуудын хувьд хотруу цутган орж ирж байсан үе байв. Уул уурхайн хөгжил хотын гадна талд орших гэр хороололруу ядуусыг нэмж, нийгэм дэх сөргөлдөөнт хүйтэн уур амьсгалыг дэвэргэж байсныг Монголын нийгэмд судалгаа хийдэг “Сант Марал” төрийн бус байгууллагын захирал Лувсандэндэвийн Сумати ярьж байлаа. Иргэдийн олонхи нь уул уурхайгаас орж ирж буй мөнгө тэгш хуваарилагдахгүй байна гэж үзэн, хуваагдмал байр суурьтай болсон байжээ. “Хамгийн гутармаар нь хэт баян хэт ядуу, ядуу гэсэн эрс ялгаатай дүр зураг юм” хэмээн Сумати хэлсэн.

Барилгын компаниуд хятадуудыг хэдэн мянгаар нь Улаанбаатарт авчирсаар. Засгийн газар ч тэр, өөр хэн нь ч тэр яг одоо Монгол Улсад хэр олон тооны хятад иргэн байдгийг мэддэггүй. Монголын ардчилал оюуны чадавхыг баталгаажуулах гэж байх зуур арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл газар авсаар. Хэт үндсэрхэг үзэлтнүүд зодоон цохион хийх, ялангуяа хятадуудын эсрэг үйл

ажиллагаа явуулах нь бий. Тухайлбал, арьс өнгөөр ялгаварлах үзэл бүхий Гее-ийн дуунууд хүмүүсийн дунд ихээхэн дэлгэрчээ. Хэрэв Хятадын эдийн засаг хүчээ алдвал, бид ч адил хэмээн Сумати гуай хэлсэн. Гэвч бүх зүйл хурдацтай урагшлаадывал эдийн засаг халж, бас нэг талаар асуудал гарч ирнэ. “Хэрвээ инфляци өсвөл олон нийтийн замбараагүй байдал үүснэ гэж үзэхэд болно” хэмээн тэрбээр бухимдангуй шүүмжилсэн юм.

Улаанбаатараас гадна таван цаг шороон замаар хонь, мал ,адуун сүрэг ,зэрлэг бугыг харан Монголын өргөн тэнүүн талаар аяллаа.

Хотын гэр хорооллоос гаралтай цахилгаанчин мэргэжилтэй ажилгүй Хишигбадарчийн Батболдыг хуучин уурхайн үйл ажиллагаа явуулж байсан газарт алт хайн шороо угааж суухад нь би танилцсан юм. Биднийг ярилцаж байх зуур булангийн цаахна байдаг зэрлэг барууны маягийн хотыг санагдуулам тос шороо ихтэй Шижир алт гэр хорооллоос хижээл насны согтуу эр хүрч ирээд, Батболдын хүмүүсийн шорооруу дайрлаа. Харин үүний хариуд, Батболдын найз хашгирч орилохгүйгээр шууд л горхи руу тонгойн атгасан гарын дайтай чулуу шүүрч аваад өнөөх эрийн толгой дундуур зад цохиод унагачихав. “Монголчууд нэг иймэрхүү л хүмүүс байдаг юм даа” гэж Батболд хэлсэн юм. Зөвхөн энд ч биш. Угаасаа л төрөлхийн түргэн зантай улс юм гэж тэрбээр хэлсэн юм. ■


Үргэлжлэл бий...

KHATAN TUUL
Pure Water

Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/	Маркетинг: 99071655
0.6 L /bottled/	Захиалга авах утас: 70173386
1 L /bottled/	Факс: 976-11-70174494
19 L /ballon/	

Produced and bottled by “Welmon Trade” Co.,Ltd of Mongolia



Зочин

Увидаст Маестро

“...Бэлтгэл эхлэхээс өмнө хөгжимчид хувийн бэлтгэлээ базааж, энд тэндгүй төрөл бүрийн хөгжим хангинуулж, тайзнаас нэг л эмх замбараагүй хэзээ ч хоорондоо авцалдахгүй мэт санагдам уур амьсгал мэдрэгдэнэ. Харин Маестрог гараа дээш өргөх тэр л мөчид тайз тэр аяараа аниргүйд автана. Ид шидийн дохилтоор хэдэн зуун хөгжмийн аялгуу голын ус мэт нэгдэн, аугаа хүчит цогц нэгэн эгшиг болон гарах ажээ. Анир чимээ нь үгүй Маестроогоор удирдуулсан хөгжимчин нэг бүр гайхалтай тоглолт хийхийг эрмэлзэх тэр л хүслээр хөглөгдөж нэгэн бие мэт хоорондоо гайхалтай зохицон хөгжмөө тоглосоор..” ▶

► Сайн байцгаана уу ?

Эдийн засгийн бус энэхүү арга хэмжээнд ирсэн та бүхэн баярлалаа хэмээн тэрбээр өөрийн илтгэлээ эхэлсэн юм. Гар, хөлөө сүр сар хийтэл хөдөлгөн, унаж босох шахам сэтгэлийн хөдлөлөө ил гарган найрал хөгжмийг удирддаг нэгэн байхад зөвхөн уруул хөмсөг нүдээ хөдөлгөх төдийд бүхэл бүтэн 100 гаруй уран бүтээлчийг нэгэн аялгуун дор нэгтгэж чаддаг удирдаач ч байдгийг тэрбээр бидэнд харуулсан билээ. Энэ хүн бол Итай Талгам. Анх төгөлдөр хуурчийн замналаар амьдралын гараагаа эхэлсэн удирдаач улмаар хөгжим ба бизнесийн удирдахуйн ухааныг холбогч Маестро болжээ. 2012 оны Монголын эдийн засгийн чуулганы хоёр дахь өдөр мөн ч олон сэтгэл зовоож, толгой өвтгөсөн асуудлуудыг хэлэлцсэн билээ. Түүний дунд хүрэлцэн ирэгсдийн урмыг тэтгэж, оюуныг тэжээсэн гайхалтай илтгэл тавьсан Итай Талгам манай сэтгүүлд ярилцлага өгсөн юм.

-Хөгжим ба бизнесийн удирдахуйн ухаан хоорондоо ямар талаар ижил төстэй юм бэ?

-Шалтгаан нь ерөөсөө л энэ бүгд хүмүүсийн тухай байдаг оршино. Улс төр, нийгэм, бизнес, хөгжим бүгд л хүмүүсийн сайныг нь шилж байдаг. Хэдийгээр хүмүүс өөрийн гэсэн бодол санаа, ашиг сонирхолтой хэдий ч эцсийн бүлэгтээ хөгжимчид сайхан аялгууны төлөө хамтдаа тоглодог шиг нийгмийн сайн сайхны төлөө хүмүүс ч хамтдаа хөдөлмөрлөх хэрэг гардаг. Дэлхийн хаана ч энэ бүхэн адилхан байдгийг би олж харсан.

-Та яагаад Монголд илтгэл тавихаар шийдсэн юм бэ?

-Танай Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуягтай уулзсан тэр азтай учралаас үүдэлтэй. Бид Давосын уулзалтын үеэр анх танилцсан юм. Би Монголын зах зээлд маш их өөрчлөлт гарч байгааг, мөн ард иргэдэд нь гайхалтай боломжууд нээгдэж байгаа гэх мэт маш ихийг олж мэдсэн. Үнэхээр сэтгэл хөдөлмөөр санагдсан л даа. Танай оронд ирээд юуны түрүүнд тун энгийн мөртлөө маш их мэдлэг боловсролтойн зэрэгцээ жинхэнэ өөрчлөлтөд бие сэтгэлээ зориулсан тийм л хүмүүстэй уулзсан. Төсөөлж байснаас минь хэд дахин илүү байлаа.

-Хөгжмийн удирдлагыг бизнес, улс төрийн удирдахуйн ухаантай адилтгах санаа танд хэрхэн төрсөн

бол?

-Үндсэн мэргэжил минь хөгжмийн удирдаач. Хөгжим бол хөгжимчин хүний бүхий л ертөнц байдаг. Гэхдээ хөгжим түүнээс ч илүү нарийн, гүн зүйл юм. Хөгжим зөвхөн хөгжим байхаас хэд дахин илүүг хийж чадах увидастай. Дэлхий дээрх олон зүйлийг өөртөө тусган харуулах толь байж чаддаг. Ийм л учраас энэ бүхнийг хийснээр хөгжим зөвхөн хүмүүсийг хөглөөд зогсохгүй өөрөө ч хүмүүсийн бодол санаа, мэргэжлээр хөглөгдөн баяжиж байдаг онцлогтой. Миний хувьд, үүнийг хөгжим тоглодог ба эс тоглодог хүмүүсийг найрал хөгжмийн чуулгын танхимд цугласан үзэгчид адил нэгтгэх замаар хийхийг зорьдог. Тэр дундаа тоглолтын танхимаас гадна хөгжим ба үзэгчдийг нэгтгэнэ гэдэг илүү их урам зоригийг өгч байдаг л даа. Учир нь, хүмүүст энэ нь үргэлж гэнэтийн бэлэг болж чаддаг төдийгүй гайхалтай нөлөөг үзүүлдэг.

-Хөгжмийн удирдаачийн замналаа юуны учир Та энэ зүг залахаар шийдсэн юм бэ?

-Миний хувьд мэргэжил зөвхөн чиний авьяас билэг, амьдралын зорилгын бодит биеллийг хангаж байдаг хэрэгжилтийн тал юм гэдэгт итгэдэг. Миний оршихуй хэзээ ч удирдаач байгаагүй. Харин миний оршин байх нь удирдахуйн ухаан, хөгжмөөр дамжуулан хүмүүстэй харилцан холбогдох юм. Арга барил маань өөрчлөгдсөн болохоос хүсэл зорилго минь хэвээрээ л байгаа. Магадгүй Та, хэн нэгэн удирдаач болохын тулд олон жил сурч, нөгөө нь олон улсад дуурсагдах нэр хүндийг олсон байхад Та яагаад буугаад өгчихөв гэж гайхаж байж болох юм. Гэхдээ миний хувьд харин ч бууж өгсөн бус амьдралаас хүртсэн шагнал бүхнээ бусадтай хуваалцахыг хичээж яваа гэж боддог. Энэ бол миний илтгэлдээ ч ярьдаг хөрвөн өөрчлөгдөх чадвар юм. Яаж өөрчлөгдөх, хэрхэн өөрийгөө бэлтгэх гэдэг их чухал. Бид Монгол Улс үргэлжилсэн их өөрчлөлтийн салхинд хийсч явааг ярьж байна. Миний өөрөө өөртөө бий болгож чадсан зүйл чинь л тэр юм шүү дээ. Би ердөө л энэ талаар ярихад илүү бэлтгэгдсэн юм даа.

-Та Монголын дуу хөгжмийг сонсож үзсэн үү ?

-Ирсэн даруйд нэгэн цэнгүүн дээр хоёр чавхдаст үндэсний хөгжмийг сонсох боломж гарсан. Тун ч их уянгалаг сайхан төдийгүй мэргэжлийн

түвшний суурь сайтай санагдсан.

-Та одоогийн хийж байгаа ажлаараа яг юуг олон түмэнд хүргэхийг зорьдог вэ?

-Энэ бол хамтын ажиллагаа буюу хэрхэн хамтран ажиллаж буй тухай юм. Хүмүүсийг удирдана гэдэг нэг төрлийн хамтын ажиллагааны хэлбэр. Хүмүүсийн амьдралыг орвонгоор нь өөрчилж чадахгүй л дээ. Гэвч тэдний тархинд нүдэнд үзэгдэхүйц тийм л бодол санааны үрийг тарьж чадна. Тэр нь юун түрүүнд хөгжим байдгаараа хамгийн сайхан. Илтгэлийн дараа олон хүн тэр удирдаачтай уулзмаар байна. Интернетээс илүү ихийг олж мэдмээр байна гэдэг л дээ. Энэ бол нэг зүйл. Нөгөө талаас хүн болгонд маш олон боломж бололцоо, чадвар гэж байдаг. Тиймдээ ч бид түүнийгээ ашигладаг. Тодорхой арга замаар аливаа зүйлсийг хийдэг. Та тодорхой асуулт асуудаг. Магадгүй таны оюунд дахиад зуун асуулт ч орж ирж мэднэ. Би таныг ажлаа маш сайн хийдэг гэдэгт итгэлтэй байна. Тэгвэл яагаад өөрчлөгдөх ёстой гэж хэмээн бодох байх л даа.

Та олон хүмүүстэй уулзаж, олон үйл явдал танд тохиолдоно. Тэр үед Та өөртөө магадгүй “Өө надад чинь бас ийм нэгэн өөр тал байдаг юм байна” гэж бодох үе гарна. Өөрөөсөө гаргаж зүрхэлдэггүй тийм дэврүүн сэтгэл хөдлөл гэж байдаг. Бусдын оролцоогүйгээр өөрийгөө хөгжөөх гэдэг ч юм уу. Би чинь их хөгжилтэй хүн юм байна гэдгээ ухаарчихвал ярилцлага илүү үр дүнтэй болох гэх мэт юм даа. Олон төрлийн удирдахуйн ухааны арга барилаараа дамжуулан хүмүүсийн өөрөө ч ухамсарлаж байгаагүй тэр л далд ертөнцийг гаргаж ирэхэд тусалдаг юм. Энэ байдал намайг сэтгэл хангалуун болгодог. Миний зорилго тэр юм. Би олон газраар явж энэ ажлаа үргэжлүүлж яваа. Харин энэ удаад Монголд ирэх завшаан олдсонд байртай байна.

-Танд удирдахуйн ухааны олон төрлийн илтгэл байдаг уу?

-Маш их материал бий. Нэг ижил материал ч тухайн илтгэлээсээ шалтгаалан өөр өөр өнгө төрхтэй байж болдог л доо. Цөөхөн үзэгчид дунд илүү ойр дотно яриа өрнүүлэх сонирхолтой. Хүмүүстэй яриа өрнүүлэх тэр үе л маш их зүйлийг зааж өгч байдаг. Энэ бол зөвхөн би лекц уншаад байх бус илүүтэй сонсоход оршдог.

-Эдийн засаг хөгжим хоёр ►

► хоорондоо ямар талаараа холбоотой вэ?

-Амжилт дагуулсан эдийн засаг, бизнесийн хүмүүсээс тухайн жилийн орлого, төсвийн орлого нь бизнес эрхлэх голлох шалтгаан биш гэдгийг олонтой сонсож байлаа. Хамгийн чухал нь яагаад би бизнес хийж байгаа вэ гэдэг асуулт юм. Маш олон хүн аливаа зүйлийг хийхэд тодорхой утга учир хэрэгтэй гэдгийг ойлгож ухаарч байна. Юуны төлөө надад мөнгө хэрэгтэй юм. Түүнийг нийгэмд хэрхэн зөв зохистой тараах вэ гэх мэт асуултууд хүмүүсийн хувьд нэн тэргүүнд тавигдах байх гэж би хувьдаа боддог. Энэ их тоонуудын ард хүмүүс л байдаг. Тэдэнд ёс суртахууныг бий болгодог утга учир хэрэгтэй байна. Хүмүүс зөвхөн мөнгийг сонирхож байсан өнгөрөгч хямралын тэр л үед хамгийн ихээр энэ утга учир үгүйлэгдэж байсан болов уу. Зөвхөн мөнгөндөө байдаггүй л дээ. Хөгжмийн хэмнэл, бизнесийн үйл явцын аль алинд нь хүмүүсийн үнэ цэнийн асуудал оршдгоороо хоорондоо дэндүү хамааралтай гэдэгт би итгэдэг. Хувь хүн өөрөөсөө илүү үнэ цэнэтэй зүйлсийг олж харах бололцоог олгохуйц тийм л нийгмийг бий болгох нь миний хүсэл. Энэ бүгд ёс суртахуун ухамсартай дэндүү их холбогдоно.

-Таны дараагийн ээлжинд гайхшруулах орон аль бол. Эсвэл очихыг хүсэж буй газар ч юм уу?

-Би Африкийн орнуудад очихыг их хүсдэг. Өмнөд Африкт бол очиж үзсэн л дээ. Гэсэн ч тус тив бүхэлдээ сонирхлыг минь татсаар байдаг. Жуулчлалаар очих сайхан санагдсан. Гэхдээ хөтөлбөрийнхөө хүрээнд тэр оронд ямар нэг санал санаачилгад гар бие оролцож үзээгүй. Тэдгээр улс соёл урлаг, уламжлалынхаа хувьд гайхалтай баян атлаа амьдралын түвшин маш доогуур. Тэнд маш их баялаг байгаа хэдий ч тэрийгээ ойлгож мэдээгүй байна.

-Монголд ирээд хөл тавиад төрсөн анхны сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?

-Би зөвхөн Улаанбаатар хотод байсан болохоор Монгол орны тухай тийм ч ихийг хэлж чадахгүй. Гэхдээ хүмүүс нь огтхон ч ширүүн дориун биш, найрсаг, ухаалаг бас их царайлаг юм. Иргэдийн амьдралын хэв маяг их биширмээр санагдлаа. Монгол Улс надад маш их таалагдлаа. Эргэж ирэх боломж хэзээ нэгэн цагт дахин тохионо гэдэгт итгэлтэй байна. ■



Итай Талгам

Итай Талгам нь бизнесийн болон аливаа нэгэн байгууллагын удирдлагыг симфони хөгжим удирдахтай харьцуулан, маш сонирхолтой уран илтгэгдгээрээ алдаршсан нэгэн юм. 1994 онд, Израил улсын хөгжмийг гадаадад сурталчилахад хувь нэмрээ оруулсныг нь үнэлж тус улсын Хөгжмийн зохиолчдын холбооны хүндэт шагналаар түүнийг шагнасан байна. Талгам нь "Тэл-Авив" найрал хөгжим, "Musica Nova Consort"-ыг удирддаг бөгөөд Израил улсын үндэсний урлагийн зөвлөлөөс "Оны шилдэг тоглолт" хэмээх хүндэт шагнал мөн хүртэж байжээ. Итай дэлхийн нэр хүнд бүхий олон арга хэмжээ тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форум, технологи, энтертайнмент, дизайны дэлхийн чуулган гэх мэт томоохон хурлууд дээр илтгэл тавьж олны итгэл, талархлыг хүлээж байжээ.

Итай Талгамаар Францын алдарт удирдаач Леонард Бернштейн 1987 онд Парисийн найрал хөгжимчдийг удирдуулж

байжээ. Мөн тэрбээр дэлхий даяар олон найрал хөгжимчдийг удирдаж байсан байна. Түүн дотроос онцолбол нь Оросын Санкт Петербург филармони болон Германы Лейпциг хотын дуурийн театрын найрал хөгжмийг удирдсан анхны Израил удирдаач аж.

Тель-Авив хотын уугуул Итай Талгам нь Йерусалим Рубин академид Америк Израилийн соёлын сангийн тэтгэлгээр суралцаж, 1987 онд уран сайхны удирдаачаар диплом авчээ. Үүний дараагаар тэрбээр Италийн Чигана хөгжмийн академид Италийн Франко Феррара болон Оросын Геннадий Рождественский нарын хамт Америкийн Тангльвүүд хотод Сеажи Осава, Леон Флейширболон Лени Бернштейн гэх мэт алдарт хөгжмийн зохиолч удирдаач нарын удирдлаган дор суралцжээ. Үүнээс гадна Йерусалим хотын Хебрюих сургуульд ерөнхий философи судалж эрдмийн зэрэг хамгаалсан гэнэ.

Итай Талгам нь Рубин хөгжмийн академи, Тель Авивийн их сургууль болон Йерусалим хотын Хөгжим бүжгийн академид багшилж байсан юм байна. Хөгжим удирдахынхаа хажуугаар тэрбээр цөөнгүй боловсролын төсөлд идэвхтэй оролцжээ.



Ч.Отгочулуугийн булан

Баруун хөрш маань Бар болох уу?

Эсгий туургатны нэг том төлөөлөл болсон казах үндэстэн тун удахгүй Наурызийн баяраа тэмдэглэх гэж байна. Тийм учир бидний баруун хөрш Казахстан улсын өрсөлдөх чадварын талаар бичихээр шийдлээ. Үндэстний удирдагч гэгдэх Назарбаев ерөнхийлөгч энэ улсыг ЗХУ-аас салж тусгаар төртэй болсон цагаас нь эхлэн удирдаж буй юм. Бусад ... стан орнуудыг удирдагч нараас ялгаатай нь Назарбаев өөрийн улсаа шинэчлэх талаар “Хятадын онцлогтой социализм” гэдэг шиг “Казахстан маягийн капиталист” бодлого явуулж байна. Сингапурын Ерөнхий сайд Ли Гуан Яо болон Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Парк Чунг-хээ нар улс орнуудаа Азийн Бар болгож чадсан шиг Назарбаев ч мөн адил Казахстан орныг дэлхийн хамгийн хөгжингүй, өрсөлдөх чадвар сайтай орны нэг болгох зорилготой юм. Харин баруун хөрш маань ойрын ирээдүйд Өмнөд Солонгос эсвэл Сингапуртай адил өрсөлдөх чадвар сайтай орон болж чадах уу?

Эдийн засгийн хэмжээ. 2010 оны байдлаар баруун хөршийн эдийн засгийн хэмжээ 146 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь манай улсын эдийн засгаас 24 дахин их, харин хойд хөрш Оросынхоос 10 дахин бага байна. Зүүн хөрш Өмнөд Солонгосын ДНБ нэг их наяд (триллион) ам.долларт хүрчээ. Нэг хүнд оногдох ДНБ-ээр баруун хөрш 9,000 ам.доллар гэсэн үзүүлэлтээр Малайзыг ардаа орхиж улмаар Мексик болон Оросыг гүйцэхэд ойрхон байгаа юм. Манай улсын хувьд 2.2 мянган ам.доллар байсан бөгөөд энэ нь Солонгосынхоос 10 дахин бага байна.

2010 онд монголчууд 400 сая долларын алдагдагдалтай наймаа хийсэн бол баруун хөрш маань 30 тэрбум ам.долларын ашиг хийжээ. Зүүн хөршийнх тэгвэл гадаад худалдаанаасаа 41 тэрбум ам.долларын ашиг олж. Манай улс гурван тэрбум ам.долларын экспорт гаргасан бол баруун хөрш маань үүнээс 20 дахин илүүг хил давуулан худалджээ. Харин солонгосчууд Казахстанас найм дахин их бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн зах зээлд нийлүүлжээ. Солонгосчууд ихэвчлэн эцсийн бүтээгдэхүүн борлуулдаг бол Монгол, Казахстан хоёр түүхий эд борлуулдаг. Чухам ийм учир Назарбаев 2030 он гэсэн хөтөлбөртөө өрсөлдөх чадвар, эдийн засгийн төрөлжилтийг эрс дээшлүүлнэ гэсэн “амлалт” аваад байгаа юм.

Хөдөлмөр эрхлэлт. Монголын хүн амын 37 хувь нь албан ёсоор хөдөлмөр эрхэлж бусдыгаа тэжээдэг

бол баруун хөршид энэ харьцаа 49 хувьтай байна. Монголд нийт хөдөлмөр эрхлэгчдийн 15 хувь нь төсвийн байгууллагад ажилладаг бол зүүн хөрш Солонгост ердөө дөрвөн хувь нь төрд харьяалагдана. Харин баруун хөршид маань энэ үзүүлэлт 23 хувьд хүрчээ. Энэ нь Казахстаны дөрвөн ажилтны нэг нь татвар төлөгчдийн мөнгөөр цалинждаг гэсэн үг. Тиймдээ ч тэр үү тус улсын төсвийн алдагдал 3.4 тэрбум ам.долларт хүрч байв.

Төрийн оролцоо. Засгийн газрын өрийг ДНБ-д харьцуулж үзвэл манайд 28 хувь, харин баруун хөршид 2.5 хувь, зүүн хөршид 1.6 хувь байна. Казахстан бидний хажууд өргүй шахам улс аж. Төсвийн зардлыг эдийн засагт харьцуулсан үзүүлэлт манайд 40 хувь байсан бол баруун болон зүүн хөршид маань ойролцоо буюу 22 хувьтай байна. Хөршүүдтэй нь харьцуулбал, Монгол Улсыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай социалист улс гэж хэлж болохоор. Монголын Засгийн газар эдийн засгийнхаа 13 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг Татаас маягаар аж ахуйн нэгжүүдэд олгодог бөгөөд энэ нь татвар төлөгчдийн мөнгөөр үрэлгэн байдлыг санхүүжүүлж буй нэг хэлбэр юм. Гэтэл баруун хөршид энэ хувь 0.53 хувь, харин зүүн хөршид маань ердөө 0.06 хувь байна.

Зээлжих чадвар ба эрсдэл. Мэргэшсэн хөрөнгө оруулагчдын олон улсын байгууллагаас жил бүр улс орнуудын зээлжих чадварын үнэлгээ өгдөг. Хамгийн сайн оноо нь 100. Тэгвэл зүүн хөрш маань 77, баруун хөрш маань 54 оноо авсан байна. Харин бид 36 оноотой тууж явна.

Евромонигос улс орнуудын хөрөнгө оруулалтын эрсдэлийн үнэлгээ гарчээ. Эрдсэл даах чадвар хамгийн сайтай гэж үзвэл 100 оноо авна. Монголчууд ердөө 36 харин баруун хөрш маань 54, зүүн хөрш 78 оноо тус тус авсан байна.

Бүтээмж. Эдийн засгийн өсөлтийг бодит хөгжил болгож хувиргадаг гол хүчин зүйл бол бүтээмж. 2010 оны байдлаар дундаж монгол ажилтан жилд зургаан мянга орчим ам.долларын баялаг үйлдвэрлэсэн бол Казахстанд 18, харин БНСУ-д 42 хүрч байж. Монгол ажилтан цагт дунджаар таван ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол баруун хөршид 12, харин “зүүн хөрш”-д 25 байна. Монгол ажилтан цагт дунджаар 1.4 ам.долларын цалинтай бол баруун хөршид 4.4, харин зүүнд 12 байгаа юм. ▶▶

Ногоон эдийн засаг. Солонгост 1,000 ам.долларын баялаг (ДНБ) үйлдвэрлэхийн тулд 24 шоо метр ус ашигладаг. Тэгвэл Монгол 127 шоо метр болно. Харин Казахстанд 315 шоо метр буюу Солонгосынхоос 13 дахин их ус зарцуулж байна. Энэ бол нэн үрэлгэн хэрэглээ юм.

2008 оны байдлаар солонгосчууд дэлхийн агаар мандалд нийт 500 метр тонн нүүрс хүчлийн хийг цацжээ. Харин Казахстан 200 метр тонн, Монгол Улс ердөө 11 метр тонн хорт хий “үйлдвэрлэж”. Гэвч эдийн засгийн хэмжээтэй нь харьцуулж үзвэл өөр дүр зураг үзэгдэнэ. Нэг сая ам.долларын баялаг үйлдвэрлэхийн тулд Солонгост 513 тонн хорт хий ялгаруулсан бол Казахстан гурав дахин их буюу 1,511 тонныг ялгаруулжээ. Өөрөөр хэлбэл, баруун хөрш маань нэг хүнд оногдох нүүрс хүчлийн хийн үйлдвэрлэлээрээ зүүн хөршийнхөөс гурав дахин их байна гэсэн үг. Гэхдээ л бидэнтэй харьцуулахад



бага байгаа юм. Монголчууд нэг сая ам.долларын баялаг үйлдвэрлэхийн тулд агаарт 2,200 тонн нүүрс хүчлийн хийг цацдаг.

Боловсрол ба бүтээмж. 2009 оны байдлаар Солонгосын төр боловсролын салбартаа эдийн засгийнхаа 4.6 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийжээ. Харин Казахстанд 4.1 хувь байв. Монголд энэ тоо харьцангуй өндөр буюу 7.1 хувь байна. Гэвч хүнд нь хуваагаад үзвэл мөн л өөр дүр зураг тодорно. Солонгос улсын дундаж иргэн жилд 800 орчим ам.доллартай тэнцэх боловсролын үйлчилгээг төрөөсөө авдаг аж. Гэтэл Казахстанд энэ хэмжээ ердөө 290 ам.доллар байна. Гэхдээ энэ хэмжээ Монгол Улсынхаас хоёр дахин их байгаа юм. Учир нь, Монгол Улсын дундаж иргэн жилд ердөө 110 ам.доллартай тэнцэх хэмжээний боловсролын үйлчилгээг төрөөс авдаг ажээ. Солонгост бага ангийн багш дунджаар 24 сурагчтай ажилладаг байхад, манайд улсын дундаж нь 31 байгаа юм. Харин Казахстанд ердөө 16 байна.

2009 оны байдлаар Монголд бага ангийн багш жилд хоёр мянган ам.долларын цалинтай байсан бол банкны зээлийн мэргэжилтэн гурав дахин ихийг буюу долоон мянгыг авч байж. Харин Солонгост багш жилд 30 мянгын, харин банкир 26 мянган ам.долларын

орлоготой. Сингапурт ч мөн адил багшийн үнэлэмж өндөр. Харин баруун хөршид маань багш хүн жилд ердөө гурван мянган ам.долларын цалинтай байхад банкны зээлийн мэргэжилтэн зургаа дахин их буюу 18 мянган ам.долларын орлоготой байсан аж. Казахстанд багшийн үнэ цэнэ, багшийн хөдөлмөрийн үнэ цэнэ харьцангуй доогуур байна.

Уул уурхайгаас орж буй мөнгөө ашиглан Болашак хэмээх сангаар дамжуулан залуусаа гадаадад өндөр боловсрол эзэмшихэд нь ихээхэн анхаарч ирсэн. Тус хөтөлбөрөөр гадаадад сураад ирсэн залуус өнөөдөр Казахстаныг орчин үеийн өрсөлдөх чадвартай орон болгон хувиргах биз ээ. Мөн үндэсний хөрөнгө оруулалтын тусгай сангаар дамжуулж гаднын шилдэг менежмент, технологийг нутагшуулах зорилготой.

Улс төрийн эрх чөлөө, ардчилал. Казах гэдэг нь эрх чөлөөт гэсэн утга бүхий үг гэж зарим эх сурвалжид дурджээ. Улс төрийн ардчилалын хувьд хязгаарлагдмал хэдий ч, Казахстаны хувийн хэвшлийнхэн өнөөдөр монголчуудаас илүү их эрх чөлөөг эдэлж байна.

Нэгэн цагт Сингапур, Өмнөд Солонгосын туулаад өнгөрсөн хүчтэй төр бүхий капиталист тогтолцоог баруун хөрш маань туршиж байна. Энэ нь “хүчтэй гар”-ын дор улс төрийн тогтвортой байдал, мөн хувийн хэвшлийг дэмжсэн дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын бодлого гэх зэрэг юм. Баруун хөрш маань эдийн засгийн хүч чадлын хувьд адилхан социалист байсан зэргэлдээ орнуудаа олон талаар хол хаяжээ. Гэвч Азийн бар гэгдэх Солонгос эсвэл Сингапурын дайн

хүрч хөгжихөд нь томоохон бэрхшээл, сорилт байсаар байна. Тухайлбал, хүн амын эрүүл мэнд, багшийн үнэлэмж сул, эрчим хүч, усны үрэлгэн хэрэглээ, байгалийн бохирдол, судалгаа шинжилгээны салбар дорой болон харилцаа холбооны сул дэд бүтэц гэх зэрэг болно. Түүнчлэн залуус нь бодит баялгийг үйлдвэрлэдэг хувийн хэвшилд эрсдэл үүрэхээсээ илүү баялаг хуваарилдаг төрийн албанд орохыг илүү үзэх болжээ. Экспорт нь уул уурхайн түүхий эдээс хэт хараат болж байна. Уул уурхайн их мөнгө үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хөөс үүсгэх, мөн бусад салбарт ажиллах хүчний зардлыг өсгөх гэх зэрэг дарамт учруулж байгаа юм.

Эдгээр сул талуудын зэрэгцээ, асар их байгалийн баялгаа ашиглан хөгжингүй гүрэн болох зорилго тавиад буюу Назарбаевын Казахстан “Аж үйлдвэрээ хөгжүүлэх төлөвлөгөө”, “Казахстан 2030” гэх зэрэг хөтөлбөртэй. Тэр дагуу Балхаш, Жамбулд үйлдвэрийн томоохон цогцолборууд барина гэж зарлаад байгаа. Эдгээр төслүүдийн санхүүжилт хэдэн тэрбумаар хэмжигдэнэ. Энэ мөнгөний эх үүсвэрийг гадаадын хөрөнгө оруулалт гэж тооцоолж буй. Гэвч гаднынхны хувьд нэг том эрсдэл бий. Энэ бол Назарбаевын дараах Казахстан орныг хэн, хэрхэн авч явах вэ гэдэг тэрбум ам.долларын үнэтэй асуулт юм. ■



Хөгжил

Жижгээс том руу

Э.Зоригт

Дэлхийн хөгжлийн галт тэрэгнээс Долоо хоцорчихоод “хүүе хүлээгээч” хэмээн хий дэмий орилохгүйн тулд монголчууд галт тэрэгний зогсоол дээр зөв цагтаа, зөв тасалбараа бариад зогсож байх хэрэгтэй аж. Бидний тасалбар бол “Ногоон эдийн засаг”, цаг нь өнөөдөр. Тиймээс Монголын эдийн засгийн чуулганаар “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу” сэдэвт нэгдсэн хуралдаан болсон. Харин уг хуралдаанаар ногоон эдийн засгийн талаар хэн юу гэж хэлэлцсэнийг одоо уншигч танд хүргэе.

Юун ногоон, юун хүрэн буюу сэтгэлгээний өөрчлөлт

Д.Цогтбаатар /БОАЖ-ын сайд/:

-Ногоон эдийн засгийн талаар нэгдсэн ойлголт одоогоор байхгүй байна. Үүнтэй холбоотой ногоон эдийн засгийг тал бүрээс нь өөр өөрөөр харж томъёолдог. Ер нь зургаан зүйлийг бүрдүүлж чадвал түүнийг ногоон эдийн засаг гэх ойлголт бий. Үүнд, цэвэр эрчим хүч, ногоон барилга байгууламж, байгальд ээлтэй цэвэр тээвэрлэлт, усны менежмент, хогийн менежмент, газрын менежмент зэргийг бий болгох сайжруулах зэрэг багтдаг. Гэхдээ хамгийн гол нь эдгээрийг өөр хооронд нь холбох ногоон сэтгэхүй, хууль эрх

зүйн орчинг бүрдүүлэх буюу хоорондын уян холбоос чухал юм. Ногоон эдийн засаг гэдэг чинь товчхондоо энэ ертөнцөд өлмий дээрээ ирээд өлмий дээрээ явсан мэт байгаль эхийг хойч үедээ хэвээр нь үлдээх тэр чадварыг хэлж байгаа юм. Ногоон эдийн засгийг хүлээж авах сэтгэхүй бидэнд чухал. Өнөөдөр зарим улс орон ногоон эдийн засаг нь хөгжлийн саад гэж ойлгоод байдаг. Энэ бол буруу. Харин ч ногоон эдийн засаг гэдэг хөгжлийн цоо шинэ арга аргачлал юм. Мөн бидэнд мөнгө хэрэгтэй. Хэчнээн сайхан сэтгэлтэй байгаад ногоон эдийн засаг хөгжихгүй. Тиймээс бид мөнгө олох хэрэгтэй.

Д.Дэмбэрэл /УИХ-ын дарга/:

-Ер нь бидний өвөг дээдсээс уламжилж ирсэн уламжлал, мал аж ахуй зэргээс харахад монголчууд ногоон орчин, амьдралын талаар дэлхий нийтэд заах хэмжээний арга туршлагатай. Харин өнөөдрийн бидний яриад байгаа ногоон хөгжил, эдийн засаг гэдэг маань XXI зууны хөгжил дэвшилд зохицсон арай өөр ойлголт юм. Ногоон эдийн засгийн бодлого бол том. Гэхдээ хэрэгжих үйл явц нь жижгээс эхлэх хэрэгтэй. Сургуулийн цонхны тавцан бүр дээр цэцэг тавих ч юм уу. Ер нь аливаа зүйлийн эхлэлийг бид өөрсдийнхөө орчин тойрон, сэтгэлгээ зэргээс эхэлж дараа нь төрийн нэгдсэн бодлогоо хэрэгжүүлэх учиртай.

П.Цагаан /Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх/:

-Судалгаанаас харахад манай улс байгаль орчноо ихээхэн бохирдуулж байгаа орны тоонд орж байгаа. Тиймээс бид ногоон эдийн засгийг дэмжих цаг нь болсон. Үүний тулд сэргээгдэх эрчим хүчний аливаа санал санаачлагыг дэмжих хэрэгтэй. Мөн бид хэтэрхий үрэлгэн байна. Энэ нь биднийг ядуу, зүдүү байлгаад байгаа юм. Үрэлгэн гэдэг нь зөвхөн мөнгөний тухайд хэлээгүй юм шүү. Тухайлбал, бидний дунд дулаан хадгалах тухай анхаардаг хүн ховор. Харин ногоон эдийн засаг гэдэг дулааныг хадгалж чаддаг. Тиймээс ногоон эдийн засаг бидний хөгжлийн гарцаас гадна ядуу байдлаас гаргах том хөшүүрэг мөн.

Ч.Сайханбилэг /УИХ-ын гишүүн/:

-Өнөөгийн манай хүрэн өнгөтэй байгаа эдийн засгийг солонгорсон өнгөтэй, бусад салбараа дэмжсэн болгох хэрэгтэй. Ер нь ногоон эдийн засаг гэдэг хайр дурлал, аз жаргал гэдэгтэй адилхан хүн бүрөөрийнхөөрөө тайлбарладаг харьцангуй ойлголт. Миний ойлголтоор гурван гол хүчин зүйлээс хамаарах юм. Үүнд, эдийн засгийн үр ашгийг бий болгох. Гэхдээ энэ үр ашгийг байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар бүтээх ёстой. Мөн нийгмийн шударга ёс, тогтвортой байдал зэрэг болно. Манайхан аливаа зүйлд хэт туйлширдаг. Ногоон эдийн засаг гэхээр манайхан нэг хэсэгтээ л энэ талаар бүгд ярина, хошуурна. Гэхдээ бид энэ талаар арга туршлага хуримтлуулсан гаднын орнуудын алдааг нь гээж оносныг нь авах нь чухал. Энэ бол бидний боломж. ▶

▶ П.Эрдэнэжаргал /Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал/:

-Экологийн үр ашигтай байдал маш чухал. Хүрэн эдийн засаг нь ямар ч хамаагүй аргаар тооны араас хөөцөлддөг байсан бол ногоон эдийн засаг аль болох бага зардлаар эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагаа явуулах юм. Хамгийн гол нь бидний сэтгэлгээний өөрчлөлт чухал байна. Мөн төрийн бодлогын уялдаа холбоо чухал. Эдгээр нь бидний шийдэх ёстой тулгамдсан асуудал.

Д.Зоригт /ЭБЭХ-ний сайд/:

-Ногоон эдийн засаг гэдэг нь өнөөдөр бидний өмнө тулгамдсан асуудал юм. Өнөөдөр уул уурхайн компаниудын нөхөн сэргээгээгүй 4900 га талбай, Улаанбаатар хотын агаарын бохирдол зэрэг асуудлыг шийдэхээс эхлэх учиртай. Манай эдийн засаг нэгэнт уул уурхайтай холбоотой болсон учраас бид уул уурхайгаа байгальд ээлтэй ногоон болгох шаардлага байгаа юм. Харин энэ асуудлыг шийдэх хуулийн заалтыг биелүүлэхгүй, биелэлтэд анхаарал тавихгүй байна. Тиймээс хуулийн хэрэгжилтэд анхаарах хэрэгтэй. Бидэнд нэгдүгээрт, төрийн хяналт чухал. Тухайлбал, Мэргэжлийн хяналтын газрын хүн хүч, хөрөнгө мөнгөний асуудлыг шийдэж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг сайжруулах нь ногоон бодлогыг хэрэгжүүлэх нэн тэргүүний ажил юм.

Б.Бямбасайхан /“Ньюком” группын гүйцэтгэх захирал/:

-Ногоон эдийн засгийн талаар гурван Э гэх ойлголт бий. Энэ нь эрс багасгах, эргүүлж ашиглах, эдэлгээ уртасгах зэрэг юм. Үүнийг бид амьдралдаа нэвтрүүлэх хэрэгтэй. Тухайлбал, бид сүүн гэрэл хэрэглэх гэдэг ч юм уу. Энэ нь цахилгааныг 80 орчим хувь хэмнэдэг. Энэ мэт ногоон эдийн засаг жижгээс том хүртэлх өргөн ойлголт. Бидэнд бодлого байна уу байгаа. Тухайлбал, 2020 он гэхэд сэргээгдэх эрчим хүчээр нийт эрчим хүчний 20 хувийг хангах гэдэг ч юм уу. Харин түүнийг хэрэгжүүлэх хяналт үнэхээр муу байна. Энэ талаар яамдууд сайн дэмждэг. Харин доод шатандаа очоод гацаанд ордог. Нэг төсөл бариад очиход ямар нэгэн шалтаг заадаг. Энэ бол бодит байдал. Хамгийн түрүүнд үүнийг л шийдэх хэрэгтэй.

Хуралдааны үеэр олон санал санаачилга оролцогчдын зүгээс гаргасан. Зарим нь хүний чихэнд

содон басхүү шинэ байлаа. Тухайлбал, “Ногоон сан”-тай болох, “Ногоон зээл” олгох, Монгол Улс эрчим хүчний диваажин болох, мөн эрчим хүчний салбарт хувийн хэвшлийнхнийг оруулах гээд олон шинэ санаа гарсан. Ямартай ч нэгдсэн хуралдаанд оролцогчид ногоон эдийн засаг, ногоон хөгжил гэдэг бидний хөгжлийн

галт тэргэнд суух тасалбар гэдэгтэй санал нэг байсан юм. Д.Зоригт сайдын хэлсэнчлэн өнөөдөр бид нэгэнт галт тэргэнд суучихсан. Харин хаашаа залах вэ гэдэг чухал. Тиймээс нэгдсэн ойлголт, сайн хяналт шалгалт, хамтын хүчээр жолоо мушгих хэрэгтэй талаар хуралдаанд оролцогчид мөн хэлж байлаа. ■

Гадаад туршлага

Энгийн бүхэн ээлтэй

Х.Хулан

Бодит байдал

Өдөржин шөнөжин эвдэрсэн крантнаас дуслах ус, энд тэндгүй хөглөрөн агаар тэнгэрт хөөрөх хог хаягдал, уулын барааг харагдуулахгүй бүрхсэн утаа униар юуг өгүүлнэ вэ? Ногоон хөгжил бол ирээдүйн гарц, экологийн тэнцвэрт байдлын шийдэл мөн гэж

дэлхий дахинаа уриалах болсоор нэлээд хэдэн жилийн нүүрийг үзэж байна. Манай улсад ч мөн адил энэ чиглэлээр багагүй үйл ажиллагаа өрнүүлэн хэрэгжүүлж байгаа ч үр дүн нь үнэхээр чамлалттай хэвээр.

Йелийн их сургуулийн судалгаа

Иймд бид дахиад л энэ талаар хэлэлцэх хэрэгтэй болж байна. Гэхдээ ▶



► бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчидтай биш, харин эхлээд юуны өмнө иргэн бид тулж ярилцах цаг болжээ. АНУ-ын таван ерөнхийлөгчийг /ЖоржХерберт Уокер Буш, Жорж Уильям Буш, Уильям Жефферсон Клинтон, Жеральд Форд, Уильям Ховард Тафт нар/ төрүүлсэн Йелийн их сургуулиас Байгаль орчны гүйцэтгэлийн индексийг /Environmental Performance Index, IPE/ хамгийн сүүлийн байдлаар гаргасан байна. Тус индекс нь улс орнуудын Засгийн газраас явуулж буй байгаль орчны бодлогын хэрэгжилтийг хянадаг арга хэрэгсэл юм. Энэхүү жагсаалтад байгаль орчны гүйцэтгэл хамгийн сайн есөн орны тоонд Швейцари, Латви, Норвеги, Люксембург, Коста Рика, Франц, Австри, Итали, Англи, Швед зэрэг улс орон оржээ.

Хамгийн сул гүйцэтгэлтэй арван хоёр орны баян ходоодоор Ирак шалгарсан аж.

Манай улс урд болон хойд хөршийн хамт сул хэрэгжилттэй ангилалд орж, 107 дугаар байр эзэлжээ. Хамгийн сүүлд орсон Ирак 132 дугаар байранд байгаагаас харахад, манай улс мөн л хойгуур, байгаль орчны бодлогын хэрэгжилтийн үзүүлэлт нь талаар нэг таран салхинд хийсэж буй хамхуулийн адил байгааг илтгэнэм.

Бид яаж “ногоон” болох вэ?

Ногоон эдийн засгийг ойлгож дэмждэг, амьдрал дээр үүнийг цагаан “цаасан” дээр бус бодитоор хэрэгжүүлдэг эдгээр шилдэг орнуудын туршлагыг судалваас тэдэнд нийтлэг нэг л зүйл анзаарагддаг. Бүхэл бүтэн улс орны хөгжлийг дэлхийн тавцанд удирддаг тэрхүү зүйлийг илэрхийлдэг ганцхан шидэт үг байна. Тэр нь ердөө л ухамсар. Дэлгэрүүлж авч үзвээс, ард иргэдийн хүрээлэн байгаа орчиндоо хандах хандлага, тэдний сэтгэлгээний түвшинг харуулсан ухамсар /англи хэлнээ ecological awareness, герман хэл дээр Umweltbewusstsein/ юм.

Энэхүү орчин цагт “ухамсар” хэмээн томъёологдох зүйл монголчуудын хувьд газар доороос гэв гэнэт цойлон гарч ирсэн цоо шинэ зүйл биш ээ. Нүүдэлчин соёл иргэншилтэй монголчууд бидний өвөг дээдэс уул ус, газар нутгаа хайрлан дээдэлж, хамгаалсаар ирсэн бус уу? “Голын усанд бохир зүйл бүү оруул, галд хамаагүй юм хийж түлвэл гал бузартана, боловсроогүй жимс самар битгий түү, ан амьтны аминд хамаагүй бүү хүр” гэж цээрлэдэг байсан. Нүүдэлчин айл нүүсэн ч гэрийн бууцан дээр нь малын гаралтай, газар дэлхийдээ эргээд шингэх зүйл л үлддэг байсан.

Гэтэл өнөө үед Монголын хөдөө хээр газар ямар байдалтай байгааг Та бүхэн бүгд мэднээ. Дэлхийн өнцөг бүрээс цугларсан хог новшийн үлдэгдэл, аялагчдын замбараагүй хаясан хаягдал, тэр дундаа талын Монголын хөрсөнд шингэж чаддаггүй гялгар уут “чимэх” болсон. Иргэд өөрсдөө энэ тал дээр сэтгэл гаргаж анхаараагүй цагт хэчнээн зөв бодлого, шийдвэр гаргасан ч хэрэгжих үндэсгүй. Зөвхөн төр бус, иргэний нийгмийн бүлэг идэвхи чармайлт гаргаж байж байгаль орчны бодлогын хэрэгжилтийн үзүүлэлт сайжирна. Эвдэрсэн крантаа засуулж усаа ариглая, хогоо түүхий эдээр нь ангиланялгагдахин боловсруулах нь зөв юм байна шүү, дэлгүүрт даавуун уутаа авч орж байя, нэг удаагийн хэрэглээний эд анги худалдан авахаас татгалзая, хүн бүр машинтай байх шаардлагагүй юм байна гэж бодох таны хувьд тийм хэцүү юу? Энэ бол зөвхөн таны ухамсраас л шалтгаалах зүйл. Та өөрийн хэвшиж ирсэн хувийн хэрэглээгээ илүүчилсэн сэтгэлгээгээ өөрчлөхөд байгаль орчинд хэмжишгүй том хувь нэмэр оруулах боломж таны гарт байна. Энгийн бүхэн экологид ээлтэй. Германы “Цайт” /Die Zeit/ сонин эрхлэгчээр олон жил

Байгаль орчны гүйцэтгэлийн индекс /EPI Rankings/		
Хамгийн сайн хэрэгжилттэй	1. Швейцари 2. Латви 3. Норвеги	76.69 70.37 69.92
Сайн хэрэгжилттэй	11. Герман 12. Словак 13. Исланд	66.91 66.92 66.28
Дунд зэргийн хэрэгжилттэй	47. Гүрж 48. Австрали 49. АНУ	56.84 56.61 56.59
Сул хэрэгжилттэй	106. Орос 107. Монгол 116. Хятад	45.43 45.37 42.24
Хамгийн сул хэрэгжилттэй	130. Узбекистан 131. Туркменистан 132. Ирак	32.24 31.75 25.32

Эх сурвалж: <http://epi.yale.edu/>

ажилласан сэтгүүлч, язгууртан гаралтай хатагтай Марион Дёнхофф /1909-2002/ ингэж хэлсэн байдаг “Хүн бүр нийгмийн төлөө хариуцлага үүрэх учир зөвхөн өөрийн амьдралаа битгий бодооч ээ. Иргэдийн дуу хоолойг нийлүүлж багтаасан нийгмээс илүү сайн нийгэм гэж байхгүй”. Мөн ХБНГУ-ын Байгаль орчны яамнаас 2010 онд гаргасан “Байгаль орчноо ухамсарласан байдал” нэртэй судалгаанд оролцогсдын 85 хувь нь “Сэргээгдэх эрчим хүчинд шилжих явдал зайлшгүй” гэж үзсэн байна. Түүнчлэн 2006 онд судалгаанд хамрагсдын 39 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийг зогсоож чадна гэсэн байсан бол 2010 онд энэхүү өөдрөг үзэлтнүүдийн тоо 56 хувь болж өсжээ. Германы хүн амын хувьд дотооддоо амрахад байгалийг чухалчилсан байна. Ялангуяа 30-аас дээш насны хүмүүс байгальд амралтаа өнгөрүүлэх нь амьдралын чанарын баталгааны чухал хэсэг гэж тооцдог гэнэ.

Энэ бүхэн юуг илтгэж байна вэ гэвэл ногоон улс орнуудын иргэд хүрээлэн буй орчиндоо анхаарал тавьж, амьдрах орчноо хүн өөрөө л хамгаалж байж ирээдүйгээ хамт бүтээлцэнэ гэдгийг ухамсарласныг харуулж байна. Иргэн Та “ногоон” болоход амархан. Гагцхүү Та нүдээ нээх л үлдлээ. ■



Уул уурхайг
Улс төрөөс тусгаарлая!



Шоо зурагийг А.Амарсайхан

“Discover Mongolia”

Хүлээлт буюу “Хэлсэндээ шүү”

Б.Баяртогтох

Уул уурхайгүйгээр Монголын маргаашийг төсөөлөөд үзэх үү. Хамгийн түрүүнд төсвийн орлого ганхаж, төрийн сан хоосрох болов уу. Цаашилбал, уул уурхайг бараадсан дагалдах салбарууд уналтад орж ажилгүйдэл нэмэгдэх нь мэдээж. Боловсрол, эрүүл мэнд зэрэг үйлчилгээний салбар хөрөнгө оруулалтаар гачигдаж, цалингаа ч тавьж чадахгүйд тулах вий. Юун эдийн засгийн өсөлт, өсөх бус буурах үзэгдэл эрчимжих нь дамжиггүй. Бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл хөтөлбөр хий хоосон цаас болон шарлана. Уул уурхайг “саалийн үнээ” болгосон аж ахуйн нэгж, зөвхөн уул уурхайгаас 90 гаруй хувь нь хамаарсан Монголын эдийн засаг хад мөргөнө. Тэгвэл Монгол Улс уул уурхайг үл тоолоо гэхэд юу болж болох вэ.

“Уул уурхайн салбараа авръя” хөдөлгөөний тэргүүн Б.Агваандондов “Улстөрчид нам хоорондоо улс төр хийдэг байсан бол одоо улс орны тэргүүлэх салбараар улс төр хийдэг болжээ” гэв. Үгүйсгэж, баллуурдсан ч уул уурхайн салбарын хувь нэмэр манай улсын эдийн засагт даанч их болох нь маргашгүй үнэн. Гэтэл сүүлийн үед уул уурхайн салбарт

улстөржилт хэт явагдах хандлага бий болсонд салбарын мэргэжилтнүүд нэлээд болгоомжилж байна.

Өнгөрсөн хугацаанд зөвхөн уул уурхайгаар овоглосон цөөнгүй томоохон чуулга уулзалт Монголд болов. Эдгээр чуулга уулзалтаас ихэнх хөрөнгө оруулагчид улс төрийн эрсдэл, түүнээс хамаарсан хууль, дүрэм, журамд хавчигдаж байгаагаа нуусангүй. Учир нь, Монголын төр гаргасан хуульдаа хариуцлагатай, судалгаа тооцоотой хандаж гэмээнэ манай улсад тогтвортой хөрөнгө оруулалт, урт удаан хугацааны төсөл хөтөлбөр хэрэгжих боломжтой болохыг онцолж байлаа. Өнгөрөгч арваннэгдүгээр сард болсон “Металс Монголиа-2011” чуулга уулзалтын үеэр ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “Монгол Улсын Засгийн газар экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг тус орны эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон. Тиймээс хөрөнгө оруулагчдад байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх таатай нөхцөл бүрдүүлэхийг чухалчилж байна” хэмээн чуулганыг нээж байсан.

Гэтэл уул уурхайн салбарын хөгжилд чөдөр болсон “Урт нэртэй хууль”-иас улбаатай таагүй уур амьсгал бүрдсэн нь хөрөнгө оруулагчдын сэтгэлийг хөргөж байгааг “Гложекс” группын ерөнхий захирал Л.Наранбаатар хэллээ. Энэ оны эхэнд болсон “Коал Монголиа-2012” чуулга уулзалтын оролцогчдын хувьд ч тэр Монголыг хууль эрх зүйн болоод бизнесийн орчноо тогтвортой байлгаасай гэцгээж байсан.

Улс төргүй уул уурхай

Уул уурхайн салбар улс төргүй, улс төр нь уул уурхайгаар бага амьсгалах учиртайг судлаач Б.Оюунбилэгт хэлсэн юм. Харин ирэх сонгуулийн өмнө уул уурхайн салбарт “сонин юм” болох вий гэхээс уул уурхайн салбарынхан эмээж сууна. Хөрөнгө оруулалтын зах зээлийг сэдрээсэн, уул уурхайн салбарын хөгжлийн хэмнэлийг алдагдуулсан шийдвэрийг гаргах вий гэдгээс л санаа зовниж байгаагаа Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгс онцолсон. Түвшинтөгс багшийн хэлснээр судалгаа тооцоогүй, зөвхөн хувийн эрх ашгийг нэгд тавьсан улс төрийн дайралт уул уурхайн салбарын

хөгжилд гар дүрж, хутган үймүүлэх нь манайд ашиггүй. Харин ч ихээхэн хохиролтой болохыг тайлбарласан юм. Өөрөөр хэлбэл, Монголын төрд үүссэн нөхцөл байдал, хэт улстөржилт, гаргасан хууль дүрэм, гэрээ, журмаа зөрчих нь хэзээ ч сайн зүйлд хүргэхгүйг эдийн засагчид хэлж байна. Тэгвэл бидний ярих дуртай тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхай хаанаас эхлэх вэ гэсэн асуудлыг нухацтайхан бодоод үзье. Баталсан хууль, гаргасан журмаа үл тоомсорлох нь манай төрийн “олон ааш” хэдий ч зах зээлийн тоглоомын дүрэм биш аж. Нэг үгээр хэлбэл, хариуцлагатай уул уурхай хариуцлагатай төрөөс эхэлдэг байна.

Өнөөдрийн байдлаар ашигт малтмалын газарт бүртгэлтэй 1200 гаруй ашиглалтын лицензийн 400 гаруйг нь одоо ашиглаж байгаа ажээ. Мөн уул уурхайн боловсруулах үйлдвэрийн салбарт 200 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай цаашид Тогтвортой байдлын гэрээ байгуулах хуулийн төслийг боловсруулсныг Зоригт сайд хэлсэн удаатай. Мөн хүнд аж үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортлоход гаалийн татвараас чөлөөлөхөөр болсон байна. Гэтэл сонгуулийн өмнөхөн ийнхүү хэлсэн ярьсан зүйлээ мартаж вий гэдгээс л уул уурхайн салбарынхан болгоомжилж байгаагаа хэллээ. Хэрвээ энэ нь сонгууль угтсан хоосон шоу яриа төдий өнгөрвөл монголчууд яах вэ, ертөнцийн анхаарлын төвд Монголыг аваачсан уул уурхайн салбарын хөгжил чөдөрлөгдөнө гэсэн үг. Нэг үгээр хэлбэл, Монголын улс төрчдийн ямар шийдвэр гаргах, гаргасан шийдвэр, амласан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэхийг нүдээ бүлтийлгэн, чихээ дэлдийлгэн харж суугаа гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд энэ нь тун чухал. Хэрвээ сонгуульд хөтлөгдөөд манай төр, засгийнхан уул уурхайтай холбоотой хөнгөн хуймгай шийдвэр гаргавал магадгүй дэлхий Монголоос татгалзаж мэдэхийг санах хэрэгтэй. Энэ салбарын Монголын эдийн засагт оруулж буй үр өгөөжийн зах зухаас дурдвал, зөвхөн өнгөрсөн онд л гэхэд 8700 ажлын байр уул уурхайн салбарт шинээр бий болж, нийт 50 гаруй мянган хүн ажиллаж байгаа аж.

Энэ салбарт “За л бол ёогүй”

Хэн нэгэнд “За” гээд хэлчихсэн бол түүнийгээ биелүүлэх гэж, амласандаа хүрэх гэж зүтгэдэг нь хүний ёсон.

Үүнтэй адил төр, засаг ч тэр “За” л гэсэн бол ёогүй занд суралцахын төлөө, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд ажилладаг байх учиртай. Гэтэл Монголын төрийн хариуцлагагүй байдал хүрээгээ тэлж, гаргасан хуулиндаа хүртэл засвар хийдэг тухай улстөрчид өөрсдөө ярьдаг. Ийм ёс зүйгүй байдал нь гадаадын хөрөнгө оруулалтыг бөөн бөөнөөр нь хуйлруулж, Монголын эдийн засгийг сөгийтөл нь дээш татаж гаргаж ирсэн уул уурхайн салбарт ихээхэн муу уршигтай зүйл юм. Түүнээс биш, монголчууд дотроо хууль тогтоогчид хуулиа засдаг, засдаггүй тухай яриад өнгөрөх өөр хэрэг.

“Төр нэгдүгээрт үйлчлэх, туслах л ёстой. Хоёрдугаарт, төр хуулиа хэрэгжүүлэх учиртай. Өөр олон юм руу орж, ард түмэн, улс орныхоо амьдралд хүндрэл учруулж болохгүй” хэмээн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн удаатай.

Манай улс хүний хөгжлийн үзүүлэлтээрээ дэлхийн 169 орноос 100 дугаар байранд, өрсөлдөх чадвараараа 143 орноос 96-д багтаж байгаа гэх. Үүнийг ҮХШХ-ны дарга Ч.Хашчулуун “Энэхүү өсөлт нь уул уурхайн салбарын хөгжилтэй холбоотой боловч дэд бүтцийн салбарын хөгжил сул байна” хэмээн дүгнэсэн. Уул уурхай хэрэв хөгжөөгүй бол Монголын эдийн засагт өнөөдрийнх шиг өсөлт гарахгүй нь лавтай.

ЭБЭХЯ-ны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү “Хүн болгон уул уурхайг

шүүмжилдэг болчихсон. Мэддэг болсон. Харин одоо газар тариалангийн салбар шиг уул уурхайн салбараа дэмжих л үлдлээ. Хүний нүдэнд бол муу муухай салбар болж харагдаад байдаг. Энэ чинь Монгол Улсыг тэжээж яваа салбар” гэв. Тэрбээр уул уурхайн салбараа харааж зүхмээргүй байна. Ерөөж сууя гэсэн юм. Харин ерөөж суухад хөрөнгө оруулагчдын зүгээс “хэлсэндээ шүү” гэсэн ам тангараг, өчгийг төрөөс нэхэж байгааг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа учирлав.

“Behre Dolbear” группын ерөнхийлөгч Бернард Гуарнерра “Уул уурхайг хөгжүүлэе гэвэл төрийн оролцоогоо багасгах хэрэгтэй. Намайг 2005 онд ирэхэд Монголын хууль эрх зүйн орчин тогтвортой байсан. Гэтэл 2006 оноос тогтворгүй болж эхэлсэн. Одоо ч ялгаагүй” гэж ярьсан нь бий. Татварын хэмжээ, лиценз олголт, хууль дүрэм тогтворгүй, барьц муутай байгааг тэрбээр өнгөрсөн жилийн “Дисковер Монголиа” чуулга уулзалтын үеэр тайлбарласан юм.

Түүнээс хойш ямар шинэчлэлт өрнөсөн бол. “Танай хууль хатуу чанга байх нь хамаагүй. Энэ бол танай мэдэх асуудал. Хамгийн гол нь хууль дүрмээ тогтвортой байлгаж өгөөч” гэдэг санал Ашигт малтмалын газарт хамгийн их ирдэг байна. Уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинд ямар таатай, баярлууштай өөрчлөлт гарсан талаар Та дуулсан уу. Уул уурхайн нэгдсэн хуультай болох тухай сонсогдсон боловч таг чиг. ■

Байгалийн орлогын зохистой удирдлага

Төрөлжиж чадаагүй эдийн засагт үлэмж орлого тогтохгүй

Б.Алтай

Алдах эрхгүй улс

“Байгалийн асар их баялагтай байна гэдэг “лүд” юм. Өвөлжөөний дэргэд өнөөдөр хайгуул хийгээд л, маргааш нь тэнд уурхай нээчихэж байна” хэмээн Дундговь аймгийн Сайнцагаан сумын дөрөвдүгээр багийн малчин Б.Адъяа халагласан

юм. Тэрбээр Монголын эдийн засгийн чуулганд оролцохоор ирсэн малчин түмний цорын ганц төлөөлөл. Малчин Б.Адъяа Эдийн засгийн чуулганд оролцохдоо “Байгалийн орлогын зохистой удирдлага, эдийн засгийн төрөлжилт” сэдэвт салбар хуралдааны гол төлөөлөгч байсан нь учиртай. Өдийд хаврын тарчиг цаг. ►

▶ Мал төллөх гээд түмэн ажил ундрах цагаар хөвөнтэй дээлтэй хашир бор өвгөн яагаад Монголын эдийн засгийн форумыг зорьж ирээ юм бол. Эндээс л уул уурхай, ухаж төнхөх түрэмгийлэл нь хөдөө аж ахуйн салбарт тулгамдсан асуудал болон хувирч байна. Монгол Улс газар тариалан, уламжлалт салбараа зөвхөн уул уурхайгаар солих, эс солих салаа замын уулзварт ирээд буй нь энэ. Хэдий малчин боловч эдийн засагч мэргэжилтэй өвөө ардчилалын гал дөлийг хөдөө, орон нутагт бадрааж явжээ. Адъяа малчин уул уурхайн өнөөгийн дүр зурагтай эвлэрч чадахгүй, дотроо шаналж, гаднаасаа эмтэрч, элэгдэж яваагаа нуусангүй. Олон төрийн нүүрийг үзсэн, зуд турхан, ган гачгийг ч юман чинээ бодолгүй даван туулж ирсэн тэрбээр Монголын эдийн засгийн чуулганд хоёр өдөр саатсан. Баялагтай хэдий ч буруу замаар будаа тээж, баларсан орны жишээ цөөнгүй бий. Манайх харин аль замаар нь явна вэ.

Дэлхийд уул уурхайгаар замнасан орнууд өдгөө эдийн засгаа төрөлжүүлэх тухай асуудлыг хөндөцгөөж байна. УИХ-ын гишүүн С.Оюун “Уул уурхайгаа түшиглээд орлого олж чадах юм уу? Чадах юм шиг санагдаж байгаа боловч баталгаа байхгүй шүү дээ” гэв. Баялгийн хуваарилалт гол нь зөв ашиглаж чадах юм бол тэр бүр хаа хамаагүй улсад олдоод байдаг боломж ч биш. Газрын хэвлийдээ маш олон төрлийн байгалийн баялаг нуусан Монгол орон боломжоо хэрхэн алдахгүй атгаж, ухаантай ажиллах вэ гэдэг л хамгийн чухал байгаа юм. “Аль нэг тал руугаа туйлшрахгүй, төвийг сахисан эдийн засгийн зөв бодлого явуулбал байгалийн баялгаас орлого

олж чадах байх” хэмээн С.Оюун хэлсэн. Гэхдээ орлого олж болно. Гагцхүү олсныгоо зөв зарцуулж, эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлж чадах эсэх л өнөөдөр хэний ч хэлж мэдэхгүй хариулт нэхсэн асуулт болон Монгол Улсын өмнө тулгарч байна. Өөрөөр хэлбэл, нэг салбараас хамааралтай эдийн засгийн эрсдэлээ үүрч дүүрч гарах арга ухаан нь сайн засаглал болохыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж онцлов. “Байгалийн баялгийн орлогоо зөв зарцуулах нь олдож буй цор ганцхан боломж. Баялаг дахиж ургахгүй. Бид алдах эрхгүй. Баялгийн орлогын хуваарилалт тэгш бус байвал нийгэмд тогтворгүй байдал авчирна” хэмээн Нээлтэй нийгэм форумын судлаач Н.Дорждарь хэлсэн байдаг.

Хөлөө олж, гараа нийлүүлнэ


Эдийн засгийн форумд оролцогчид шударга төр, сайн засаглалын асуудлыг олонхи нь хэлэлцэж, цөөнх нь санал нэгдэв. Нэг үгээр хэлбэл “Засаглалын технологи манайд алдагдсан” гэж МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл дүгнэсэн юм. Мөн Байгалийн баялгийн сангбайгуулах асуудал оройтож байгааг эдийн засагчид тайлбарлаж байсан. Бий болж буй баялгийн орлогоо төр нь зөв хөрөнгө оруулалтад зориулдаг байхыг л зохистой орлогын сайн менежмент хэмээн мэргэжилтнүүд тодорхойлж байна. Хүний хөгжил сан, Тогтворжуулалтын санг ирээдүйгээ харсан, урт удаан хугацаанд оршин тогтнох нь баталгаагүй гэж үзэж байлаа. Мөн төсвийн тэлэлтийг хязгаарлахгүй бол баялгийн орлого урсаад өнгөрөх эрсдэл байгааг хэллээ.

Нүүрсний чиглэлээр хамгийн их талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аймгууд /талбай,мян.га/



Дорноговь	37.8
Багануур	4.8
Говьсүмбэр	4.4
Төв	3.4

Дэлхийн хамгийн их нүүрсний нөөцтэй улс /тэрбум.тн/



Эх сурвалж: АМГ

Үйлдвэрлэл бус үйлчилгээний салбар ноёлж буй манай орон үйлчилгээнд суурилах нь хэврэг эдийн засгийн дохио болохыг ИБУИНВУ-ын Велфаст хотын Хатан хааны их сургуулийн эдийн засгийн профессор, эдийн засагч Г.Рагчаасүрэн санууллаа. Өөрөөрхэлбэл, үйлдвэрлэлийн салбар дорвитой хөгжихгүй байгаа нь манай улсын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлнө гэсэн үг. Цаашилбал хэзээ ч Монгол Улс экспортлогч бус импортлогч орны байр сууриндаа гүн шигдэх сул талтай юм байна. Тиймээс хөрөнгө оруулалтын хөлөө зөв олж, гараа нийлүүлэх нь төрийн бодлогоос шууд хамааралтайг Рагчаасүрэн онцолсон юм. Тэрбээр монголчууд хөдөлмөрийн бүтээмжээ дээшлүүлэх шаардлагатай байгааг ч дурдлаа. Орлогоо тэгш хуваарилж, хүртээмжтэй өсөлтийг хүртэж, хангалуун сайхан амьдрах нь монголчуудын хүсэл. Ирэх цагийн хүлээлт, бас тэмүүлэл. Тиймээс баяжихаасаа өмнө нь хөлсөө гаргах хэрэгтэйг эдийн засагчид хэлж байна. ▶



Төр бол өөрөө асуудал

“Монголын хувьд улс төр хамгийн том эрсдэл болчихоод байна. АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рейганы хэлсэн сайхан үг байдаг. “Төр бол өөрөө асуудал” гэж. Монголын нөхцөлд би төр бол эрсдэл гэж хэлнэ. Төр Монголын нөхцөлд аюул болох тал руу хэлбийж байна” хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж эдийн засгийн чуулганд тавьсан илтгэлдээ онцолсон юм. Ерөнхийлөгчийн хэлснээр уул уурхайн салбараас орж буй хөрөнгө мөнгөний чимээ хаана гацаж, хаашаа цутгаад байна вэ. Өрхийн орлого нэмэгдэж, ядуурал буурсан уу. Ажилгүйдэл цөөрөв үү. Энэ бүгдэд хариулт болох базаатай тоон мэдээлэл, бариад авах баримт даан ч алга. ҮХШХ-ны дарга Ч.Хашчулуун “Боловсруулах үйлдвэр байгуулах. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбараа дэмжих. Аялал жуулчлал, Мэдээлэл харилцаа, Био технологи, дэд бүтцийн салбараа хөгжүүлснээр эдийн засгаа төрөлжүүлнэ” гэлээ.

Гэтэл яг одоо манайд өөрийн бүтээж, үйлдвэрлэж байгаа зүйл ховор байгааг бараг л хүн бүр хэлж буй. Тэгвэл Хашчулуун даргын хэлсэн тэр олон үйлдвэрлэлийн салбарын шанг хэзээ татах бололцоотой, юунд нь хэдий хэмжээний хөрөнгө санхүүжилт шаардлагатай байгаа, түүнийг хаанаас хэзээ гаргах боломжтой вэ гээд хариулт нэхсэн асуулт олон.

Монгол импортлогч орны шаварт улам шигдэхгүйн тулд үйлдвэр олноор барих шаардлага цаг хугацаа өнгөрөх тусам улам бүр тодорч буй. Гагцхүү байгалийн баялгаас орох орлогоос тэдэн үйлдвэр барина гэсэн бодит тооцоо үнэндээ алга нь форумын үеэр бүр ч тод харагдав. Оюутнуудад сар бүр 70,000 төгрөг өгч, цэнгээний газрын бизнесийг цэцэглүүлж байхын оронд тэр мөнгөөрөө ганц үйлдвэр ч гэсэн барьж байсан бол аштай юу даа гэж бодогдоно. Улс төр үнэхээр Монголыг “алж” байна гэж харамсаж, халаглах хүн тус хурлын үеэр цөөнгүй таарч байсан.

Долоон өнгө

УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэг “Уул уурхайн салбараас гадна дагалдах, дагуулах улс орны эдийн засагт тэргүүлэх үүрэгтэй оролцох долоон салбарыг тусгайлан хөгжүүлэх шаардлагатай” гэв. Уламжлалт

хөдөө аж ахуй, газар тариалан, гар урлалын салбараа дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэл хөгжихөд төр хаалт бус гишүүр болох учиртайг ч салбарынхан хэллээ. Мөн баялгийн тэгш хуваарилалтыг бий болгохын тулд санхүүгийн зах зээлээ хөгжүүлэх, аж үйлдвэрлэлийн салбараа хөл

дээр нь босгосноор ажлын байрыг нэмэгдүүлэх учиртайг мэргэжилтнүүд тэмдэглэж байв. Өөрөөр хэлбэл, төр тэгш хуваарилалтыг тэгш боломжоор олгох хэрэгтэй хэмээн МҮХАҮТ-ын тэргүүн С.Дэмбэрэл хэлсэн юм. Тэгвэл тэгш хуваарилалт нь сайн засаглалаас улбаатай ажээ. ■

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

Монгол Улс баялгийн орлогоо хэрхэн зөв удирдаж сурах вэ?

Г.Рагчаасүрэн /ИБУИНВУ-ын Велфаст хотын Хатан хааны их сургуулийн эдийн засгийн профессор/:



“Олсон орлогоо бид зөв удирдах тухай асуудлыг өнөө жилийн эдийн засгийн чуулганаар хөндөн ярилцсан. Нэг үгээр хэлбэл, зарлагаа хэрхэн удирдах вэ. Монгол хэмээх өрх айлын зарлагыг хэрхэн зөв зохистой авч явах вэ гэдэгт л асуудлын гол нь оршиж байна. Уул уурхайн салбараас орж ирэх орлого бол ойлгомжтой. Харин олсон орлогоороо хэрхэн хүртээмжтэй өсөлтийг бий болгож, эдийн засгаа төрөлжүүлэх нь бодлого, зарчмаас шууд хамааралтай. Баялгийн орлого бусад салбартаа хэрхэн нөлөөлж байгааг, цаашид эдийн засгийн тэргүүлэх чиг хандлагаа ч одооноос олон тулгуурт

эдийн засгийн хэв маяг руу аваачихгүй бол дангаар уул уурхайд найдаж болохгүй юм. Капиталын бүтээмж хөрөнгө оруулалт буюу боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт хийх нь зөв зохистой хуваарилалт. Ингэснээр салбар болгоныг хөгжүүлэх боломж нээгдэж байна. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардал бусад оронтой харьцуулахад өрсөлдөгч чадвартай л байх юм бол энэ салбар тунаж үлдэнэ. Байгалийн баялгаас орж ирж байгаа орлого бидний үеийнхэн хэрэглээд дуусах бус хойч үедээ өвлүүлэх өв хөрөнгө. Тиймээс манай улсын хөдөлмөрийн бүтээмж өндөр байж гэмээнэ өрсөлдөх чадвар бэхжинэ. Өрсөлдөх чадвар сайн байснаар орлогоо удирдаж, захирч сурна.

Д.Даваасамбуу

/УИХ-ын даргын ахлах зөвлөх/:

“Нэгдүгээрт, олон улсын байгууллага, хүмүүстэй худалдаа хийх чадвартай байх хэрэгтэй. Дэлхийг мэддэг байх хэрэгтэй. Тэгэхгүй юм бол байгалийнхаа баялагт өндөр үнэ тогтоож чадахгүй. Хүнтэй хэлэлцээр хийхээрээ дэлхийн жишгийг мэдэхгүй байж таарахгүй. Нүүрсний үнийг дэлхийд ямар газрын үнээр жишиг болгож зардаг ▶



гэдгийг тодорхой мэддэг байх хэрэгтэй. Байгалийн баялгаас бид орлогоо бүрэн авч чадаж байна уу гэдэг эндээс эхэлнэ. Удирдаж чадах эсэх үүнээс хамаарна. Хоёрдугаарт, авсан орлогоо зөв зарцуулж чадаж байна уу. Гуравдугаарт, шавхагдах баялаг учраас нөөц нь дуусна. Нөөц шавхагдсаны дараа бид яаж, хэрхэн хөгжих юм

бэ. Ямар салбарыг бий болгосон байх ёстой юм бэ. Гурван том асуудал байна. Тиймээс татварын алба, эдийн засгийн хяналтын алба нь сайн ажиллах ёстой. Эрх мэдэл бүхий хүмүүс нь олсон орлогоо тодорхой мэдүүлэх учиртай. Хамгийн их нөөцтэй нүүрс, зэсээ боловсруулж нэмүү өртөг шингээх нь чухал. Эцэст нь хүний хөгжилдөө анхаарах хэрэгтэй. Улс төрийн хувьд засаглалтай байх ёстой.

Х.Владимир /Эрдэс баялгийн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/



-Байгалийн баялгийн зохистой удирдлага баялгийн үнэ цэнээс л эхэлнэ. Монголд өнөөдөр байгалийн баялаг руугаа хэт дайрч, довтолсон өлсгөлөн шинж давамгайлж байна. Ямар ч зохистой удирдлага алга. Манайх асар их баялагтай болов ч байгалийн баялгаа үнэлж чадахгүй байна. Зах зээлийн эдийн засагт

шилжсэн хэдий ч үнэндээ яаж шилжиж байгаа гэдгээ ч ойлгохгүй байна. Тэгэхээр зах зээлийн эдийн засгаасаа л эхлэх хэрэгтэй. Зах зээлийн эдийн засаг гэдэг чинь хөрөнгийн зах зээл. Хөрөнгийн зах зээл нь Монголд хөгжөөгүй учраас зах зээлийн эдийн засаг хөгжсөнгүй.

Дэлхийд баялгийн ашгаас иргэдэд хэрхэн үр дүнтэй хүртээх хоёр арга бий. Нэг дэх нь, хувьцаа эзэмшүүлэх, хувьцаагаар дамжуулж ногдол ашиг хүртэнэ. Эсвэл зах зээлд эргэлдэж байгаа хувьцааны борлуулалтаар ашиг олох боломжтой. Хувьцаа бол хөрөнгө оруулалтын эрхийн бичиг болохоос үнэгүй тараадаг цаас биш шүү дээ. Хоёр дахь нь, аль ч улсад байдаг нөөцийн татвар. Тиймээс манайх нөөцийн татвараа оновчтой тогтоох хэрэгтэй. Алт, зэс, нүүрсээ тухайн ордтой холбож тогтоох нь чухал. Гэтэл манайх нэгдсэн стандартаар нэг тоо тавьчихдаг. Түүгээрээ 30 жилээр гэрээ хийчихдэг. Тэгэхээр тэндээс орлого орж

ирэх үү гэдэг асуудалтай болж байна. Нөөцийн орлого дээр түшиглэсэн сан байгуулах хэрэгтэй. Сангаар дамжуулж баялгийн орлогоо удирдаж чадна. Түүнээс засаглал сул оронд хүртээмжтэй өсөлт гарахгүй. Харин сангийн хөрөнгийг зах зээлд эргэлдүүлж, түүний өссөн хэмжээнээс ард иргэддээ орлого хуваарилах боломж бий. Энэ чиглэлээр ажилласан олон сан бий. Жишээ нь, Чили, Алексийн сан.

Алишер Али /“Евразиа Капитал” хөрөнгө оруулалтын банкны захирал/:



-Асар их баялагтай байх нь том завшаан. Гэвч юун түрүүнд уул уурхайг тэргүүлэх чиглэлээ болгоод буруу менежмент, бодлогоосоо болоод баларч, доройтсон олон орон байдгийг санаж, гашуун туршлагаас нь суралцах хэрэгтэй. Жишээ нь, Нигери байна. Газрын тосны асар их баялагтай, түүнийгээ тэргүүлэх чиглэл болгосон ч өнөөдөр тус улсын хүн амын 90 гаруй хувь нь ядуу, улс орон нь өрөндөө баригдчихсан.

Үүний эсрэгээр сайн жишээ ч олон байгаа. Үүний нэг нь Чили. Чили бол дэлхийн хамгийн том зэсийн экспортлогч. Үүгээрээ Монголтой их ойрхон жишээ. Хэдхэн жилийн дараа Монгол Улс зэсийн хоёр дахь томоохон экспортлогч болно.

Чилийн хувьд нэг сонирхолтой тоо баримт бий. Тус улсын хөгжлийн хөдөлгөгч хүч нь болсон уул уурхайн салбарт хүн амынх нь хэдэн хувь нь ажилладаг гэж бодож байна. Ердөө тавхан хувь нь. Тэгвэл үлдсэн 95 хувь нь юунд найдаж амьдардаг вэ. Өмнөд Чили улс дэлхийн тэргүүлэх дарс импортлогчдын нэг болсон. 20 жилийн өмнө уул уурхайгаас орж ирсэн хөрөнгө дээрээ түшиглэн хөгжүүлж байсан энэ салбар өнөөдөр өөрийн гэсэн дэлхийд үнэлэгдсэн технологитой, орон зайтай, хэрэглэгчидтэй болсон байна. Өөр нэг сонирхолтой баримт гэвэл Чили улс дэлхийн яргай загасны хэрэгцээний дөрөвний нэгийг хангадаг. Мөн л уул уурхайгаас орж ирсэн хөрөнгөөр өдий зэрэгтэй болтлоо хөгжсөн. Одоо энэ салбар тэрбум тэрбум ам.долларын орлогыг улсдаа оруулж, хэдэн зуун мянган ажлын байр бий болгоод байна. Үүнтэй адил Монголд уул уурхайгаас гадна дэлхийд өрсөлдөх чадвартай болгож хөгжүүлэх боломжтой олон салбар бий. Жишээ нь, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Үүнээс гадна Монголын хөдөө аж ахуйд дэлхийд хүчтэй өрсөлдөгч байж чадах асар их нөөц боломж бий. Наад захын жишээ, зөвхөн махны экспортоороо л гэхэд дэлхийд өрсөлдөгчийн нэг байх бүрэн бололцоотой. Цагаан идээний үйлдвэрлэл байна. Мөн ноос ноолуурын салбарт өргөн боломж нээлттэй байна. ▶

▶ **Д.Ганбаяр**
/Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн/:



-Монголд асар их хэмжээний мөнгө орж ирж байна. Энэ их мөнгийг дотоодын эдийн засагтаа шингээхийн тулд хамгийн чухал асуудал нь уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүмүүсээ чадавхжуулах. Уул уурхайн хөрөнгө оруулалтыг мал аж ахуй, газар тариалан, шинжлэх ухаан, боловсрол, үндэсний үйлдвэрлэл рүүгээ оруулах ёстой юм. Манайд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэртэй байдал алдагдаад байна. Гадаадад хувьцаа гаргаж байгаа компани Монголын санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авдаг байх ёстой. Уул уурхайн баялгаа ашиглах аргаа өөрчлөх хэрэгтэй. Боловсон хүчнээ чадавхжуулах нь зөв. Тэгж байж орлогын хуваарилалтыг удирдаж сурна. Хүссэн хүсээгүй уул уурхайн баялаг үнэ цэнэтэй болоод ирлээ. Төрөөс уул уурхайд үзүүлж байгаа хөнгөлөлтөө өөрчилж, уул уурхайг дэмжсэн татварын бодлогоо хумих цаг ирсэн. Харин боловсролын салбараа дэмжих цаг болсон.

Б.Баттөмөр
/Үндэсний татварын ерөнхий газрын дарга/:



-Уул уурхайн салбараас тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт манай эдийн засагт нийлүүлэгдэж байна. Орж ирсэн мөнгийг яаж үр ашигтай зарцуулах вэ. Тиймээс мөнгөний зөв менежментийг бид хийх хэрэгтэй. Уул уурхайн компанийн татвар хэлбэрээр төлсөн мөнгийг нь Монголын төр маш сайн хянаж чаддаг байх ёстой. Хүн болгонд ажлын байр бий болгоё. Нийгмийн баялгийг үйлдвэрлэж байгаа компаниуд эргэлтийн хөрөнгөөр байнга дутагдаж байна. Тэдэнд эргэлтийн хөрөнгөд нь туслая. Зээлийнхээ хүүг бууруулж, хугацааг сунгах хэрэгтэй. Боловсролын салбарт хөрөнгө зарах ёстой. Мэдэхгүй байгаа зүйлийг нь мэдүүлэхийн төлөө мөнгө зардаг байх учиртай. Байгалийн баялгаас орж ирсэн мөнгөний менежментийг л сайн хийе. Уул уурхайгаас бусад салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлбэ. Эрүүл мэндэд мөнгө зарах учиртай. Зохистой удирдлага эндээс шалтгаална. Энэ бүхний дүнд өсөлт хөгжил болно.

Б.Чулуун
/МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга/:



-Байгалийн баялгаас орж ирж буй орлогоо оновчтой зарцуулахын тулд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх хэрэгтэй. Боловсролын тогтолцоог өндөр түвшинд гаргаснаар өрсөлдөх чадвар сайжирна. Залуучуудыг гадаадад сургуульд явуулж, мэдлэг туршлага нөөцлөхөд нь хөрөнгө оруулалт хийх нь үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, хүмүүн капиталыг бий болгох хэрэгтэй. Сэргээгдэх эрчим хүч, хэмнэлттэй технологийг нэвтрүүлж ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд байгалийн баялгийн орлогоос хөрөнгө зарах хэрэгтэй.

Н.Дорждарь
/Нээлттэй нийгэм форумын судлаач/:



-Ямар ч орлогыг бид зөв менежментээр зөв удирдах ёстой. Төсөв санхүүгээ хариуцлагатай, иргэдийнхээ оролцоотой төлөвлөдөг байх хэрэгтэй. Уул уурхайн орлого байхгүй байлаа гэхэд эдийн засгаа хэрхэн авч явах вэ. Зарчим бол нэг байх ёстой. Уул уурхайн орлого өөрөө асар их хэмжээтэй. Уул уурхай давамгайлж байгаа учраас түүнээс үүдсэн эрсдэлүүд манайд үүсэж байна. Гэхдээ эрх зүйн орчин, бодлогын түвшинд өөрчлөлт хийх хэрэгтэй. Уул уурхайн орлого бол өвөрмөц эрсдэлүүдийг бий болгодог. Ялангуяа, цөөхөн хэдэн компанитай эдийн засагтай оронд нийгмийн хамаарал мэдрэгддэг. Төр, иргэдийн харилцаа холдох муу жишээнүүд ч байгаа. Энэ алдааг давтахгүйн тулд хариуцлагатай, ил тод, төр, засгийн бодлогыг дэмжихийн тулд нийгмийн оролцоог идэвхжүүлэх шаардлагатай. Удирдлагыг төр дангаараа хийх оновчгүй болж байна. Төрд ашиг сонирхлын зөрчлийн асуудал үүсэх нь ажиглагдах болсон. Зарим асуудлыг төр дангаар бус бусад хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлэх боломжтой. Заавал нийтийн эрх ашгийн төлөө шийдвэрийг төр гаргах шаардлагагүй. Орлогоо удирдаж сурахын тулд засаглалтай, ил тод байх ёстой. Иргэдийг бодлого боловсруулахад оролцдог, хяналт тавих эрхийг нь төр нээж өгөх нь зөв. Мөн хариуцлагын тогтолцоо хэрэгждэг байх нь үр дүнтэйд тооцогддог. Хариуцлагын механизм ажиллахгүй болохоор л орлогын үрэлгэн байдал үүсэж байна. ■

Хөгжлийн хөшүүрэг

Б.Тогтох

Манай улс уул уурхайн салбарт дөмөгхөн нэртэй байхаа больжээ. Үүнийг өнгөрсөн онд болсон хэд хэдэн чуулга уулзалт, хамгийн сүүлд л гэхэд Монголын эдийн засгийн чуулганаас тодхон харж болмоор. Уул уурхайн тухай мэдээлэл хомсхон байсан өнгөрсөн цаг үе хэдийнээ бидний ард үлдэж. Зөвхөн Монголын уул уурхайн салбарын хэтийн хөгжил, уурхай дагасан Монголын үсрэнгүй өөрчлөлтийн талаар дэлхий нийт “буу халцгааж” байна. Нүдээ унагасан өмнийн говийн баялаг, цаана нь буй нээгдээгүй өчнөөн үлэмж ордын тухай тэд өдгөө ярьцгаах аж. Хөгжилд гэгээ нэмсэн, бүтээн байгуулалт, дэд бүтцийн салбарт хөгжлийн шанг татах Оюутолгой төсөл бас Тавантолгой. Эндээс л цөөхөн монголчууд, дараа дараагийн ирээдүй хойч үе маань алгаа тосон, хөрөнгө мөнгө хүлээж сууна.

Хүлээлт гэдэг маш том итгэл, бас эрсдэл болохыг МУИС-ын Эдийн засгийн сургуулийн багш, эрдэм шинжилгээний бүтээл нь олон улсад үнэлэгдсэн Б.Эрдэнэбат хэлсэн удаатай. Эрдэнэбат багшийн хэлснээр хүлээлт их хөгжлийн өмнөх тэсрэлт байгаасай. Харин үүнд монголчууд бэлэн үү. Эдийн засагт энэ онд 25 хүртэлх хувиар өснө гэсэн таамаг бий. Тооцсон ёсоор өссөн тохиолдолд урьдын өсөлтөө бататгаж байгаа нь энэ. Тэгвэл энэхүү өсөлт хэр бодитой, амьдралд тустай өсөлт байх бол оо. “Эдийн засгийн өсөлт бүхэн хөгжил биш юм” гэж Эдийн засагч Д.Жаргалсайхан “Эдийн засгийн өсөлтийг эдийн засгийн хөгжил болгоё” нийтлэлдээ тайлбарлажээ.

Хүлээлт

Уул уурхайн салбарын хөгжлийн тэлэлтээс хамаарсан эдийн засгийн гэнэтийн өсөлт манайд ямархан маргаашийг бэлэглэх бол. Тавантолгой орд байрандаа байгаа хэдий ч дэд бүтэц муутайхан олборлолт, шороо тоос манаруулсаар өмнийн говийн баялгийг нааш, цааш нь цөлмөх аж. Ямар ч бүтээн байгуулалт, дэд

бүтцийн сураг чимээгүй томоос том Тавантолгой орд өнөөдөр ч бүрхэг байгааг мэргэжилтнүүд хэллээ. Уг нь хөгжилд гэгээ нэмэх Тавантолгой ордын гэрээ хэлэлцээр үргэлжилсээр байгаа билээ. Өмнийн говьд хоёр өөр амьдрал цэцэглэсээр буй. Нэг нь Оюутолгой орд дагасан бүтээн байгуулалт. Харин эсрэгээрээ Тавантолгойгоос нүүрс тээвэрлэсэн тарчиг, ядуухан, бас зүдүүхэн “үрэлгэн байгуулалт” Өмнөговь аймгийн Цагаан хаданд баттай орших аж.

Галбын говийн улаан тэмээ дэргэд нь идээшлэх Оюутолгойн бүтээн байгуулалт зэрэглээн дундаас зэрвэс харвал аж үйлдвэрийн хот мэт. Хэзээ аж үйлдвэрийн хот энд боссон билээ гээд бодоод үзсэн чинь өнөөдрийн бүтээн байгуулалтын эхлэл нь тэр бөлгөө. Зээргэнэ, бударга, заг, хөмүүлтэй толгод алсарсан тал. Тэнд л таван хантай гэрээ дугуйлсан “Оюутолгой” төслөөс одоогийн Монгол Улсын маргаашийн хөгжил зураастай байх нь гэсэн бодол төрснийг нуух юун. Гэтэл өнөөдөр манай улсын хөгжил цэцэглэлт, амьдралын өнгө эрээн бараантай, ядмаг доройхон. Бидний ийм байдлаас нь гаргах, ажилтай, орлоготой, сэтгэл тэнүүн амьдрах хөшүүрэг нь тэгээд юу вэ. Одоогийн нөхцөлд уул уурхай, цаашид ч уул уурхай тулгуур болохыг зарим эдийн засагчид хэлэх юм. Хариуцлагатай уул уурхай хөгжлийн хөшүүрэг. Тэгвэл “Оюутолгой” төсөл Монголын хөгжлийн хөшүүрэг, бас бидний хүсэж мөрөөдөх хөгжингүй оронд хүргэх гишгүүр, гүүр нь болж өгөх аж.

Өмнийн говь бол усан далай бус эх газар

“Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн таван мянган ам.долларт хүрнэ” хэмээн Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд тэмдэглэсэн нь билээ. Гэхдээ хөгжлийн асуудал Оюутолгой, Тавантолгойдоо бус монголчуудаас шалтгаалах нь тодорхой. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, профессор Б.Бат “Капиталыг



дотор нь байгалийн, биет, хүмүүн гэж гурав хуваадаг. Байгалийн капитал гэдэгт алт, зэс, нүүрс орж байна. Харин биет гэхээр сандал, ширээ, хүмүүн гэдэгт мэдлэг боловсролтой иргэд ордог. Тэгэхээр байгалийн капиталыг яаж биет болон хүмүүн капитал болгох вэ гэдгээс хамаараад эдийн засаг нь цаашаа урт хугацаанд тогтвортой хөгжиж чадах уу гэдэг нь хамаарна” гэлээ. Манайд байгалийн капитал нь бий. Хөдөлмөрийн зах зээл ч хангалттай байгааг салбарынхан нь хэлдэг. Үндэсний статистикийн хороо /УСХ/-ны мэдээлснээр бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны хоёрдугаар сарын эцэст 58.4 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.9 мянган хүнээр буюу 51.6 хувиар өссөн байна. Яагаад ажилгүйдэл өссөөр байна вэ.

Оюутолгойд бүтээн байгуулалт буцалж, Тавантолгой ордын яриа хэлцэл өндөрлөх тийшээ аядаж байхад ажилгүйдэл байсаар л. АНУ, Хятад, Солонгост ч ажилгүйдэл амь бөхтэй орших аж. Манай улсын хувьд томоохон төсөл дагаж ажлын байр нэмэгдэнэ гэсэн үг. “Оюу Толгой” ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРэй “Энэ оны наймдугаар сард үйл ажиллагааны эхний үе шатыг эхлүүлэх “Оюу Толгой” жил тутам 450 мянган тонн зэс, 330 мянган унц алт олборлох дэлхийн хэмжээний хамгийн том алт- ▶



▶ зэсийн уурхайнуудын нэг. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 7.7 их наяд төгрөгийн /зургаан тэрбум ам.доллар/ хөрөнгө оруулалтыг уурхайд оруулсан” хэмээн онцлов. Урьд өмнө манайд ийм тооны жинтэй хөрөнгө оруулалт байгаагүйг эдийн засагчид онцолсоор.

“Оюу Толгой”-н баяжуулах үйлдвэр хоногт 110 мянган тонн хүдэр боловсруулах хүчин чадлаар ажиллах үед хэрэглэх усны хэмжээ дунджаар 100 мянган шоо метр байх ба үүнээс 90 хувийг нь хүдэр боловсруулахад ашиглах юм байна. Дэлхийн хэмжээнд хамгийн бага ус хэрэглэдэг уурхайн нэг болж, усыг хамгийн хэмнэлттэйгээр ашиглах “Оюу Толгой” төслийнхөн усанд харам байхаас ч аргагүй юм. Учир нь, өмнийн говь бол усан далай бус эх газар.

Хариуцлага нэхэх нь бидний үүрэг

Нийгмийн хариуцлага, бодлогынхоо талаар “Оюу Толгой” компанийн Ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРэй “Зэс үйлдвэрлэлтэй холбоогүй олон үйл ажиллагаанд бид хөрөнгө оруулдаг. Жишээ нь, орон нутагт, сургалтын төв, их дээд сургуулиуд, урлагийн зөвлөлд. Ингэхдээ бид хийж байгаа зүйлээ монголчуудад хамгийн их үр ашигтайгаар хүргэхийг зорьдог” гэв. Нэгэн таатай мэдээ дуулгахад энэ

сарын статистик мэдээнд “Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2011 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 548.9 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 104.3 мян.төг буюу 23.5 хувиар өссөн” гэсэн үзүүлэлт гарчээ. ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “Машинаар бол Оюутолгой, Тавантолгой төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь Монголын эдийн засгийг түлхүүрдээд асаачихсан гэсэн үг. Машин асчихжээ. Сайн хэрэг” хэмээн “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлагадаа тэмдэглэжээ. Уул уурхайн салбарыг моодонд оруулсан “Оюу Толгой” төслийн өгөөжийн тухай өмнөх дугаартаа бид тов тодорхой өгүүлсэн. Говийн наран дор ховоо татах тэмээчний амьдралд, “Нарантуул” худалдааны захад лангуу түрээслэн, өвлийн хахир хүйтэнд эрүүл мэндээ золиослох наймаачны бизнест гэгээ болох “Оюу Толгой” төслөөс хариуцлага нэхэх нь бидний үүрэг аж.

Тогтвортой хөгжихийн тулд...

Манай улс энэ оны хоёрдугаар сарын байдлаар дэлхийн 103 оронтой худалдаахийж, гадаадхудалдааны нийт бараа эргэлт 1469.3 сая ам.долларт хүрсэн тухай УСХ-ноос мэдээллээ. Тодруулбал, экспортын 97.7 хувийг уул уурхайн эрдэс бүтээгдэхүүн эзэлжээ. Мөн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 287.8

тэрбум төгрөг болж, өнгөрсөн оныхоос 20.6 тэрбум төгрөг буюу 7.7 хувиар өссөн байна.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 160.8 тэрбум төгрөгөөр буюу 37.2 хувиар өсчээ. “Оюу Толгой” төсөл өдөр бүр 10.4 тэрбум төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авч байгаа аж. Товчхондоо 2019 онд манай улсын ДНБ 35 хувиар өсөж, экспортын хэмжээ одоогийнхоос хоёр дахин нэмэгдэх юм байна. Үүний тал хувийг Оюутолгой дангаар бүрдүүлэх аж. Одоогийн байдлаар “Оюу Толгой”-д 6837 монгол, 3632 хятад, 772 бусад 35 орны иргэд ажиллаж байгаа аж. Эдийн засагч Д.Жаргалсайхан “Агчны навч” нийтлэлдээ “...уул уурхайн салбараа алсыг харсан бодлогоор удирдаж эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэхэд оновчтой чиглүүлэх хэрэгтэй байна” гэжээ.

Мэргэлжилтнүүдийн хэлж байгаагаар уул уурхайгаас хүртэх ахиухан ашиг орлогоо хэрхэн тогтвортой хөгжил, үндэсний баялаг болгох нь монголчуудаас шалтгаалахыг учирлаж сууна. Өөрөөр хэлбэл, баялгийн орлогоо хүртээмжтэй, тэгш хуваарилдаг, улс төрийн орчин нь тогтвортой, сайн засаглалтай байснаараа ирээдүйн хүлээлт бодит хөрөнгө оруулалт болох юм. ■



Үл хөдлөх хөрөнгө

Улаанбаатарын хөгжил хаашаа явна вэ?

“Mongolian Economy” сэтгүүлийн англи хэлний редактор Теренс Эдвардс Монголын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт шинэчлэлтийн талаар сонирхолтой нийтлэл бичлээ. Тэрбээр нийтлэлээ Монголын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд ажилладаг Ди Грубений хийсэн тайлан дээр үндэслэж, холбогдох байгууллагын эх сурвалжийг ашиглан туурвижээ.

Далаад жилийн тэртээ Оросын бүтээн байгуулагчид Утопия хотыг ажилтны ангид зориулан үүсгэн байгуулахаар төлөвлөж байсан нь одоогийн бидний мэдэх Улаанбаатар хот билээ. Хот төлөвлөгчид одоогийн Зайсан толгойгоос эхлээд Сүхбаатарын талбайг дайруулан хойд захыг нь одоогийн Бага тойруу байхаар зурж байжээ. Энэхүү хот нь дүүргүүдэд хуваагдан, төр, засгийн зүтгэлтэн болон өндөр албан тушаалтнуудын байр, Засгийн газрын ордны ойролцоо

Теренс Эдвардс



“Mongolian Economy”
сэтгүүлийн Англи
хэлний редактор

байхаар, үүнээс эмч эрүүл мэндийн ажилтнуудын байр зүүн зүгт байрлаж байв. Мэс заслын эмч нарын байр сувилагчдынхаас илүү тохилог, харин хамгийн гоёмсог байруудыг эмнэлгийн дарга нарт зориулж үечлэн зохион байгуулсан байжээ. Ийм хэлбэрээр зохион байгуулагдсан хот нь ажилтан, мэргэжил нэгтнүүд бүгд нэгдөр амьдрах гэсэн коммунизмын үзэл бодолд тохирч байсан болов уу. Орос улсад энэ хэлбэрийн зохион байгуулалттай хот цөөнгүй байсан ч монголчуудын хувьд анхных байсан тул хотоороо бахархсан. Ийм ч учир монголчууд энэхүү хотоо “Улаанбаатар” гэж нэрлэсэнд гайхах зүйлгүй.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нийслэл хот тэрхүү хуучны коммунист мөрөөдлийн хотын дүр төрхөөс богино хугацаанд ангижирчээ. Түм түжигнэж бум бужигнасан, зав чөлөөгүй, алдаа дутагдал, ололт амжилт аль алинийг нь агуулсан их хот болон хувирч, капитализм руу шилжжээ.

Шилжилтийн үе үргэлжилсээр

Уул уурхайн салбарын эрчимтэй өсөлт Улаанбаатар хотыг маш хурдтацтайгаар хэдхэн жилийн дотор танигдахын аргагүй өөрчилжээ. Өнөөгийн хотын амжилт дутагдал, дэвшлийг хамгийн сайн харуулж чадах жишээ бол “Blue Sky” цамхаг нэртэй Монголын нийслэлийн бэлгэ тэмдэг болсон барилга юм. Энэхүү содон барилгын хэв маяг, хийц нь сэтгэл зүйн дүн шинжилгээг агуулах мэт. Зарим хүмүүст далбаат усан онгоцын хэлбэртэй харагдсан байхад, заримд нь хуушуурыг санагдуулж, тэр ч байтугай, Фрэйдийн хэв шинжийг агуулсан гэж үзэх тохиолдол ч бий. Тус барилгын түүхийг илүү ойроос өнгийж харах юм бол үл хөдлөх хөрөнгийн салбар капиталист шинжид дөнгөж орж байгаа нь харагдаж байна.

“Эм Эй Ди” /M.A.D/ компанийг үүсгэн байгуулагч, удирдагч Кристофер ▶▶

► Ди Грубен нь санхүүгийн бэрхшээлүүд нь тухайн төслийн гол бэрхшээл байсныг ярилаа. Зээл олдохгүйн улмаас барилга барих гэж байгаа хүн байшингийн суурийг цутгахаасаа өмнө бүх байрыг худалдан авч чадах хөрөнгө оруулагч хайхад ихээхэн цаг зарцуулахад хүрдэг. Өөрөөр хэлбэл, барилга барих төлөвлөгөөгөө гаргаад, байруудыг худалдаж авах боломжтой хөрөнгө оруулагч нарт бизнес төслөө өгөөд, ажлаа эхэлдэг нь энгийн үзэгдэл болжээ.

Ди Грубен үл хөдлөх хөрөнгийн салбарт амжилттай тоглогч, мөн Монголын түүхийг сонирхогчийн хувьд тохиромжтой шийдэл аргыг боловсруулсан байна. Тэрбээр Улаанбаатар хотын төлөвлөлтийг хуучин дүрсэлж байснаар гаргажээ. Ди Грубен саяхан “Монголын үл хөдлөх хөрөнгийн тайлан” нэртэй чухал гарын авлага нийтлүүлсэн байна. Олон нийтийн ил тод байдлын дутагдал, Улсын нууцын тухай хууль иргэдэд ч гэсэн зах зээлд хөл тавихад хүндрэлтэй байдаг. Ди Грубен нь Монголд зах зээлийн зөв хэвшил байхгүйгээс аливаа хөрөнгийн бодит үнийг тогтоох хүндрэлтэй байдгийг дурдлаа. Номоо бичихийн тулд тухайн байрны хэд нь борлуулагдсан гэдгийг мэдэхийн тулд шөнө очиж гэрэлтэй цонхыг нь тоолж, газар дээр нь очиж барилгыг хэмжих гэх мэт аргуудыг хүртэл хэрэглэж байжээ.

“Хөх тэнгэр” цамхаг мэтийн барилгын төслүүдэд тулгардаг өөр нэгэн саад бол жилийн дөрвөн улиралд тасралгүй барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй явдал юм гэж тэрбээр тайлбарлав. Барилгын ажил нь зуурмаг бүрэн хатахуйц дулаан байх богинохон хугацаанд л явагдах боломжтой. Цемент үйлдвэрлэгчид хасах таван хэмээс доош байгаа тохилдолд цемент хагарч, чанаргүй сул болно гэж анхааруулдаг. Дээрх цамхагийн зургаан жил үргэлжлэх барилгын үйл явц урт хугацаа ч хэвийн бус үзэгдэл биш.

Ди Грубенейг Монголд анх ирснээс хойш долоон жилийн хугацаа өнгөрсөн. Түүнийг ирснээс хойш эхэлсэн олон барилгын ажил дөнгөж одоо дуусч байгаа билээ. Ди Грубен “Барилгын ажил хамгийн багадаа гурван жил, таван жил ч үргэлжилж болно. Чанаргүй барилгын материалаар туршлагагүй барилгачдын барьсан өндөр зэрэглэлийн байшингууд нурж байна” гэж хэллээ. Шинэ худалдааны болон орон сууцны олон барилгад

тохиромжтой бодлого дутагдаж байна. Ди Грубен тодруулан хэлэхдээ “Хэдийгээр Улаанбаатарын шинэ цагийн орон сууцны цөөнгүйн аятахтай мэт харагддаг ч Шанхай, Пномпен, Банког зэрэг хотын дээд зэрэглэлийн барилгуудтай харицуулалтгүй. Хамгийн наад захын шаардлага болох дулаан гараж байхгүй.

“Хөх тэнгэр” цамхаг л гэхэд 12 айлын орон сууцтай. Гэтэл эдгээр орон сууц огт гараж байхгүй. Ам.метрийг нь хоёр сая ам.доллараар худалдан авч байгаа хүнд “Хаммер” жийпээ байрлуулах газаргүй тул хасах 40 хэмийн хүйтэнд машинаа гадаа тавих хэрэгтэй болно гэж яаж хэлэх вэ?” гэж Ди Грубен гайхширч байна.

Шинэ өнгө төрх

Нийслэлийн өнгө төрх өөрчлөгдөхийн хэрээр нийслэлийн хүн ам ч өөрчлөгдөж байна. “Ази Номхон Далайн хөрөнгө оруулалтын түнш” /“Оазис” төсөл хэрэгжүүлэгч/ гэхчлэн компаниуд нь шинэ чинээлэг давхарга болох гадаадын мэргэжилтнүүд болон эх орондоо буцан ирж буй монголчуудыг өөрийн үйлчлүүлэгчээ болгохыг зорьж байна. Эдгээр худалдан авагчид нийслэлийн уламжлалт оршин суугчдаас эдэлж хэрэглэх хэвшил, мэдрэмжээрээ ихэд ялгаатай байдаг.

“Гадаадаас Монголд ажиллаж амьдрахаар ирж байгаа хүмүүсийн талаас илүү хувь нь ганцаараа ирдэг” гэж “Монголиан пропертис” үл хөдлөх агентлагийн ахлах агент А.Өнөржаргал хэлжээ. Мөн тэрбээр “Ихэнх ирж байгаа гадаад хүмүүс гэр бүлээ эх орондоо үлдээж ирдэг ч сүүлийн үед удаан хугацаагаар ажиллаж, амьдрах хүмүүс гэр бүлийхнийгээ авчрах явдал нэмэгдэж байна” гэв.

“Монголиан пропертис”-ийн ерөнхий менежер О.Батзаяа “Амьдрахад таатай газрын нэг бол Монгол мөн гэсэн төсөөлөл байдаг. Манай улс төрийн нөхцөл байдал аюултай биш. Харин амьжиргааны түвшин барууны өндөр хөгжсөн орнуудыг бодвол доогуур” гэжээ. У.Алтанцэцэг хэлэхдээ “Ихэнх гэр бүл хотын төвд байрлалтай, баар цэнгээний газар бага, тэргүүлэх хувийн сургуультай ойролцоо байрлалтай орон сууцыг хайдаг. “Монголын хөрөнгө” гэх мэт үйлчилгээ үзүүлэгчид амралт чөлөөт цагаа өнгөрөөх газар, дэлгүүр гэх мэт бүхий л зүйлийг нэг дор багтаасан орон сууцыг санал болгож байна. Улсын циркийн хажууд, Сөүлийн гудамжинд байрлах тус байгууллагын

“Оазис” төсөл үүний нэг жишээ юм. Өвөл шөнөдөө гадаа хасах 40 хэм хүрдэг өвөлтэй Монгол руу нүүж ирэх эсэхээ бодолцож буй гаднынханд энэ төсөл нь томоохон өөрчлөлт, давуу талуудыг авчирч болох юм.

Ди Грубен эдийн засагт гарах өөрчлөлтөд шууд өртөх өндөр магадлалтай, дөрвөөс зургаан мянган байнгын гадаадын оршин суугчтай хөрөнгийн зах зээлд их хэмжээний итгэл үзүүлэх боломжгүй гэжээ. Гаднын мэргэжилтнүүдээс арай найдвартай бүлэгт олон жил гадаадад ажиллаж, амьдарч байгаад эх орондоо буцаж ирж байгаа монголчууд орж байна. Тэд, гадаадуудтай мөн адилаар соёлдоо эргэж дасан зохицох, амьдарч байсан газрынхаа нөхцөл байдлыг эх орондоо боломжоороо бүрдүүлэх, өдөр тутмын стрессийг даван туулах гээд олон олон асуудалтай тулгардаг. О.Батзаяа “Хэдийгээр ийм олон асуудлуудтай тулгарч байдаг ч тэд үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр худалдан авах хандлага их байдаг. Ингэж худалдан авахад олон шат дамжлага, хүнд сурталтай тулгарах хэдий ч ихэнх тохиолдолд эдгээр асуудлыг шийдвэрлэж өгөх хамаатан саднууд байдаг” гэжээ.

Уугуул улс үндэстнийх нь хэмжээнд бүхлээр нь харах юм бол монголчуудын хувьд хамгийн гол ялгаа нь гар дээрээ зарцуулах бэлэн мөнгө бага байдаг. Монголчууд уламжлалаараа хамтдаа нэг байранд олуулаа амьдардаг. Хүүхдүүд нь насанд хүрээд гэрлэх хүртлээ хамт амьдардаг. Энэхүү заншил нь одоо ч хэвээр байдаг ч бийлэгжүү залуучууд байр түрээслэн тусдаа амьдарч эхлээд байгаа билээ. Байр түрээслэх нь олны дунд нэр хүнд муу байдаг тул ихэнх хүмүүс байр худалдан авах хүртлээ мөнгөө цуглуулдаг. Харин байршлаасаа хамаараад байрны үнэ 60,000-100,000 ам.долларийн үнэтэй байдаг.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн гүнд

Ди Грубен “Монголд үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь өөрийн гэсэн эрсдэлтэй байдаг. Байр худалдан авлаа гэхэд барилгын ажил бүрэн дуусч ашиглалтад ортол ямар ч бичиг баримт авах боломжгүй. Тухайн барилга хэдэн жилийн дараа дуусан дуустал эдийн засаг яах бол гэж харахаас өөр арга байдаггүй” гэв. Эдийн засаг нь “бух”-ын шинж чанартай байх үед Монголд ирээд үл ►

► хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх нь нэлээд найдвартай санагдах ч түүхий эдийн үнэ унахад, төгрөгийн ханш буурч, үнийн хөөрөгдөл хэт өндөр болоход тухайн барилгын компани дампуурах нь бий. Харамсалтай нь энэ үед хөрөнгө оруулагч гар хоосон хоцордог.

“Оазис” гэх мэт төслүүдийн хувьд барилгын ажил нь дууссан, Мэргэжлийн хяналтын газар бичиг баримт нь хүлээгдэж байгаа ч тэдгээрийг авах хэцүү гэж Батзаяа хэлэв. Зохимжтой удирдлаггүй хот төлөвлөлтгүй хөгжихөөс өөр аргагүй. Зайсангаас Богд уул тийш өргөжин тэлж байгаа манай хот магадгүй АНУ-ын Шар чулууны паркийн түүхийг харуулж буй мэт санагдана. Дэлхийн банк Засгийн газар хууль бусаар газар худалдан, хөгжлийн олон төслүүдэд саад тогтор болж байдаг гэж шүүмжилсэн. Мөн Улаанбаатар хотод ногоон байгууламжийн асуудал тулгараад байна. “Бодь” групп Хүүхдийн паркийг худалдан аваад кино театр, галзуу хулгана гээд олон зүйлийг багтаасан зугаа цэнгэлийн маш том төв барихаар төлөвлөсөн.

Энэ талаар Ди Грубен “Хүүхдийн парк улам жижгэрсээр. Миний хувьд энэ бол арагшаа ухарч буй хэрэг. Улсын нийслэлд ногоон парк зайлшгүй хэрэгтэй” гэв.

О.Батзаяа, Ди Грубен хоёр хөрөнгийн зах зээлийн үнэ өсөж түрээсийн байрны үнэд тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэж урьдчилан харж байгаа аж. Ди Грубен “Казахстан улсын шилжилтийн үед тогтвортой үнэ зах зээл дээр тогтох хүртэл бүхэл бүтэн арван жилийн хугацаанд үнэ өссөөр байсантай Монголын зах зээл ижил байна” гэж дүгнэжээ. Түүний тооцооллоор Монголын нийслэлийн төв хэсэгт байрны үнэ ам метр нь дөрвөөс зургаан мянган ам.долларын хооронд. Энэ үнэ ирэх таван жилд өсөж үүний дараа дунджаар 2,500 ам.доллар дээр очиж тогтоно.

Ди Грубен “Энэ бол үнийн гипер хөөрөгдөл. Эрэлт маш их байгаа мөртлөө үүнийг хангах нийлүүлэлт нь бага байгаатай холбоотой. Энэ нь асар том өсөлт” гэжээ.

Ирэх 20 жилийн хугацаанд сүндэрлэн босох хоёрдогч хотууд уул уурхайн нүсэр төслүүдийн ойролцоох Даланзадгад, Ханбогд дахь хөгжил Улаанбаатартай харьцуулахад илүү гайхалтай жишээ болж магадгүй. Гэсэн хэдий ч эдгээр төслийн аль нь ч 50-иас дээш жил амьдрах хугацаагүй.

Улаанбаатар хотод байрлах төв Засгийн газартай нийслэлийн хөгжил дэвшил найдвартай үргэлжилсээр байхаар байна.

Камбожийн түүх

Монгол Улс олон чиглэлээр явж болох ч хамгийн ихээр санаа зовоосон асуудал бол 700,000 хүн амьдарч байгаа нийслэлийн гэр хорооллын асуудал юм. Засгийн газар 100,000 айлын орон сууцны хөтөлбөрийн дагуу 10,000 гэр хорооллын айлыг боломжийн үнэтэй орон сууцанд шилжүүлнэ гэж найдаж байгаа билээ.

Шинэ бүтээн байгуулах төсөл хэрэгжүүлэхийн тулд ард иргэдийг гэр орноос нь хүч хэрэглэн гаргасан Камбожийн Пномпен нийслэлийн түүх бол дурдаж болох хамгийн харамсалтай жишээ юм. Улс орныхоо ард иргэдийг сайн сайхан, амар амгалан байлгахаас илүүтэйгээр гадаадын хөрөнгө оруулалт, хөгжил цэцэглэлтэд ихээр анхаарлаа хандуулснаар байрлал сайтай газар амьдарч байгаа ард иргэд өөрийн газар, өмч хөрөнгөө зах зээлийн үнээс харьцангуй доогуур үнээр шахалтаар

өгч, өгөөгүй нэгэнд хүч хэрэглэн хөөгдөж дахин өөр шинэ газар нүүж байрших, төвхнөх ямар ч туслалцаа авч чадалгүй хоцорсон билээ.

Хүний эрхийг хамгаалагч байгууллагын мэдээгээр 85,000 иргэн сүүлийн арван жилийн хугацаанд өөрийн төрсөн гэрээсээ хүчээр нүүсэн, үлдсэн 70,000 иргэн орон гэргүй хөөгдөж хоцорсон тухай мэдээлсэн. Пномпенийн Сабкок Чап тосгонд орон гэргүй хоцорсон айл өрхүүд эрүүл мэнд, цэвэр ус, сургууль гэх мэт наад захын амьдралын шаардлага хангахгүй хотын алслагдсан хэсэгт очихоос өөр аргагүйд хүрсэн.

Харин Улаанбаатар хотын гэр хороололд хүмүүс амьдрахыг хүсэх хүртэл бүтээн байгуулагч нарын сонирхлыг татахгүй. Замын түгжрэл бөглөө, түүнчлэн ихэнх албан байгууллага, дэлгүүр хоршоо, чөлөөт цагаа өнгөрөөх газрууд төвлөрсөн хотын төвөөс зайтай оршдог нь гэр хорооллын үнэ цэнийг бууруулж байгаа болов уу. Монгол Улс хурдны зам, метроны систем барьж байгуулсан цагт л эдгээр асуудал шийдэгдэж, хүмүүсийн бодол ч хурдан өөрчлөгдөнө биз ээ. ■

Шилдэг илтгэл

Нийгмийн хариуцлага нь их ашгийг бий болгоно

М.Болд /Тэнгэр санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал/



Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Компанийн нийгмийн хариуцлага, өрсөлдөх чадвар” сэдэвтэй хурлын үеэр Хасбанкны гүйцэтгэх захирал М.Болдын тавьсан илтгэлийг хүргэж байна. АНУ-ын Бостон коллеж дахь Компанийн нийгмийн хариуцлагын захирал асан, Профессор Брэдли К.Гоогинс тус илтгэлийг “Миний олон оронд сонсож байсан илтгэлүүдээс хамгийн сонирхолтой нь байсан” гэж онцолж байсан.

Тэнгэр санхүүгийн нэгдлийн өөрөөр хэлбэл, ажахуйн нэгж компанийн жишээн дээр нийгмийн хариуцлагыг бид хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдгийг та бүхэнд танилцуулахын зэрэгцээ санал бодлоо хуваалцъя. Миний ярих сэдэв “Эрдэнэт хүн, эх дэлхий, эрүүл ашиг”. Мөн манай компанийн үзэл баримтлалаар нийгмийн хариуцлагыг юу гэж тодорхойлж байгааг

товч танилцуулах болно. Энэ талаар ярихын тулд тухайн компанийн алсын хараанаас эхэлж ярих ёстой. Бид өөрөөр хэлбэл, өөрийн компанийн алсын хараанд нийгмийн хариуцлагыг суулгаж өгснөөр амжилтад хүрнэ.

Өнөөдөр манай группийн хэмжээнд 1500 хүн ажиллаж байна. Энэ хүмүүсийн үйл ажиллагааг нэгэн зүгт чиглүүлэхийн ►►

► тулд бид нийгмийн хариуцлагыг алсын хараатай хослуулан ажилладаг. Алсын хараа нь манай компанийн хувьд номлол гэж хэлж болох юм. Энэ номлолдоо гурвалсан зорилттой байхаар тусгасан. Эхлээд бидний үйл ажиллагаа нийгэмд ач тусаа өгч байх хэрэгтэй. Мөн бидний үйл ажиллагаа байгаль орчинд ээлтэй байх хэрэгтэй. Эцэст нь эрүүл ашиг олно. Ийм үзэл баримтлалыг мөрдөж ажилладаг. Энэ бол хоосон зүйл огт биш, компанийн маань тулгын гурван чулуу юм. Эдгээр нь манай байгууллагын ажилтан бүрийн мах цусанд шингэсэн ойлголт.

"Форд" компанийг үүсгэн байгуулагч Хэнри Форд "Зөвхөн ашгийн төлөө явах аваас тухайн компани хэзээ нэгэн цагт сөнөнө" гэж хэлсэн байдаг. Би үүн дээр нэгзүйлнэмээдхэлэхэдявцуурхашгийн төлөө явах нь биднийг хааш нь аваачих вэ? Хэрвээ бид энэ зүйлийн төлөө явах аваас биднийг ядуурал, гуйланчлал хүлээж байна. Зарим тохиолдолд бид

энэ зүйлтэй дасал болчихсон байгаа нь харагддаг. Бид өнөөдөр нийтийн нийгмийн хариуцлагыг ярих хэрэгтэй. Нийт гэдэгт хууль тогтоогч, Засгийн газар, хот, аймаг, сумын засаг захиргаа гээд бүх л зүйл хамаарна. Нийтээрээ нийгмийн хариуцлагыг ухамсарлах хэрэгтэй байна. Улаанбаатар хотыг "Утаанбаатар", "Хогбаатар" ч гэж нэрлэж болж байна. Бид ийм л орчинд амьдарч байна. Уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагаа явуулснаас болж олон мал, амьтан хортой ус ууж үхэж байна. Байгаль орчин сүйтгэгдэж байна.

Би өнгөрсөн жил Монгол Улсын баруун аймгуудаар 10 мянган километр явсан. Тэгэхэд нэг ч тарвага олж хараагүй. Бид өнөөдрийн ашгийн төлөө ан амьтдаа энэ мэтээр устгаж байгаа нь аюултай. Зөвхөн өөрийн ашгийн төлөө ан агнадаг хүмүүс бий. Эндээс хувь хүний нийгмийн хариуцлага ямар байгаа нь харагдаж байгаа байх. Ажиллах орчны талаар ярилтгүй боллоо. Эрүүл

мэндэд хортой орчинд ажиллаж байгаа олон хүн бий. Хэрвээ бид ийм байдлаар цааш явах юм бол маргааш ой модгүй, нөгөөдөр амьсгалах агааргүй болно. Хөвсгөл далай дэлхийн хамгийн цэнгэг устай нуурын нэг. Гэтэл өнөөдөр тийм цэвэрхэн цэнгэг байж чадаж байна уу? Хэний нийгмийн хариуцлагагүйгээс болж ийм байдалд хүрэв. Шар айраг ууж дуусаад савыг нь энд тэндгүй хаячихдаг. Энэ бол гутамшиг. Энэ бүхний үр дүнд гол мөрөн ширгэж байна. Хөвсгөл далайд судалгаа хийж байгаа АНУ-ын нэг эрдэмтэн интернэтээр "Монгол Улс экологийн сүйрэлд өнөө маргаашгүй хүрнэ" гэж бичсэн байсан. Өнөөдөр Монголын нийт хүн амын гуравны нэг нь үгээгүй ядуу. Нийгмийн тогтворгүй байдал, өвчин, ядуурал, ажилгүйдэл энэ бүхэн биднийг хүрээлэн оршиж байна. Бид ч энэ бүхэнд дасчихаж. Энэ бол нийгмийн сүйрэл. Эдийн засгийн хямрал, сүйрлийг их ярьдаг гэтэл нийгмийн сүйрэл өдөр тутмын амьдралд энгийн нэг үзэгдэл болчихсон байгааг анзаарахгүй өнгөрч байна, хүмүүс.

Нөгөөтэйгүүр манай оронд уур амьсгалын өөрчлөлт газар авсан. Дэлхийд 0,75 хэмээр дулаан болоход Монголд 2,4 хэмээр халж байна. Манай орны нийт усны нөөцийн гуравны хоёр нь газрын хөрснөөс арчигдаж байна гэсэн үг. Эдгээр нь бидний ярьж байгаа сэдэвтэй шууд холбоотой. Гэхдээ зарим нэг нь байгалийн давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой нь ойлгомжтой юм. Гэвч бид эдгээрийг бууруулах, удаашруулах арга хэмжээ авах хэрэгтэй. Бид нийгмийн хариуцлагыг яриад л байгаа. Харин хэрэгжүүлэх нь чухал. Мөн амжилтад хүрэхийн тулд нийгмийн хариуцлагыг хэмжих ёстой. Мөн ямар түвшинд очих талаар зорилтод ажлыг хийх хэрэгтэй. Энэ үйл ажиллагааг хэмжих тодорхой хэмжүүрүүд байгаа. Бизнесийн болоод байгаль орчны хувьд хэмжиж болдог. Үүнийг бид мэддэг билээ. Тухайлбал, өнөөдөр хэр хэмжээний хог хаяж байна вэ. Манай компани жилд хэдэн тонн хог хаяж байгаа вэ гэдгээ хэмжиж болох зүйл. Үүний үндсэн дээр дараа жил хэр хэмжээний хог хаях вэ гэдгээ зорилт болгох хэрэгтэй. 10 эсвэл 20 хувиар багасгана гэдэг ч юм уу.

Нийгмийн хувьд бид ажилд хэн нэгнийг авахдаа арьс өнгө, үзэл бодлоор нь ялгаварлахгүй байх нь нийгмийн хариуцлага. Хэчнээн хүнийг гадуурхсан гэдгээ тогтоох нь ач холбогдол ихтэй. Түүнийгээ дараа дахин давтахгүй байх тал дээр анхаарах нь өөрөө нийгмийн хариуцлага юм. Хүний эрх манай байгууллагад хэр байгааг хэмжиж ►



М.Болд захирлын шлтгэлдээ ашигласан зургуудыг сонирхуулж байна.



► болно. Энэ мэт үйл ажиллагааг явуулж байж л амжилтад хүрнэ. Нийгэмд үзүүлж байгаа үр нөлөөг бид хэрхэн хэмжих талаар хэдэн жишээ хэлье. Тухайлбал, манай компаниас зээл авч байгаа иргэдийн хэдэн хувь нь орон нутгийн иргэд байна вэ? Манайд 56 хувь нь байна. Эмэгтэйчүүд хэдэн хувийг эзэлж байгааг хэмжиж болно. Өнөөдөр манайд 70 мянган хүүхэд хадгаламжтай байна. Бид 8-10 настай хүүхдүүдэд үнэ төлбөргүй санхүүгийн талаар хичээл заасан. Үүнд 356 хүүхэд хамрагдсан гэсэн тоо гарчээ. Өнөө жил үүнээс илүү олон хүүхдэд хичээл заана. Энэ нь нийгмийн хариуцлага юм.

Бидний энэ ажлыг Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны удирдлагууд дэмжиж байгаа. Гэтэл тус яамны дунд шатны түшмэдүүдийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголт муугаас бидний ажлыг ойлгохгүй байгаа юм. Мөн манай байгууллагаас 14-18 насны охид, хөвгүүдэд зориулсан сургалт зохион байгуулж байна. Уг хичээлд 110 сургуулийн 10 мянган хүүхэд хамрагдсанаар нийт улсыг хамарч чадсан. Бүх зардал компаниас гарч байгаа. Сургалтад хамрагдсан хүүхдүүдийн таван мянга нь хадгаламжийн данс нээсэн байсан. Энэ бол нийгмийн хариуцлага хэрэгжиж байгаагийн нэг жишээ. Дахин давтаж хэлэхэд, нийгмийн хариуцлага гэдэг нь бидний өдөр тутам авч байгаа арга хэмжээ юм. Нөгөө нэг жишээ нь санхүүгийн үйлчилгээг алслагдсан орон нутагт сууж байгаа иргэдэд хурдан шуурхай, хямд хүргэх. Үүнийг шийдэхийн тулд гар утасны үйлчилгээгээр мөнгөн гуйвуулга хийх харилцааг нэвтрүүлсэн. Энэ нь өөрөө иргэдийн төлөө хийсэн үйлдэл боловч компанид бас хямд аргаар гүйлгээ хийх боломжийг бий болгож байгаа. Өнөөдөр бид олон улсын хэмжээнд нийгмийн хариуцлагын зэрэглэл тогтоолгох хэрэгтэй болжээ. Энэ бүхний эцэст бид эрүүл ашиг хүртэх болно.

Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлснээр зардлаасаа илүү их ашиг бий болгож чадна гэдгийг онцлох хэрэгтэй юм. Энэ асуудлаар хүндрэл бэрхшээл байгаа гэхдээ үүнийг шийдэх ёстой. Нийгмийн хариуцлагыг бид зөв ойлгож чадвал үр ашиг нэмэгдэнэ. Мөн хөрөнгө оруулагчид ч нэмэгддэг. Нийгмийн хариуцлагаа ухамсарлаж чадвал бидэнд зээл өгөх компани захаасаа аваад олддоно. Хариуцлагаа ухамсарласан байгууллагад харилцагчдын итгэх итгэл сайжирч, давуу тал мөн бий болдог. Энэ бүгдийн эцэст тогтвортой хөгжил аяндаа бий болох юм. ■



Бизнесийн хүүхнүүд

Энэ салбар энэрэнгүй, үнэнч байхыг шаарддаг

Э.Зоригт

Манай сэтгүүл энэ дугаараас эхлэн уншигч танд “Бизнесийн хүүхнүүд” булангаа хүргэж байна. Энэ удаагийн зочноор “Монголэмимпэкс концерн” ХК-ийн гүйцэтгэх захирал, 2011 оны “Дэлхийн шилдэг бизнес эрхлэгч эмэгтэй”, 2011 оны шилдэг нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч “Lady Intrepreneur” зэрэг шагналын эзэн, МҮХАУТ-ын Эрүүл мэндийн зөвлөлийн тэргүүн, “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн удирдах зөвлөлийн гишүүн Батбаярын Болормааг урилаа.

Тэр өчигдрийн тухай

Монгол ардын зүйр үгэнд “Хүн болох багаасаа, Хүлэг болх унаганаасаа” гэсэн нь бий. Тэгвэл өнөөдрийн өндөрлөгт хүрсэн түүнээс хүүхэд насных нь талаар сонирхсон юм.

-Манай гэр бүлийн хүмүүжил, боловсрол бидний ирээдүйн ажил амьдралын эхлэлийг тавьсан гэж боддог. Манайхан хоолны ширээний ард суугаад л эдийн засаг, тэр үеийн олон улсын байдал, танин мэдэхүйн сэдвээр янз бүрийн халуун дулаан яриа өрнүүлдэг байлаа. Гэр бүлийнхэн, ойр

дотныхонтойгоо сурч мэдсэн, уншиж таньсан зүйлээ ярилцаж, зөвлөлдөх нь бидний заншил болон тогтсон юм. Тиймээс би ном их уншдаг байсан. Одоо ч уншсаар л байна. Аав минь Монголбанк, Олон улсын банкинд удирдах албан тушаал хашдаг байсан. Харин ээж маань Статистикийн төв байгууллагад насаараа ажилласан даа. Миний өнөөдрийн амжилтын гол үндэс нь миний бага нас, орчин тойрон, суурь хүмүүжил их нөлөөлсөн. Бид амжилтад хүрэхийн тулд эхлээд өөрийгөө бэлдэх хэрэгтэй. Эцэг эхчүүд нь хүүхдийнхээ оюуны хөрөнгө оруулалтад анхаарч тууштай занг төлөвшүүлэх нь чухал. Ер нь амжилтын нууц шинэ бүхнийг эрэлхийлэх сэтгэлгээ, цэгцтэй, тууштай байх зан чанар юм. Энэ бүх чадварыг бага наснаасаа л гэр бүлээсээ олж авсан гэж боддог гэв.

Энэ бол түүний бага нас. Тэрбээр багадаа зураач болохыг мөрөөддөг байжээ. Багш нь түүний зурсан зургийг магтаж, шагнал болгон өгсөн зургийн хэрэгсэл нь зураач болох мөрөөдлийг нь улам бадраасан аж. Гэвч тэр томрох тусмаа л тоо, ном хоёрт зүрх сэтгэлээ зориулсан байна. ►

► Өнөөдөр буюу амжилтын эзэн бүсгүй

Б.Болормаа захирлын араас гурван өдөр хөөцөлдөж, гуравхан асуултад л бүтэн хариулт авсан юм. Үнэхээр завгүй түүнтэй аяга цай тайван ууж, таван үг тухтай солих гэдэг хэцүү юм билээ. Арга ч үгүй биз Монгол Улсын хүн ардын эрүүл энхийг сахин хамгаалах их үйлсэд хувь нэмрээ оруулж яваа хойно.

-Хатан ухаанаар компани удирдан чиглүүлж, зах зээлийн өрсөлдөөнд ганхуулалгүй авч яваа таны бизнесийн нууц юу вэ?

-Бизнес бол зөвхөн хувь хүндээ ашиг өгөх нь чухал биш. Нийгэмдээ тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байж амжилттай явна. Эрүүл мэндийн салбарын гурван тулах баганын нэг нь эм хангамжийн салбар байдаг. "Монголэмимпэкс концерн" нь энэ салбарын ууган компани. Бүхэл бүтэн 89 жилийн түүхийг агуулж яваа. Тиймээс үлгэр жишээ байж, салбарынхаа нэр хүндийг өндөрт өргөх хэрэгтэй. Гэхдээ онцгой тээвэрлэлт, хадгалалт гээд энэ салбар өөрөө их эмзэг юм л даа. Энэ нь олон ч хүндрэлтэй асуудлыг араасаа дагуулдаг юм. Тийм болохоор эмэгтэй хүний аливааг олон талаас нь ухаалгаар харах чадвар хэрэг болдог. Тиймээс ч манай байгууллагын 90 орчим хувь нь эмэгтэйчүүд. Мөн багийн хамтын ажиллагаа, компанийн сайн засаглал бидний амжилтын гол үндэс. Манай компани 1990-ээд оны зах зээлийн шуурганд сөхрөөд уначихаагүй ч биднийг хувьчилж авах үед үйл ажиллагаа нь нэлээд зогсонги байдалтай болчихсон байсан. Харин өнөөдөр хөл дээрээ босоод иржээ. Энэ бол бидний хамтын амжилт. Ганц хүний амжилт гэж хэзээ ч байхгүй. Харин хамтын бүтээл, хамтын амжилт гэж байдаг.

-Зарим хүн эмэгтэй удирдагч гэхээр хүлээн зөвшөөрддөггүй. Эрэгтэй хүнийг л ноён нуруу, алсын хараатай байдаг гэдэг.

-Эрчүүдэд олон давуу тал бий. Гэхдээ эмэгтэй хүний тэвчээр, гүйлгээ ухаан, төрөлхийн уян хатан зөөлөн чанар бизнесийн тэр ч бүү хэл, төрийн үйл хэрэгт амжилт авчирсан олон жишээ бий. Өнөөдөр бид нийгмийн хариуцлага гэж их ярьдаг. Гэвч хэрэгжүүлж байгаа нь хэд билээ. Харин эмэгтэй хүн нийгмээ хайрлаж, хариуцлагаа хэрэгжүүлж чаддаг. Ямар ч хүн хийсэн ажил нь үр дүн, өгөөжтэй, олны санаанд хүрч байвал сэтгэл

хангалуун байх нь мэдээж. Харин үүний тулд хийх гэсэн зүйлээ чанартай хийх ёстой. Тиймээс хамгийн түрүүнд хүний тухайн ажилдаа хандах зөв хандлага, хичээл зүтгэл, санаачилга юу юунаас чухал. Миний хувьд бизнесийн салбарт ажлыг амжуулж буй ур чадвар, хурд, бүтээлч зан, шинэ санаачилга амжилтыг араасаа дагуулдаг гэж боддог.

-Өнөөгийн эм эмэн бүтээгдэхүүний хангамжийн бизнесийн өрсөлдөөн хэр ширүүн бэ?

-Эм эмэн бүтээгдэхүүний хангамжийн асуудал нь их нарийн ажил. Ганц хүнд ч гэсэн бид хамгийн чанартай бүтээгдэхүүн хүргэх ёстой. Тэр утгаараа биднээс энэрэнгүй үнэнч байхыг энэ салбар шаарддаг. Энэ шаардлага өөрөө маш том өрсөлдөөний шалгуур юм.

-Өрсөлдөөнд баримталдаг таны зарчим.

-Компанийн сайн засаглалыг хөгжүүлж, удирдлагын шинэлэг арга барил, дэвшилт технологи ноу-хау нэвтрүүлэн ажилладаг. Мөн чанарыг эрхэмлэж хамгийн сүүлийн үеийн анагаах ухааны дэвшилт технологиор бүтээгдсэн, өндөр идэвхт, эм, эмийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх. Энэ нь манай компани зөвхөн ашгийн төлөө бус нийгмийн хариуцлагатай компани гэдгийг харуулж байгаа юм.

-Танай эм хангамжийн хэдэн хувь нь дотоодод үйлдвэрлэсэн байдаг вэ?

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж ажилладаг бөгөөд нийт хангамжийн 20 хувийг дотоодын эмийн үйлдвэрүүдээс бүрдүүлдэг.

-Эмэгтэй хүн бүр л чамин, тансаг зүйлд дурладаг. Өөрсдөө ч мөн хорвоог чимэхээр төрсөн чамин хүмүүс. Харин таны хэтэвчийг хоосолдог гоё цуглуулга юу вэ?

-Миний хамгийн дуртай зүйл бол ном. Өөрт таалагдсан ямар ч номоос мөнгө харамлаж байсан удаагүй. Мөн торгомсог алчуурын цуглуулгатай. Цаанаа л дэгжин хийгээд эрхэмсэг сангаддаг юм. Лондон, Парис, Милан гээд олон хотоос цуглуулгаа баяжуулсан. Харин сүүлийн үед хөдөө агаар салхинд гарах шиг гайхалтай зүйл алга санагдах болсон. Унасан газар, угаасан ус эх орноороо бахархдаггүй, монгол хүн гэж хаа ч байхгүй. Харин стрессээс гарахын тулд зураг зурах дуртай. Энэ бол миний хобби. Би багадаа өөрийгөө зураач болно гэж боддог байсан. . .

Түүний утас дуугарлаа "Японоос гэрээ хийх хүмүүс ирчихээд хүлээгээд байна" гэх дуун сонстох аж. Хүзүүнийхээ торгон алчуурыг намируулсаар тэр яаран гарч одлоо.

Түүний шургуу хөдөлмөрийг дэлхий үнэлж 2011 оны "Дэлхийн шилдэг бизнес эрхлэгч эмэгтэй" гэх эрхэм хүндтэй шагналаар шагнасан аж. Уг шагналыг Дэлхийн 21 шилдэг бизнес эрхлэгч эмэгтэй хүртсэн байна. Шагналыг гол утга учир нь олон улсын бизнесийн эмэгтэйчүүдийг дэмжих, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг үнэлэх аж. Нөгөөтэйгүүр шагналын эздийг торуулахдаа тухайн салбарт амжилттай яваа, нийгэмд өөрийн гэсэн хувь нэмрээ хэрхэн оруулж байгаа зэргийг нь ихээхэн харгалзан үздэг байна. Уг шагнал гардуулах ёслолыг нээж АНУ-ын Конгрессын гишүүн, хатагтай Каролин Малоне, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хилари Клинтон мэндчилсэн байна. Түүнчлэн дэлхийн нэр хүндтэй удирдагч, шилдэг бизнесмэнүүд цуглаж, эмэгтэй хүний өмнө тулгамддаг олон асуудлын талаар гарц хайн ярилцдаг аж.

Маргааш ба түүний мөрөөдөл

Түүний мөрөөдөл амар тайван аз жаргалтай амьдрал аж. Тиймээс ч тэрбээр өглөө бүр өөрийнхөө ойр дотнынхон, улс Монголынхоо хүн бүрийн тусын тулд цайныхаа дээжийг өргөж "Амар тайван, эрүүл аж жаргалтай амьдралын төлөө" хэмээн залбираад эрүүл энхийн манааг сахиулах их үйлсэд өөрийн ажил үйлсээр хувь нэмэр оруулахаар "Монголэмимпэкс концерн" ХК руугаа яардаг. Тэрбээр өдгөө хот, орон нутгийн 30 орчим салбарын 500 гаруй ажилчдыг удирдан чиглүүлж яваа эмэгтэй. Болормаа захирал цайныхаа дээжийг өргөхөө огтхон ч умартдаггүй аж. Монгол бүсгүй тэнгэртээ цайныхаа дээжийг өргөж байгаа цагт миний ард түмэнд зовлон ирэхгүй оддын тоогоор мөнх оршино. Учир нь, сацал өргөж байгаа монгол бүсгүй үргэлж сайхан сэтгэлээр хорвоогийн түмэн учрыг сүлдэг гэсэн буурлуудын үг байдаг. Хорвоогийн түмэн учрыг сүлж, сүр жавхлан, амжилт бүтээлээр дүүрэн яваа бизнесмэн бүсгүй Болормаа танд улам өндөр амжилт хүсье. ■



Сэтгүүлч Б.Баяртогтох шагнууллаа.

Шоо зураач, зохиолч А.Амарсайхан
“Нарийн багажаар харвал утаа арлжээ”
зургаа баярын бэлэг болгов.

Сурвалжлага

“Mongolian Economy” нэг нас хүрлээ

Б.Энхмарт

Өдийгөөс яг нэг жилийн өмнө Монголын сэтгүүл зүйд дуу хадаан мэндэлсэн манай “Mongolian Economy” сэтгүүл нэг насныхаа ойн баярыг чамгүй амжилт бүтээл, шинийг эрэлхийлсэн тэмүүлэл, бяцхан туршлагаараа бахархан, хамтран ажилладаг дотоод, гадаадын байгууллагууд, уншигч, захиалагчдынхаа төлөөллийг оролцуулан тэмдэглэлээ.

“Чингис” зочид буудлын “Тэмүүжин-1” танхимыг манай хамт олон өөрийнхөө байгууллагын өнгө төрх үйл ажиллагааны цар хүрээнд нийцүүлэн чимэглэж, энгийн даруухан хэрнээ ихэмсэг уур амьсгалыг бүрдүүлсэн юм. Бидний ийнхүү хичээн ажилласан манай урилгыг хүлээн авч, хүндэтгэн ирсэн зочдод таалагдаж байгаа нь илт байсан. Бидний ямар нэгэн тэмдэглэлт арга хэмжээний үеэр өргөдөг сүүн ерөөл зочдод ихэд таалагдаж, “Үүнийг чинь харин ёстой хэрэгжүүлмээр зүйл байна” хэмээн олзуурхаж байсан.

2011.02.24. Эл өдөр Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл монгол-англи хэл дээр уншигчдын гарт хүрсэн нь “Mongolian Economy” сэтгүүлийн анхны дугаар байлаа. Олон жилийн мөрөөдөл, сэтгэлдээ тээж, бойжуулсаар өлгөйдөн авсан “Mongolian Economy” гэх нэрийг хамт олныхоо баруун чихэнд шивнэхдээ хүчтэй, нийгэмд үнэ цэнэтэй, хурц ухаантай, онч хараатай, улс төрөөс ангид, зөв шударгын луужин байхыг билгэдсэн биз ээ манай эрхлэгч нар. Бид эдийн засгийн сэтгүүл гээд зөвхөн нэг чиглэлийг барьж, бусдыг орхигдуулахыг хүсээгүй. Монголын эдийн засаг, нийгмийн амьдралын энэ цагийн төрхийг сайн нярав, тооцоотой эзэгтэй, шударга иргэний нүдээр харж, тус салбарт байгаа гажуудлыг зөв ухаанаар залан чиглүүлэх, болж бүтэж байгаа бүхнийг урамшуулан дэмжих нэгэн хөшүүрэг байхыг хүсэж, зорьсон. Ингэхдээ амьдралын гэрэл гэгээ, хар бараанд орчлонгийн түмэн өнгө, элдэв нялуун, гашуун амтыг хольж, шингээлгүй үнэнийг толины тусгал мэт байгаагаар нь л илчлэхийг хүссэн. Ийм хүсэл тэмүүлэлтэйгээр сэтгүүл маань Монголын сэтгүүл зүйд мэндлэхэд ердөө дөрвүүлэхнээ гар гараасаа чанга гэгч нь атган тосон авч байжээ. Цаг хугацаа нэгэн жилээр урсан одсон ч бидний хүсэл тэмүүлэл, зорилго

өөрчлөгдөж, хувирсангүй.

Нэг жилийн дотор инфляцийн халуурал, шатахуун, цахилгаан дулаан, мах, талх зэрэг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, валютын ханшийн өсөлтөөс үүдэн иргэдийн амьдралд гарсан сөрөг үр дагавараас эхлээд эдийн засаг, бизнесийн салбарт хүндхэн асуудал цөөнгүй болжээ. Энэ бүгдэд бид бусдын нулимсаар уйлж, бусдын инээд, аз жаргалыг адилхан мэдэрч ирлээ. Төгрөгийн ханш үнэгүйдэж, валютын ханш чангарч, ард иргэдийн нуруун дээр “галзуурсан” үнийн хөөрөгдөл навтайтал дарж байхад бид баттай эх сурвалжийг нөхрөө хэмээн сэтгэж, чигч шулуун, үнэн үгээр луужин хийж, үзэг, дэвтэр хоёроороо ханиа хийсээр Монголын сэтгүүл зүйн их далайд дарвуулаа хийсгэлээ. Одоо ямар ч шуурга, чиггүй салхинд ганхаж, гудайхааргүй болж, бид хөлд, хөлд орлоо. Тэд ингэж үнэлж байсан. Тэд гэдэг нь манай уншигч, захиалагч, хамтран ажилладаг байгууллагуудын төлөөлөл гэсэн үг.

“Сэтгүүлийн анхны дугаарыг гурвуулхнаа бэлдэн, нойр хоолоо умартан зүтгэж байсан редакци маань шинэ залуу, мэдлэг, боловсролтой, шинийг эрэлхийлдэг залуу сэтгүүлчдээр бүл нэмсэн. Жилийн өмнө үйл ажиллагаа эхлүүлж байсан баг, хамт олны маань тоо өнөөдөр бараг 4-5 дахин нэмэгдсэн байна. Одоогоос яг нэг жилийн өмнө анхны сэтгүүлээ гаргачихаад уншигчдын зүгээс ямар хандалт, сэтгэгдэл, мессеж ирэх бол оо гэж догдлон хүлээж суужээ. Тэгээд хамгийн түрүүнд Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуяг утасдаж “Танай сэтгүүл эдийн засгийн асуудлуудыг маш сайн хөндөж чаджээ. Хоёр хоногийн дараа болох гэж байгаа Монголын эдийн засгийн чуулганд танай сэтгүүлээс ахиухан тоотой авъя” гэж хэлсэн нь бидэнд ихээхэн урам зориг өгсөн. Сангийн дэд сайдаас тийм сайхан санал сонсоод, бид үнэхээр зорилтот бүлгийн уншигчдадаа хэрэгтэй зүйл хийж чаджээ гэж урамшсан” хэмээн “Mongolian Economy” сэтгүүлийн Эрхлэгч Д.Бэхбаярын ёслолын арга хэмжээг нээж хэлсэн үг зочдын сэтгэлийг хөвсөлзүүлсэн болов уу.

Мөн манай нэг насны ойн баярт уригдсан зочид хэзээ ч мартаггүй, сэтгэл зүрхнээс арчигдамгүй нөхөрсөг, андын, эгчийн, ахын урмаар биднийг шагнасан. ▶



Ч.Отгочулууг сайн нийтлэлч болохыг ерөөв.

► FSCO корпорацийн гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан “Өнгөрсөн намар “Discover Mongolia”-г зохион байгуулах гэж байхад “Mongolian Economy” сэтгүүл мэдээллийн ивээн тэтгэгчээр хамтарч ажиллах санал тавьж байсан юм. Бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл шиг л байх юм бодож байлаа. Гэтэл тэнд яригдсан бүх зүйлийг өөрсдийн шинэ санаа, гарцыг ул суурьтайгаар дэлгэн тавьж, үнэхээр чадварлаг сэтгүүлчид ажилладаг гэдгээ харуулсан. Тэгээд “Discover Mongolia” арга хэмжээний үеэр яригдсан асуудлуудыг бүтэн жилийн турш дараагийн хурал болтол бичих саналтай орж ирсэн нь бүр их таалагдсан. Цаашид олон чиглэлээр хамтарч ажиллах боломжтой баг юм гэдгийг олж харсан. Тиймээс улс төрөөс ангид, үзэл бодолдоо үнэнч, эдийн засгийн тухай нийтлэг уйтгартай ойлголтыг шинэ түвшинд гаргаж, өөрийн байр сууриа баттай бэхжүүлэн урагшилж байгаа танай хамт олонд өдрөөс өдөрт дэвшин дээшлэхийн ерөөл өргөө” гэв.

“Mongolian Mining journal” сэтгүүлийн эрхлэгч Л.Болормаа “Сэтгүүлч сэтгүүлчдээ баяр хүргэж байна. Бэхээ, Отгоо бид гурав сэтгүүл зүйн нэг үүрнээс өд сөд ургасан амь нэгтэй сэтгүүлчид. Нэг тохиолдлыг энд дурсмаар санагдлаа. Одоогоос арваад жилийн өмнө Их Британийн Сангийн сайд нэгэн гэр бүлийн орлого, улсад төлдөг татвар зэргийг маш энгийнээр бичсэн байсан. Түүнийг уншаад бид “Эдийн засаг гэдэг бидний ойлгоод байдаг шиг тийм хэцүү, уйтгартай зүйл биш юм байна. Энгийн үгээр, амьдралын хөрсөнд буулгаад бичвэл ямар сонирхолтой болохыг тэндээс олж харж байсан юм. Тэгээд бид хэд “Өнөөдөр” сонинд барууны хэв маяг бүхий өнгө аястай эдийн засгийг нутагшуулахаар хоёргүй сэтгэлээр ажиллаж байлаа. Харин одоо бид мөн л хамтдаа Монголын сэтгүүл зүйд эдийн засгийн сэтгүүл зүйн шинэ орчин, хэв маягийг бий болгохыг зорьж явна. Та бүхний ажилд амжилт, амьдралд аз жаргалыг хүсэж байна” гэлээ.

“Өгөөж” компанийн захирал С.Түмэнгэрэл “Бизнесийн салбарт нэг жил гэдэг маш бага хугацаа. Гэтэл ийм бага хугацаанд энэ их ажлыг амжуулахын сацуу өөрийн гэсэн орон зай, хүрээллийн уншигчидтай болсон нь бахархаж, сайхан санагдаж байна. Нийгэмд болж буй бүхнийг олон талаас нь харж, түүнийгээ маш зөв өнцгөөс уншигчдад хүргэж, хамгийн чухал нь улс төрөөс ангид байдаг нь энэ сэтгүүлийн гол зарчим гэж би ойлгосон гээд амжилт хүссэн.

“Эко-Ази” дээд сургуулийн захирал, доктор, профессор Ц.Адъяасүрэн “Эдийн засаг, нийгэм, байгаль орчныг хамтад нь хөндөж бичдэг ганц сэтгүүл бол “Mongolian Economy”. Ногоон эдийн засгийн тухай хүн бүхэн ярьж байгаа ч энэ чиглэлийн замбараагүй мэдээллийн дунд танай сэтгүүл иргэдэд зөв чиглэлийг зааж, гарч болох эрсдэлийг таниулах их үүрэгтэй. Үүнээс гадна эдийн засгийг маш энгийнээр

илэрхийлж, ирээдүйн эдийн засгийн чадварлаг сэтгүүлчдийг хүмүүжүүлж байгаа нь бахархалтай байна. Бид олон талаар хамтран ажилладаг. Цаашид ч улам батжиж, илүү ихийг хамтдаа бүтээнэ. Бүгдэд нь сайн сайхныг хүсье” гэсэн.

Бидний баярт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн захирал Штефан Хансельманн, “Евразиа капитал” хөрөнгө оруулалтын банкны захирал Алишер Али, “Женерал Электрик” компанийн суурин төлөөлөгч Ц.Түмэнцогт, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал Ч.Отгочулуу, “Ньюком” группийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан нарын эдийн засаг, бизнесийн салбарын хүндтэй зочид ирсэн. Тэд биднийг “Монголын сэтгүүл зүйн салбарт нэгэн шинэ, дахин давтагдашгүй өнгө төрхийг бүрдүүлж чаджээ” хэмээн үнэлсэн юм.

Сэтгүүлийнхээ редакцийн өрхийг татаж, үүдийг нээж байсан үеийг “Mongolian Economy” сэтгүүлийн Орлогч эрхлэгч И.Отгонжаргал дурсахдаа “Сэтгүүлийг минь төрөхөд өлгийдөн авч, цахиур нь цухуйхыг харж, дэгэж дэрвэхэд нь даган баясаж, тэнтэр тунтар алхахад түшилцэж, одоо хөл нь улам сайн чангараасай хэмээн хүлээж суугаа эрхэм хүндэт хамтран ажиллагсад, захиалагч, уншигчдын төлөөлөл болсон та бүхэндээ баярлаж явдгаа хэлэх нь зүйтэй болов уу. Сэтгүүлийнхээ хамгийн анхны дугаарыг үйлдвэрээс хүлээж авах тэр үед сэтгэл маш их догдолж байсан. Өнөөдөр бид бүтэн нэг жилийн хугацаанд арав гаруй дугаар гаргаад байгаа хэрнээ шинэ сэтгүүлээ харах гэж догдолдог тэр сэтгэл хэвээрээ.

Монголд улс төргүй эдийн засаг, улс төргүй сэтгүүл зүй, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн давхар давхар сүм хийдийн оргилд гарах том зорилт бидний өмнө бий. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд тэрхүү сүм хийдийн урт шатны дөнгөж эхнийх дээр нь хөлөө тавиад байна. Цаашаа оргил өөд улам илүү эрч хүчтэй, зоримог мацах болно” гэв.

Мөн бидний уншигч, захиалагч, хамтран ажилладаг хүмүүсийнхээ зүгээс өндөр үнэлгээ авсан нэг зүйл нь нэгхэн жилийн хугацаанд зөвхөн сэтгүүл гаргаад зогсоогүй, www.mongolianeconomy.mn цахим хуудас монгол-англи хэл дээр ажиллуулж, “Economy” TV студи, “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллага байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн явдал байлаа.

“Үнэхээр зөв эрч хүчтэй санаа нийлсэн баг бүрдвэл маш богино хугацаанд юу хийж болдгийг танай хамт олон харууллаа. Байгууллага, хамт олон бүхэн ийм байх юм бол Монгол Улс хөгжихөд амархан байна” хэмээн Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ын дарга Б.Болдын хэлснийг ►

► энд тэмдэглэхэд таатай байна. Анхны дугаараас эхлээд өнгөрсөн нэг жилийн хугацаанд хөрөнгийн зах зээлийн талаар сэтгүүлд маань цуврал ярилцлага өгч, хамтарч ажилласан Болд захиралдаа баярлалаа гэдгээ сэтгүүлээрээ дамжуулан уламжилъя. Таны хөрөнгө, санхүүгийн зах зээлтэй холбоотой ярилцлагыг уншигчид маань шимтэн уншдаг төдийгүй иргэдэд танин мэдэхүйн, мэдлэг өгөхүйц байж чаддаг нь олзуурхдаг. Таныг манай сэтгүүлийн баярын үеэр “Хамтын ажиллагаагаа ирэх он жилүүдэд улам бататгаж, урт хугацаанд хамтран ажиллана” гэж амласанд мөн талархаж буйгаа илэрхийлье.

Түүнчлэн төрсөн өдрийн баярын хамгийн сэтгэл догдлуулсан мөч нь хийсэн бүтээснээрээ хамт олноо манлайлж яваа ажилтнуудаа шагнаж, урамшуулсан явдал байлаа.

Мэргэжлийн хүний үг гэдгээрээ ч тэр, нийтлэл бичих урлагт суралцан, дадаж байгаа байдлаараа ч тэр бидний хувьд хүндтэй уран бүтээлчийн нэг бол Монголын эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал Ч.Отгочулуу билээ. Шагнал гардуулахаар индэр дээр гарсан

хоёр эрхлэгч маань түүний нэрийг хүндэтгэлтэйгээр дуудсан. Отгочулуугийн өнгөрсөн хугацаанд манай сэтгүүлд нийтлүүлсэн бүтээл, хөдөлмөр, авъяасыг үнэлж, хүндэт өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр урамшуулсан. Дараа нь сэтгүүлийн англи хэлний редактор Terrence Edwards-ийг шагнасан юм. Өнгөрсөн хугацаанд хамгийн сайн ажиллаж, шилдэг нийтлэл олныг бичиж, уншигчдын зүгээс магтаал сайшаалын үг олонтаа сонсож буй залуу сэтгүүлч Б.Баяртогтохыг цаашид улам ихийг хийгээрэй хэмээн урамшуулсан. Мөн манай байгууллагын хамгийн хөрвөх чадвар сайтай ажилтан төдийгүй сэтгүүлийн маань ууган ажилтнуудын нэг нягтлан Б.Энхцэцэг, бидний хичээнгүйлэн хөдөлмөрлөж гаргасан сэтгүүлийг маань хугацаа алдахгүй захиалагч, уншигчдад хүргэх, реклам сурталчилгаа олох гээд түмэн завгүй гүйдэг Маркетингийн менежер Д.Бариянжав, Борлуулалтын менежер С.Цэнд-Аюуш нар ч шагнал гардсан.

Арав, хорь, тавь, зуун насныхаа ойг хамтдаа тэмдэглэх уншигчдын маань ажил үйлс үргэлжийн бүтэмжтэй байж, өөдлөн дэвжих болтугай. ■

Амьдрал

Эх орны хөвгүүд

Б.Март

Тунгалаг цэнхэр тэнгэрт эртэч шувууд жиргэж, хавар эртний жихүүн салхи сэвэлзсэн өглөөгүүр Д.Сүхбаатар жанжны үүсгэн байгуулсан Хужирбулан дахь Зэвсэгт хүчний 015 дугаар ангиас “Mongolian Economy” сэтгүүл “Амьдрал” булангаа байлдагчдын нэг өдрөөр үргэлжлүүлж байна.

08.50 цаг. Гурван цэрэг Монгол Улсын төрийн далбааг хүндэтгэлтэйгээр барьсаар 015 дугаар ангийн талбайд гарч ирэв. Энэ үеэр төрийн дуулал эгшиглэх аж. Эгнэн жагссан цэргүүд төрийн далбаандаа хүндэтгэл үзүүлэн төрийн далбаа мандлаа. Тус ангийн нэг өдрийн буцалсан амьдрал эхэлж байгаа нь энэ. Төрийн далбаа мандуулах ёслолын дараа Ангийн захирагч, хурандаа С.Түвшинбаяр, Штабын дарга Ц.Буянтогтох нар офицер, ахлагч, байлдагч нарт энэ өдрийн үүрэг даалгавар болоод ирэх сард болох Марш тактикийн тэмцээн, бусад уралдаанд амжилттай оролцох бэлтгэлээ хийхийг үүрэгдэв. Ингээд байлдагчид жагсаалын дуу гарган ангийн зүг нир нир хийтэл хөл нийлүүлэн алхсаар явж одлоо. Ихэнхдээ гадаа салхинд дасгал сургуулилт хийдэг болоод ч тэр үү, цэргүүдийн нүүр тос даан борложээ.

“Үл мэдэгч” одоо бүхнийг мэддэг болсон

09.30 цаг. Хуваарийн дагуу энэ өдрийн хичээл эхэллээ. Байлдагчдын ихэнх нь 12 хуудастай тооны болон тууш шугамтай дэвтэр дээр хичээнгүйлэн бичиж байгаа харагдав. Цэргүүд захиа бичих гэж бөөн юм болдог байна. Хайртай бүсгүй рүүгээ захиа бичиж байгаа болохоор ихэд





нууцалдаг аж. Тус цэргийн ангид алба хаагчид зэвсгийн бага мэргэжилтэйгээр албаа хаадаг байна. Ирэх тавдугаар сард халагдах таван байлдагчийг Барилгын цэргийн 013 дугаар ангид III зэргийн гагнуурчин мэргэжлээр суралцуулж, мэргэжлийн үнэмлэхтэй болгожээ. 015 дугаар анги зэвсэгт хүчний арын албыг хариуцдаг учраас тус ангийн байлдагчид зэвсэгтэй харьцах, ашиглах, арчлах тал дээр мэргэших учиртай. Тиймээс ерөнхий эрдмийн найман хичээл өдрийн зургаан цагаар ордог бөгөөд үүний дээр компьютер, англи хэл заадаг байна.

Армид ирэхдээ бичиг үсэг мэддэггүй байсан цэргүүдийг “Үл мэдэгч” гэдэг аж. Сургалт хариуцсан хошууч С.Сүхжав “Офицер, ахлагч нарт болон хугацаат албан хаагчдад байлдааны анхан болон ерөнхий эрдмийн найман төрлийн хичээлийг шатлалын дагуу орж байна. Бичиг үсэг мэдэхгүй хүний тоо 20-иод жилийн өмнөхийг бодоход эрс цөөрсөн. Манайх гурван үл мэдэгчтэй байсан бол одоо уншиж, бичиж чаддаг болоод байна. Сургалтын болон байлдааны ангийн цэргүүд хичээлийн бус цагаар номын санд сууж ном уншиж, хичээлээ давтана. Манай энэ хавьд шилэн кабель байхгүй болохоор интернэтэд холбогдох боломжгүй” гэж ярьсан.

Долоон байлдагч ахлагч болж улирах хүсэлтэйгээ илэрхийлжээ

11.30 цаг. Удахгүй болох Зэвсэгт хүчний Марш тактикийн тэмцээнд оролцохоор тус ангийн офицер, ахлагч, байлдагчид бэлтгэлдээ гарлаа. Хэнтий аймаг дахь 232 дугаар цэргийн ангиас 10 байлдагч тус ангитай хамтарч тэмцээнд оролцохоор ирээд байсан юм. Буудлагын сургуулилт хийх эрх бүхий хоёрхон газрын нэг нь тус ангид хамааралтай. Гэвч сүүлийн жилүүдэд хотын тэлсэн их нүүдэл тус ангийн эргэн тойрныг бүчжээ. Энэ суурьшилт цаашид нэмэгдвэл буудлагын сургуулилт болон бусад үйл ажиллагааг явуулахад ихээхэн хүндрэлтэй болох талаар тус ангийн Штабын дарга, дэд хурандаа Ц.Буянтогтох ярьж байсан.

Цэргийн алба хаана гэхээр аль нэг цэргийн ангид хуваарилагдаад, тэндээ жилийн турш алхаж, гүйж, “дэглүүлж” өнгөрдөг хэмээн зарим хүн ойлгодог. Тэгвэл үгүй ажээ. Цэргийн ангиудын дунд авхаалж самбаа, хүч чадал, оюун ухааныг нь сорьсон уралдаан тэмцээн төлөвлөгөөний дагуу улирал тутамд зохион байгуулагддаг юм байна. Тус ангийн офицер, ахлагч, байлдагчдын баг “Ширэн бээлий” клубтэй хамтран Гардан байлдааны тэмцээнд оролцохоор бэлтгэлээ базааж байсан юм. Тэдний бэлтгэлээ базаахыг харж байх зуур нэгэн байлдагч Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн дунд зохион байгуулж буй шатрын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор “Заавал алтан медаль авчрах” тушаалтайгаар явсан юм. Дээрх тушаалыг өгсөн 015 дугаар ангийн захирагч С.Түвшинбаяр “Монгол цэргийн өдөр”-ийн мэндийг Зэвсэгт хүчний нийт алба хаагчдад хүргэж, сайн сайхныг хүсэж байсан.

1921 оны долоодугаар сард Ардын журамт цэрэг Богдын хүрээг чөлөөлсний дараа мөн оны наймдугаар сарын 30-нд Сүх жанжин тус цэргийн ангийн үндэс суурийг тавьж, “Зэвсгийн агуулах” нэртэйгээр үүсгэн байгуулсан түүхтэй. Ууган цэргийн ангиудын нэг болох тус Штабын дарга, дэд хурандаа Ц.Буянтогтох “Сүүлийн жилүүдэд Засгийн газар, Батлан хамгаалах, яам, Жанжин штаб зэрэг бодлогын газруудаас цэрэг, армид явуулж буй бодлого, үйл ажиллагаа маш өгөөжтэй, үр дүнтэй байна. Үүний үр дүн нь жилээс жилд цэргийн алба хаах хүсэлтэй залуусын тоо нэмэгдэж байна. Манай ангийн хувьд л гэхэд ирэх хавар халагдах ▶

<http://www.mongolianeconomy.mn>

► байлдагчдаас долоон цэрэг улирч, армийн албан хаагч болох хүсэлтэй байгаагаа илэрхийлээд байгаа. Энэ бол цэргийн амьдралд шинэ ирээдүй бий болсныг харуулж байгаа хэрэг юм” гэлээ.

Тус ангийн хамгийн олон жил буюу 34 дэх жилдээ алба хашиж байгаа Ч.Мягмарсүрэнтэй орчин үеийн цэргүүдийн талаар цөөн хором хөөрөлдөв. Тэрбээр “Би 1978 оны цэрэг. Тэр үеийн цэргийн амьдралыг одоогийнхтой харьцуулах юм биш. Бүх юм нь бэлэн, өөрсдийн хүсэл сонирхлын дагуу бүхнийг хийж, хүсвэл чадварлаг мэргэжилтэн болоод гэртээ буцах ч боломжтой болжээ. Энхийг сахиулах ажиллагаанд манай ангиас л гэхэд 15 ахлагч явсан. Удахгүй нэг ахлагч явах гэж байгаа” гэж ярилаа.

Цэрэг-Зэрэгц

14.00 цаг. Цэргийн алба хаагчид, штабын ажилтнууд төрийн далбааны өмнө, тэдний нэрлэж заншсанаар “Нэгтгэл”-д ирнэ. Өглөө авсан үүргээ гүйцэтгэж, үдээс хойшхи ажлаа хүлээж авна.

2002 оноос хойш манай цэрэг, цагдаагийн 5000 гаруй бие бүрэлдэхүүн НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоод байгаа юм. Харин одоогийн байдлаар Монголын 1000 гаруй эрэлхэг хөвгүүд Чад, Афганистан, Ирак зэрэг таван оронд үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь Монгол Улсын нэр хүнд тодорхой хэмжээгээр өсөх нэг шат бөгөөд энэ байдлаараа энхийг сахиулах ажиллагаанд дайчдаа тогтмол оролцуулсаар байвал манайх 2015 он гэхэд гурван батальонтой болох аж.

Номтой нөхөрлөх цагаар

15.30 цаг. Чөлөөт цаг эхэлж байна. Ном унших нь уншиж, шатар тоглох нь тоглоно. Даалгавраа хийнэ, захиагаа бичнэ. Хоёр цагийн турш үргэлжлэх чөлөөт цагийг байлдагчид өөрсдийн хүслээр л өнгөрүүлнэ. Ихэнх нь ирэх сард болох Зэвсэгт хүчний Марш тактикийн тэмцээнд бэлдээд завгүй.

“Хоолондоо цадахгүй гэх хүн байхаа больсон”

Тэр өдрийн ахлах тогоочоор С.Энхтуяа, туслахаар Б.Дэмбэрэлцэцэг нар ажиллаж байсан бөгөөд өглөө хөц будаатай шөл, талх масло, элсэн чихэр, цай, өдөр гурилтай шөл, будаатай хуурга, орой тасалсан гурилтай шөл өгөхөөр цэс гаргажээ. 1990-ээд онд цэргүүд төдийгүй нийгэм тэр аяараа хонхолозсон ходоодтой, юм юм хомс байсан болоод ч тэр үү, тухайн үед армид татагдсан цэргийн олонхи нь сэтгэлийн өлсгөлөнд нэрвэгддэг байсныг тогооч эгч нар дурдсан. Одоо бол хоолондоо цадахгүй байна гэх гомдол гарахаа байгаад удаж байгаа гэв.

“Түрүүч ээ, тайчиж дууслаа”

17.00 цаг. Жил жилийн халагдах цэргүүдийн дуулах дуртай дуу бол “Хурд” хамтлагийн “Халагдах цэргийн вальс” хэмээх дуу. Мөн хөгжилтэй зүйл олон гардаг гэнэ. Шинээр ирсэн цэргүүд алхаж чадахгүй байх нь энүүхэнд. Мөн шөнө болгон уйлж, ярьж зүүдэлдэг цэрэг ч байсан гэсэн. Тус ангийн цэргүүд хоёр сарын өмнө болсон үйл явдлыг ярих аж. Буу задалж угсрах сургуулилт хийж байтал нэг цэрэг “Түрүүч ээ, тайчиж дууслаа” гэж хамт олноо нэр хийтэл инээлгэсэн хөгжилтэй явдал болжээ.

Халагдах өдрөө тоолон догдлох цөөн байлдагчтай уулзаж, сэтгэгдлийг нь сонслоо.

Булган аймгийн Могод сумаас ирсэн А.Алтанбагана “Хайрт аав, ээждээ энэ өдрийн мэндийг дэвшүүлээд, хүү нь Зэвсэгт хүчний бүх цэргийн ангийн дунд зохион байгуулсан “Гийр өргөлт”-ийн тэмцээнд амжилттай оролцож хүрэл медаль авсан. Одоо Гардан байлдааны тэмцээнд орохоор бэлтгэлээ хийж байна. Та хоёртоо болон ах, дүү хамаатан садан, найз нөхөд дээрээ очих өдрийг хоног тоолон хүлээж байна” гэв. Түүнчлэн байлдагч Э.Дашням “Өвөрхангай аймгийн Баянгол суманд суугаа аав А.Энхжаргал, ээж Д.Дорж нартаа болон хоёр дүүдээ хайртай шүү. Хүү нь цэргийн хүн болохоор шийдсэн. Жагсаалд дуу гаргаад, төрийн далбаандаа ёслол хүндлээд алхаж явах цаанаа л гоё юм” гэлээ. Байлдагч Г.Эрдэнэболд “Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд суугаа аав Д.Ганбат, ээж Д.Панаасүрэн болон найз охин Б.Сувд-Эрдэнэдээ та нарыгаа маш их санаж байна. Удахгүй халагдаад очно оо. Хайртай шүү” хэмээн уламжилж өгөхийг хүссэн.

22.00 цаг. Байлдагчид бүгдийг дуусгах ёстой. Захны цагаан давуугаа сольж, шинэ өглөөдөө бэлтгээд тэд орондоо орцгоолоо.

Жанжин Д.Сүхбаатарын үүсгэн байгуулсан 90 жилийн настай тус ангийн зарим эд хогшлыг шинэчилж, засмаар санагдсанаа нуух юун. Хэдий надад тэгж санагдсан ч он оны байлдагч нартаа ирэх бүрт нь дурсамж хөврүүлж, сэтгэл гэгэлзүүлсэн их өргөө байдаг биз ээ. Хал цэргүүд гэртээ харьж, шинэ цэргүүд хал болоход хоёр сар хүрэхгүй хугацаа үлджээ. ■



Эрүүл мэнд

Ирээдүйн аав Та эрүүл байж чадаж байна уу

Х.Бөртэ

Манай улсын нийт хүн амын 48.8 хувь нь эрчүүд. Тэдний 67-73 хувь нь зүрх судас, элэг, уушги, хоол боловсруулах эрхтэн, хорт хавдар, түрүү булчирхай, бэлгийн замын халдварт өвчинтэйг Эрүүл мэндийн яам, ДЭМБ-аас өнгөрсөн онд гаргасан судалгаанд дурджээ. Эрчүүд зонхилон өвддөг дээрх өвчнүүд архи, тамхины хэрэглээ, стрессээс үүдэлтэйг тус тайланд онцолсон байна.

Дэлхий дээр найман секунд тутамд нэг хүн тамхины хор хөнөөлөөс болж нартыг орхидог бол архины уршгаар гурван секунд тутамд нэг хүн таалал төгсдөг байна. Ингэж зуурдаар амиа алдагсдын 63-68 хувийг эрчүүд эзэлдэг аж. Тэдний дундаж наслалт 32-45 байдгийг ч дурджээ.

Мөн Нийслэлийн эрүүл мэндийн газраас өсвөр насны хүүхдүүдийн дунд явуулсан судалгаанд 13-18 насны нийт хүүхдийн 62-68 хувь нь архи, тамхи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн гэжээ. Түүнчлэн үүний 36 орчим хувь нь архи, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг гэдгийг тогтоожээ. Тэдний 93 хувь нь хөвгүүд аж. Харин дээрх байгууллагын Наркологийн судалгаагаар насанд хүрэгсдийн 55.2 хувь нь архи хэтрүүлэн хэрэглэж, жилдээ 140.000 хүн эрүүлжүүлэгддэг, архинд донтох эмгэгээ эмчлүүлэх шаардлагатай 12.000 хүн байгаа тухай дурджээ. Манай улсын хэмжээнд архидалтын улмаас золгүй тохиолдлоор жилд 1000 гаруй хүн хорвоогоос буцдаг гэсэн тоо байна. Архинаас үүдэлтэй гэмт хэргийн 55.2 хувь нь нийслэл хотод, 43.7 хувь нь хөдөө, орон нутагт гарч байна. Энэ нь Монгол Улс бүхэлдээ буюу хөгшин залуугүй, хот хөдөөгүй архин далайд живж байгааг харуулж байгаа хэрэг гэж үзэж болох нь ээ.

Тамхи татдаггүй, архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй хүн монголчуудын дунд харьцангуй цөөхөн болжээ. Сүүлийн үед архи, тамхи хэрэглэдэггүй баяр ёслол ч гэж бараг байхгүй болсон. Сар болгонд шахуу бүх нийтээрээ тэмдэглэх ёстой ямар нэг баяр, ой, ядаж л хэн нэгний төрсөн өдөр гээд хавтгайрсан найр шил дараалан өрнөж байна. Хэн нэг нь архи, согтууруулах ундаагүйгээр, тамхигүй орчинд төрсөн өдөр ямар нэг баяр тэмдэглэнэ гэвэл урьсан зочид нь тоож очихгүй, ирсэн нэгнийх нь нүд орой дээрээ гарч эвэртэй туулай үзсэн мэт болох биз. Бид нэгнийгээ ийм сэтгэхүйтэй болтол нь архиар дайлжээ. Үүний төлөөс нь зөвхөн эрүүл бүс эрүүл мэнд. Ядарч, зүдэртлээ ажиллаж олсон хэдэн төгрөгөө шилтэй цэнхэр, хайрцагтай янжуурт өгч, оронд нь өвчин, зовлон үнэггүйгээр авсаар байна. Дэлхийд чанараараа тэргүүлэгч ноос, ноолуур, чацарганаа бид дэлхийн зах зээлд гаргаж чадахгүй атлаа архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, хэрэглээгээрээ ОХУ-ын дараа удаалж явна. Тиймээс архи, тамхины хэрэглээнд хязгаар тавьж, импортын бодлогыг чангатгах нь юу юунаас чухал гэдгийг энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг мэргэжлийн байгууллагынхан анхааруулсаар буй. Мөн архи, согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулагчдад тавих шаардлагыг ч өндөржүүлж, худалдаалах цагийг богиносгох хэрэгтэй гэдэг. Үүнээс

гадна Эрүүлжүүлэх байрт саатуулагдсан иргэдээс авдаг торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатайг холбогдох албаныхан хэлсээр байгаа ч хаданд хашгирахтай адил байх шиг. Нийслэлд ганцхан хоногт л гэхэд 150-180 гаруй иргэн Эрүүлжүүлэх байраар үйлчлүүлдэг гэсэн тоо баримт ч бий.

Дээр дурдсан Нийслэлийн эрүүл мэндийн газраас өсвөр насны хүүхдүүдийн дунд явуулсан судалгаанаас үзэхэд ирээдүйн эцэг, айл гэрийн эзэн болох 15-16 настай хөвгүүн Та эрүүл мэндийн хувьд эрүүл хүн мөн үү гэдгээ эргэцүүлж бодоход илүүдэхгүй л болов уу. Ирээдүйн эцэг хүнийг өсгөж, хүмүүжүүлж буй аав Та эрүүл байж чадаж байна уу. Архи, тамхинд бурууг өгөлгүй, түүнийг хэрэглэж хэвшсэн зуруул, сэтгэхүйтэйгээ яг өнөөдрөөс ажиллаж, ангижирахыг оролд.

Хайртай аав, хань, дүү, хүүгээ архи, тамхи хэмээх амьдаар нь мэрж дуусгадаг тахлаас хэрхэн аварч чадах вэ, Та. Архи, согтууруулах ундаагүй баярын ширээ, тэмдэглэлт ойг яагаад зохион байгуулж болохгүй гэж.

“Mongolian Economy” сэтгүүлээс архи, тамхигүй баяр, уулзалт зохион байгуулж хэвшүүлэх, сард нэг удаа байдаг архи худалдан борлуулах хориотой өдрийн тоог олон болгох санал санаачилга гаргаж байна. Оюуны чадамжаараа дэлхийд тоогддог цөөхөн монголчууд эрүүл байх ёстой.

Тамхи хаях зургаан "3"-гийн зарчим

1. Зарлах: Би тамхийг хаяхаар шийдсэн гэж өөртөө болон бусдадаа зарлан хэлээрэй

2. Зайлсхийх: Тамхитай холбоотой бүх зүйлсийг өөрөөсөө холдуулаарай. Тамхи татах хүсэл 3-5 минут л үргэлжилдэг болохоор энэ хугацааг л Та анхаарлаа өөр зүйлд хандуулвал тамхи татах хүсэл тань үгүй болно.

3. Зөв амьсгалах: Хамраараа гүн амьсгаа авч зуугуухан гаргах

4. Зөвхөн шингэн зүйл уух: Тамхи татмаар санагдсан үед 1-2 аяга усыг аажмаар шимж уугаарай

5. Завгүй байх: Хэн нэгэнтэй ярих, тайвшрах, бохь захилах гэх мэт дуртай зүйлээ хийгээрэй

6. Залбирах сүсэглэх: Өөрөө өөртэйгээ ярих аргыг хэрэглээд үзээрэй



Бизнес зөвлөгөө

Бизнес эрхлэгчдийн 11 нийтлэг алдаа

Бизнесийн гараагаа шинээр эхэлж буй төдийгүй туршлагатай бизнес эрхлэгчид ч гэсэн саад бэрхшээлтэй тулгардаг. Жижиг, дунд, том гээд бүх л хүрээний бизнес эрхлэгчдэд зориулж анхаарвал зохимжтой хамгийн түгээмэл тохиолддог нийтлэг алдааг хүргэж байна.

1. Тооцоогоо толгойдоо хадгалах

Ихэнх бизнес эрхлэгч өөрсдийн санхүүгийн байр суурь ба ашгийн дээд хязгаараа мэддэг боловч санхүүгийн мэдээлэл хоцрогдсон эсвэл агуулга муутай байваас машинаа дугуйгаар нь өнхрүүлэх бус зөвхөн түлхүүрдсээр байгаатай адил.

2. Эмх замбараагүй байдал

Системчлэл байхгүй үед алдаа гарах нь зайлшгүй аж. Хэрэв Та болон таны доор ажиллаж байгаа ажилчид эн тэргүүнд хийх зүйлээ ангилсан эсвэл тухайн зорилгоо биелүүлэхэд юу хэрэгтэй байгаагаа нэг бүрчлэн жагсааж бичээгүй бол өдөр бүр ажлын бүтээмжийн 50 хувийг зөвхөн нэг алдаагаа дахин засварлах, мэдээлэл хайх болон дахин шийдвэрлэхэд гарздах болно.

3. Бусдад хариуцуулаагүйгээс

Хэрэв Та бизнес эрхлэх явцдаа ажлаа зөвхөн өөрөө хийж бусдад хариуцуулахаа мартсан бол өөрийн зүгээс оруулж чадах хамгийн том хувь нэмэр буюу компани алсын хараагаар хангах ажлаа хийж чадахгүй болсон гэсэн үг. Мэдээж энэ тохиолдолд Та шаардлагатай удирдамж өгч чадахгүй болох учир таны бизнес ч ухрах аюултай.

4. Төлөвлөгөөгүй байх

Бизнес хийх явцад тухайн газар бизнес төлөвлөгөөнөөс гадна цаашид

юунд хүрч болох талаар дэлгэрэнгүй зураглал байх ёстой. Үүнд цаашид ямар байдлаар зах зээлийг эзлэх тухай баримт бүрдүүлэх нэн шаардлагатай.

5. Ашиг ба бэлэн мөнгөний урсгалын хоорондох ялгааг ойлгоогүйгээс


Ихэнх бизнест ашиг ба бэлэн мөнгөний хооронд харьцангуй ялгаа байдаг. Тиймээс энэ хоорондох ялгааг аль болох багасгаж тэнцвэртэй ойлголтод тулгуурласан үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй.

6. Үйлчлүүлэгчийн оюун ухаан дахь үнийн тухай бодлыг илүү үнэлэх

Танд маш сайн бараа бүтээгдэхүүн хамгийн бодит үнээр байлаа гэж бодъё. Та бараагаа сурталчилж, үүний дараа тань дээр олон хүн ирнэ хэмээн хүлээж байгаа байх. Гэвч бараа бүтээгдэхүүний борлуулалтыг зөвхөн үнэ ба үйлчилгээний талаас харвал нэг л өдөр үсээ халзрахыг анзаарах байх. Харин энд маш чухал юмыг нэмж хэлэхэд худалдан авагч буюу үйлчлүүлэгчийн сэтгэл санааны хэрэгцээг мэдэрч түүнийг хангаж сурвал таны бараа зах зээл дээр ямар ч саадгүй борлогдоно.

7. Туршиж үзэхээс илүү тааварлах

Ихэнх тохиолдолд бизнесийн талбарт ямарваа үйл ажиллагааг эрхлэхдээ энэ нь ингэж явагдсаар ирсэн гэх үндэслэл дээр юм уу эсвэл ихэнх нь ингэж хийдэг гэдэг зарчим дээр тулгуурладаг. Харин Та шинжлэх ухааны сургалтад суусан бол хүмүүсийн итгэдэг зүйл нь тухайн үр дүнгээс өөр байхтай тулгарах нь элбэг. Таны хөрөнгө хаясан зар сурталчилгаа хэр үр дүнтэй байгаа вэ гэдэг асуултыг эхнээс нь дахин эргэж харахыг зөвлөж байна. Танд байгаа нотолгоон дээр үндэслэлд шийдвэрээ гаргаарай.



8. Хамгийн өртөг багатай шийдэл

Дэлхий дээрх хамгийн үр нөлөө бүхий маркетингийн стратеги нь үнэгүй эсвэл хамгийн хямд байх нь элбэг. Гэхдээ та өөрийн вэбсайт болон гарын авлага, олон нийтийн мэдээлэлд зориулсан хуудсаа өөрөө биш харин мэргэжлийн хүнээр хийлгэхийг зөвлөж байна. Учир нь мэргэжлийн бус хүн хийх тохиолдолд мэргэжлийн хүнээс илүү зардал гардагтай холбоотой.

9. Чадвартай ажилчныг өөртөө татах стратеги байхгүйгээс

Хүний нөөцийн менежментийн стратегийг хэрэгжүүлэх нь нэн чухал. Ийм ажлыг мэргэжилтнээр хийлгэх хэрэгтэй боловч байхгүй тохиолдолд ажилтнаа алдах, дахин хүн сургах зэрэг хэд дахин өндөр өртөг төлөх хэрэгтэй болохыг санахад илүүдэхгүй биз.

10. Өөрөө өөртөө анхаарал тавихгүй байх

Жижиг бизнес эрхлэгчид өөрсөддөө анхаарал тавихдаа муугаараа алдартай. Тэдний хувьд амьдралаас илүү бизнес чухал байдаг. Ингэснээрээ бусад салбарт өөрсдийн өсөх боломжоо хязгаарлан бизнесээ илүү эрч хүчтэйгээр хийх хүсэл эрмэлзлэлээ ч мөн адил алддаг.

11. Үргэлжлүүлэн суралцахын ач холбогдлыг ойлгох

Бизнес эрхлэгчид нь үргэлжлүүлэн суралцаар л байх хэрэгтэй. Энэ нь тухайн хүний өсөлт хөгжилтөөс гадна юуны өмнө зах зээл дээр хэрэг болдог. Бизнес эрхлэгчдэд гаргадаг өөр олон алдаа байдаг ч эдгээр 11 алдаа хамгийн түгээмэл тохиолддог. ■

Бизнесийн завсарлага

Таны амьдралд өөрчлөлт авчирсан номоо нэрлэхгүй юү?

Миний оюун санаанд гүн мөрөө үлдээсэн ном

Х.Алтай /Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал/:

-Нэрт нийтлэлч Б.Баабар гуайн 1996 онд хэвлэгдсэн “Дори идэр дүүдээ” номыг 15 насандаа уншиж байлаа. Миний оюун санаанд гүн мөрөө үлдээсэн номны нэг/ тэрбээр номоо үзүүлэв/. Дүү нартаа хэлэхэд заавал унших номны нэг юм шүү. Хуудсыг нь нээхэд л хөтлөөд явчих сонирхолтой, уншууртай. Ертөнцийг таних, мэдлэгийн цар хүрээгээ тэлэхэд тус болно

байх. Сүүлийн үед номын дэлгүүр, номын зах зээлд шинэ уур амьсгал бүрдэж байгааг анзааралгүй өнгөрч боломгүй. Хүмүүс ч номын дэлгүүрт зочлох дуртай болсон байна билээ. Ажлын холбогдолтой номыг голдуу уншиж байна. Одоо бол С.Цогтсайханы “Бид араншин: Гурван монгол зодолдоно”, С.Баярын ярилцлагын “Би ирээдүй рүү нүүр бардам харна” номыг уншиж байна. Миний ширээний номнууд байгаа юм. Намтарчилсан, түүхэн номнуудыг илүү цаг гаргаж уншдаг.



Ертөнцийг харах цонх

З.Шагдарсүрэн /Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/:

-Robert Axelrod “The Evolution of Cooperation” номыг одоогоос 10 гаруй жилийн өмнө Япон хэлнээс уншиж байсан юм. 1989 онд Япон хэлнээ орчуулагдсан. Энэ номыг би хэзээд ширээн дээрээ байлгадаг. “The Evolution of Cooperation” хүнтэй харилцах шинжлэх ухааны талаарх дэлхийн шилдэг сурах бичиг гэж хэлж болно. Номын философи нь хүн хоорондын харилцаа юм. Хэдий тухайн хүн чиний итгэлийг алдсан ч гэсэн уучилж, түүнд боломж олгож байх өгөөмөр сэтгэл хэрэгтэйг олон талаас нь тоглоомын аргаар тайлбарласан. Хүнийг хэзээд уучлах, бусдын сайн талыг тэргүүн зэрэгт тавих шаардлагатайг эл ном хэлдэг. Хүн болгон амар тайванг хүсэж, дэлхий ертөнц энх тайван, эв

найрамдлыг эрхэмлэж байна. Бид хамтран ажиллахын тулд хамтын нэг зорилготой байх ёстой гэсэн хамтач санааг дэвшүүлсэн.

Robert Axelrod нь АНУ-ын Мичиганы их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор. Улс төрийн шинжлэх ухаанд тоглоомын онолыг оруулж ирсэн эцэг гэж түүнийг тодорхойлдог. Америкт улс төрөөр Иелийн их сургууль, Мичиганы их сургууль нэгдүгээрт багтаж байна. Нийгмийн шинжлэх ухааны судалж байгаа хүн энэ номыг уншихгүйгээр судалгаа, шинжилгээ хийхэд бэрх болов уу. Байгалийн шинжлэх ухааны хүмүүс хүртэл сонирхож байна. Нийгмийн нийт баялгийн хуваарилалт шударга, боломж тэгш олгосон нийгмийг бүтээх цаг үед энэ ном багагүй зүйлийг хэлнэ. Миний хувьд энэхүү ном ертөнцийг харах цонх болсон.



Зүгээр сууж болохгүй юм байна

Б.Үржинханд /“Нууц товчоо” ХХК-ийн менежер/

-Ц.Оюунгэрэл эгчтэй анх хоёр жилийн өмнө танилцсан юм. Түүний гаргасан “Миний ажлын ноу хау” номыг уншсан. Хүн амьдралдаа бусдад хэрэгтэй хүн байхын тухайд бас хүн гэгч амьтан ямар их хүч нөөц бололцоотой юм бэ гэдгийг гайхалтай сайн тод томруун харуулсан байсан. Энэ номыг уншаад би зүгээр сууж болохгүй юм байна гэдгийг ойлгосон. Бас ажлын ард гарах, хийж буй ажлаасаа урам авах, үргэлж урагшаа тэмүүлж байх тэр их хүчийг олж авсан. Ажилгүй өвдөөд гэртээ байх цаг хугацааг хүртэл боломж болгон ашиглаж чаддаг байх тэр их чадвар. Хүн амьдралдаа нэг л зүйлийг хийж амьдарч болох ч юм юмыг хийж өөрийн хүчийг сорих нь бас сонирхолтой

юм. Мөн энэ номыг уншаад эх оронч байх үзлийг дахин өөртөө баталгаажуулж авсан. Гаднын хүмүүсийн хөлд нь сөгдөх биш харин түүх соёлоо гайхуулж бишрүүлж чаддаг байх хэрэгтэй юм байна билээ. Хүн ямар ч орчинд байж болно, бас юу ч тохиолдож болно, ямар ч нөхцөлд байсан тухайн цаг, тухайн орчиндоо өөрөө эзэн нь байж, өөрийн хүрээллийг бий болгож, үзэл бодлоо төлөвшүүлж, нийгэмд байр сууриа эзлэх тийм л чадвартай байх ёстойг ойлгож ухаарсан. Тэгэх ёстой, тийм байх нь зөв гэж хэлж ярихаас илүүтэйгээр тийм юм байна билээ, тэгсэн шүү, тийм юм мэдэрч ойлгож авсан гэх бодит амьдралын туршлага нь миний оюун ухаанд илүү ойр тусч, хүн ингэж ажиллаж байхад би юугаар дутах гэж гэсэн ойлголт авсан. ■



ТОД
ТАМГА
БИШИРТҮГЭЙ! АЮУТУГАЙ!



ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРТ!

Утас: 91919499, 323454 www.todtamga.mn

Хаяг: ЧД, Татварын Ерөнхий газрын ард

“ТОД ТАУЭР” оффис, 101 тоот

Утас: 98907234

САЛБАРУУД:

Баруун 4 зам

Зуун айл

Түгээмэл

Утас: 98626587 todtamga2@yahoo.com

Ута: 98907912 todtamga1@yahoo.com

Утас: 98630499 todtamga3@yahoo.com



www.mongolianeconomy.mn

 MONGOLIAN
ECONOMY